

**ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**  
*2026 оны 4 дүгээр сарын 15-ны өдөр, Лхагва гараг*

**Хуралдааны тэмдэглэлийн агуулга**

<b>Хуралдааны товч тэмдэглэл:</b>	1-4
<b>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</b>	5-49
<hr/>	
1.Байнгын хорооны тогтоолын төсөл /Ажлын хэсэг байгуулах тухай/	5-17
2.Орон нутгийн хөгжлийн сангийн 2024 оны бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүн, үр нөлөөнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан	17-33
3.Хүү, торгуулийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалтад хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан	33-39
4.Гадаад зээллэгийн ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлэх тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Н.Алтаншагай нарын 21 гишүүн 2025.12.12-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/	39-49

**Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы  
Төсвийн байнгын хорооны  
4 дүгээр сарын 15-ны өдөр /Лхагва гараг/-ийн  
хуралдааны товч тэмдэглэл**

Төсвийн байнгын хорооны дарга Н.Наранбаатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 29 гишүүнээс 15 гишүүн хүрэлцэн ирж, 51.7 хувийн ирцтэйгээр хуралдаан 9 цаг 54 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: Д.Үүрийнтуяа;  
Чөлөөтэй: Д.Батбаяр, Б.Түвшин, Г.Тэмүүлэн;  
Эмнэлгийн чөлөөтэй: Ж.Баясгалан, Х.Болормаа, Ж.Ганбаатар.

**Нэг.Байнгын хорооны тогтоолын төсөл /Ажлын хэсэг байгуулах тухай/**

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, зөвлөх Ё.Энхсайхан, референт Г.Нарантуяа, С.Төрмөнх, С.Тэгшжаргал нар байлцав.

Байнгын хорооны дарга Н.Наранбаатар Улсын Их Хурлын гишүүн Р.Батболдоос “Туулын хурдны зам төсөл”-ийн эдийн засгийн үр ашиг, техник, эдийн засгийн үндэслэл, төсөвт өртөгтэй холбоотой асуудлыг шалган судлах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах тухай албан бичиг ирүүлснийг танилцуулав.

Ажлын хэсэг байгуулах хүсэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Мөнхсоёл, П.Сайнзориг нарын тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн Р.Батболд, Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Г.Ганбаатар, Да.Цогтбаатар, Х.Булгантуяа, Н.Алтанхуяг нар үг хэлэв.

**Н.Наранбаатар:** Улсын Их Хурлын гишүүн Р.Батболдын гаргасан, “Туулын хурдны зам төсөл”-ийн эдийн засгийн үр ашиг, техник, эдийн засгийн үндэслэл, төсөвт өртөгтэй холбоотой асуудлыг шалган судлах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9  
Татгалзсан: 10  
Бүгд: 19  
47.4 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Дээрх санал хураалттай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Н.Алтанхуяг, Ж.Батсуурь, Г.Ганбаатар, Да.Цогтбаатар, Б.Мөнхсоёл, Ж.Батжаргал, Д.Энхтүвшин нар үг хэлэв.

*Уг асуудлыг 10 цаг 40 минутад хэлэлцэж дуусав.*

***Хоёр.Орон нутгийн хөгжлийн сангийн 2024 оны бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүн, үр нөлөөнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Ерөнхий аудитор С.Магнайсүрэн, Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр, мөн газрын аудитын менежер У.Батсүрэн нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, зөвлөх Ё.Энхсайхан, референт Г.Нарантуяа, С.Төрмөнх, С.Тэгшжаргал, Хяналт шалгалтын газрын ахлах зөвлөх Х.Энэбиш, ахлах мэргэжилтэн Д.Отгонбаатар нар байлцав.

Орон нутгийн хөгжлийн сангийн 2024 оны бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүн, үр нөлөөнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг Монгол Улсын Ерөнхий аудитор С.Магнайсүрэн танилцуулав.

Тайлантай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Заяабал, Ж.Батжаргал, Р.Батболд, Г.Ганбаатар, Б.Мөнхсоёл, П.Сайнзориг, П.Ганзориг, Д.Жаргалсайхан нарын тавьсан асуултад Төсвийн байнгын хорооны дарга Н.Наранбаатар, Монгол Улсын Ерөнхий аудитор С.Магнайсүрэн, Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал, П.Сайнзориг нар үг хэлэв.

Улсын Их Хурлын гишүүд Орон нутгийн хөгжлийн сангийн 2024 оны бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүн, үр нөлөөнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг хэлэлцэв.

*Уг асуудлыг 11 цаг 39 минутад хэлэлцэж дуусав.*

***Гурав.Хүү, торгуулийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалтад хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Ерөнхий аудитор С.Магнайсүрэн, Нийслэл дэх Төрийн аудитын газрын ахлах менежер Ч.Болд, мөн газрын ахлах аудитор Д.Дариймаа нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, зөвлөх Ё.Энхсайхан, референт Г.Нарантуяа, С.Төрмөнх, С.Тэгшжаргал, Хяналт шалгалтын газрын ахлах зөвлөх Х.Энэбиш, ахлах мэргэжилтэн Д.Отгонбаатар нар байлцав.

Хүү, торгуулийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалтад хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг Монгол Улсын Ерөнхий аудитор С.Магнайсүрэн танилцуулав.

Тайлантай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Да.Цогтбаатарын тавьсан асуултад Төсвийн байнгын хорооны дарга Н.Наранбаатар, Монгол Улсын Ерөнхий аудитор С.Магнайсүрэн нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал үг хэлэв.

Улсын Их Хурлын гишүүд Хүү, торгуулийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалтад хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг хэлэлцэв.

*Уг асуудлыг 12 цаг 00 минутад хэлэлцэж дуусав.*

***Дөрөв.Гадаад зээллэгийн ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлэх тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Н.Алтаншагай нарын 21 гишүүн 2025.12.12-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд З.Мэндсайхан, Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Ерэн-Өлзий, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Газрын тосны бодлогын газрын дарга Ч.Хишигдалай, Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, мөн яамны Өрийн удирдлагын хэлтсийн дарга Л.Гантогтох, Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Б.Ганзориг, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль тогтоомж, гэрээ, эрх зүйн газрын дарга М.Үнэнбат, мөн газрын Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Л.Эрдэнэбадрах, “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн Гэрээ, эрх зүйн газрын дарга У.Чинзориг, мөн компанийн Технологийн албаны дарга Б.Мөнх-Эрдэнэ нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, зөвлөх Ё.Энхсайхан, референт Г.Нарантуяа, С.Төрмөнх, С.Тэгшжаргал нар байлцав.

Байнгын хорооны дарга Н.Наранбаатар нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналыг хуулийн төсөлд нэмж тусган эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төслийг Улсын Их Хурлын гишүүдэд тараасныг танилцуулав.

Эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн хуулийн төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшин, Ж.Батжаргал, Л.Мөнхбаясгалан, Б.Мөнхсоёл, П.Мөнхтулга нарын тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ж.Алдаржавхлан, Сангийн сайд З.Мэндсайхан, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль тогтоомж, гэрээ, эрх зүйн газрын дарга М.Үнэнбат, мөн газрын Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Л.Эрдэнэбадрах, “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн Гэрээ, эрх зүйн газрын дарга У.Чинзориг нар хариулж, тайлбар хийв.

*Гадаад зээллэгийн ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлэх тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.*

**Н.Наранбаатар:** Ажлын хэсгийн гаргасан, Хуулийн төслийн 5 дугаар зүйлд дор дурдсан агуулгатай хэсэг нэмэх:

“5.4.дунд хугацаанд хэрэгжих төслийн орлогоороо хөрөнгө оруулалтын зардлаа бүрэн нөхөх боломжтой, эдийн засгийн үр ашиг бүхий хөгжлийн төсөл, арга хэмжээг нэгдсэн төсөвт нөлөө үзүүлэхгүйгээр санхүүжүүлэх чиглэлийг баримтална.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 5  
Татгалзсан: 13  
Бүгд: 18  
27.8 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Байнгын хорооноос гарах танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн П.Ганзориг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

*Уг асуудлыг 12 цаг 49 минутад хэлэлцэж дуусав.*

Байнгын хорооны хуралдаанаар 4 асуудал хэлэлцэв.

*Хуралдаан 2 цаг 55 минут үргэлжилж, ирвэл зохих 29 гишүүнээс 22 гишүүн хүрэлцэн ирж, 75.9 хувийн ирцтэйгээр 12 цаг 49 минутад өндөрлөв.*

**Тэмдэглэлтэй танилцсан:**  
ТӨСВИЙН БАЙНГЫН  
ХОРООНЫ ДАРГА

Н.НАРАНБААТАР

**Тэмдэглэл хөтөлсөн:**  
ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ  
ГАЗРЫН ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2026 оны 4 дүгээр сарын 15-ны өдөр,  
Лхагва гараг  
Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар” танхим  
9 цаг 54 минут.

### ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

**Н.Наранбаатар:** Эрхэм гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая. Байнгын хорооны гишүүдийн олонх нь хүрэлцэн ирж, ирц 51,7 хувьтай бүрдсэн тул Төсвийн байнгын хорооны 2026 оны 4 дүгээр сарын 15-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 7.8-д заасны дагуу хуралдааны ирцийг гишүүний сонгогдсон тойрог 8 нэрээр нь танилцуулна. Нанзадын Наранбаатар 7 дугаар тойрог, Жуковын Алдаржавхлан 12 дугаар тойрог, Тилеуханы Аубакир 3 дугаар тойрог, Ренчиндоржийн Батболд жагсаалт, Жигжидийн Батжаргал 5 дугаар тойрог, Жамбын Батсуурь жагсаалт, Гомбын Ганбаатар 7 дугаар тойрог, Пүрэвжавын Сайнзориг 11 дүгээр тойрог, Батжаргалын Заяабал 2 дугаар тойрог, Баатаржавын Мөнхсоёл жагсаалт, Загжавын Мэндсайхан 2 дугаар тойрог, Чинбатын Номин 11 дүгээр тойрог, Даваагийн Цогтбаатар 1 дүгээр тойрог, Баттогтохын Чойжилсүрэн 2 дугаар тойрог, Дашцэрэнгийн Энхтүвшин жагсаалт, Даваахүүгийн Пүрэвдаваа жагсаалт, нарын гишүүд, Булгантуяа гишүүн ирсэн байна. Хүрэлбаатарын Булгантуяа 8 дугаар тойрог нар Байнгын хорооны хуралдаандаа ирсэн байна.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. 1 дүгээр асуудал нь Ажлын хэсэг байгуулах тухай Байнгын хорооны тогтоолын төсөл. 2 дугаар асуудал нь Орон нутгийн хөгжлийн сангийн 2024 оны бүрдүүлэлт, зарцуулалт, үр нөлөөнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан. 3 дахь асуудал Хүү, торгуулийн орлогын бүрдүүлэлт зарцуулалтад хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан. 4 дэх асуудал Гадаадын зээллэгийн ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлэх тухай хуулийн төсөл Улсын Их Хурлын гишүүн Алтаншагай нарын 21 гишүүн 2025 оны 12 сарын 12-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг. Хэлэлцэх асуудлаар саналтай гишүүн байна уу? Саналтай гишүүн байхгүй бол хэлэлцэх асуудалдаа орно. Норовын Алтанхуяг гишүүн ирсэн байна. Ирц ингээд 58,6 хувьтай болсон байна. Хэлэлцэх асуудалдаа оръё.

#### ***Нэг.Байнгын хорооны тогтоолын төсөл /Ажлын хэсэг байгуулах тухай/***

Туулын хурдны зам төслийн эдийн засгийн үр ашиг, техник, эдийн засгийн үндэслэл /ТЭЗҮ/, төсөвт өртөгт хяналт шалгалт хийх үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах тухай Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэж эхэлье.

Төсвийн байнгын хорооны 2026 оны 4 дүгээр сарын 01-ний өдрийн хуралдаанаар Туулын хурдны зам төслийн эдийн засгийн үр ашиг, ТЭЗҮ, төсөвт өртөг, санхүүжилтийн эх үүсвэр, төсөвт үзүүлэх нөлөөлөл, мөн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахтай холбоотой мэдээллийг сонссонтой холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Батболдоос дээрх асуудлуудыг нарийвчлан судалж, холбогдох

санал, дүгнэлт гаргах зорилгоор Төсвийн байнгын хорооноос хяналт шалгалтын ажлын хэсэг байгуулж өгөхийг хүссэн албан тоотыг ирүүлсэн. Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлд Байнгын хороо өөрийн эрхлэх асуудлын хүрээнд тодорхой асуудлаар шалган судлах, холбогдох санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийг дангаар болон хамтран байгуулна. Мөн Улсын Их Хурлын гишүүн хяналт шалгалт явуулах саналыг өөрийн харьяалах Байнгын хороонд эрхлэх асуудлын хүрээнд гаргаж болох боловч, болох бөгөөд уг саналыг Байнгын хороо хэлэлцэж шийдвэр гаргана гэж заасны дагуу Батболд гишүүнээс гаргасан Ажлын хэсэг байгуулах хүсэлтийг хэлэлцэж шийдвэрлэсний дараа Ажлын хэсэг байгуулах тухай Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэнэ.

Дээрх асуудалтай холбогдуулан санал хэлэх Улсын Их Хурлын гишүүд байна уу? Алтанхуяг гишүүнээр, дарсан уу? Ирцдээ ор. Булгантуяа гишүүнээр тасаллаа. Ирцийн дарааллын дагуу Ганбаатар гишүүн санал хэлнэ.

**Г.Ганбаатар:** Өглөөний мэнд гишүүдээ. Энэ Туулын хурдны замын төсөвт өртөг, үр өгөөжийн талаар ингээд ажлын хэсэг байгуулахаар Төсвийн байнгын хороон дээр санал орж ирж байгаа нь нэг бодлын сайшаалтай, нөгөө бодлын их оройтож байна гэж бодож байгаа. Энэ асуудал уг нь өнгөрсөн наадмын үеэр нийслэлийн 1 дүгээр тойргийн замыг зам дээр Засгийн газар /ЗГ/-ын баталгаа гаргах асуудал Төсвийн байнгын хороогоор 2025 оны 7 дугаар сарын 9-ний орой 17 цагийн үед санал хураах үед би бас саналаа хэлж байсан. Ер нь яах вэ энэ Туулын хурдны зам түгжрэлийг бууруулахыг эсэргүүцэж байгаа юм байхгүй. Гэхдээ энэ төсөвт өртөг болоод дээрээс нь тэр Туул голын экосистемийн асуудал, мөн энэ Туул голтой холбоотой бусад энэ эрдэмтдийн байгаль орчны нөлөөллийн үнэлгээ гээд олон асуудал бүтэн бараг жилийн дараа ингээд дахин яригдаж эхэлж байна.

Хамгийн гол анхаарал татсан асуудал нь урьдчилаад тэр 500 гаруй тэрбум төгрөг шилжүүлчихсэн байгаа нь бас хар сэр дагуулахаар байгаа. Үүнтэй холбоотойгоор манай Байгаль орчны байнгын хороо уг нь Туулын хурдны замын тэр бусад асуудлууд байгаль орчин, байгаль орчны нөлөөллийн үнэлгээтэй холбоотой мэдээлэл авах үед Нийслэлийн Засаг дарга /НЗД/ мэдээлэл өгөхдөө Фидикийн silver нөхцөлөөр гэрээ байгуулсан гэж байгаа юм. Гэтэл тэр сийлбэр нөхцөл чинь хамгийн дээд тал нь нэг 10-аас 15, тодорхой заагаад үзсэн ер нь дунджаар 10 орчим хувь байдаг. Гэтэл урьдчилаад 22 хувийн урьдчилгаа өгчихсөн байгаа асуудал байгаа. Ер нь ямар тохиолдолд тэр урьдчилгааг өгдөг вэ гэдэг ялангуяа энэ ажлаа хурдан явуулах үүднээс банкнаас зээл авахынхаа оронд төсвөөс урьдчилж хүүтэй мөнгө авч болдог арга байдаг.

Гэхдээ хамгийн гол нь тэд юу яриагүй вэ гэхлээр урьдчилгаа төлбөрийг яагаад ийм өндөр өгөх болсон шалтгаанаа хэлээгүй бидэнд. 22 хувь гэдэг маш өндөр, жишээ нь дулааны станц ч юм уу турбин гээд зайлшгүй урьдчилж захиалдаг өндөр өртөгтэй, цементийн клинкер ч гэдэг юм уу өндөр өртөгтэй тохиолдол 10, 15 хүртэл өгдөг. Хамгийн их хар сэр дагуулж байгаа нь тэр 22 хувийн урьдчилгаа байгаа. Дээрээс нь урьдчилгаа төлбөр яагаад хийх болсон үндэслэл, мөн ажлаа бэлдэх, тог татах, үнэтэй тоног төхөөрөмж урьдчилж авах тухай тэр нийслэл дээр явсан протоколыг бид олж хараагүй. Нэн шаардлагатай ямар тоног төхөөрөмж авах гэж байгаа талаар гэрээ хийсэн тухай огт яригдаагүй. Энэ чинь фидикийн загвар гэдэг гэрээний загвар. Ямар нөхцөлөөр вэ гэдэг нь тэн дээрээ маш тодорхой тэр гэрээний загвар дээрээ байдаг. Харамсалтай нь нийслэлээс ерөөсөө энэ талаар

бидэнд мэдээлэл өгөөгүй учраас Улсын Их Хурлаас энэ ажлын хэсэг гаргаад ер нь ямар, ямар гэрээнүүд хийгдсэн юм, урьдчилгаа төлбөр.../минут дуусав/

**Н.Наранбаатар:** 1 минут нэмж өгье Ганбаатар гишүүнд.

**Г.Ганбаатар:** Дээрээс нь олон улсын инженерийн практикт нэг хамгийн дээд хувийг 15 хувийг л хамгийн эрүүл үзэгдэл гэж үздэг урьдчилгаа өгөхдөө. Тэгэхдээ тэр нь уурын жишээ нь дулааны цахилгаан станц байгуулахын тулд тэр турбин захидаг ч юм уу, тэгээд тэр урьдчилж гэрээнийхээ тоног төхөөрөмжийг хийгээд, ямар бэлтгэл ажлуудаа энэ том төсөл явуулахын тулд урьдчилж хийх ёстой энэ талын мэдээлэл ч өгөхгүй байгаа. Тийм учраас энэ дээр энэ ажлын хэсэг гарахыг дэмжиж байгаа. Ажлын хэсэгт орж ажиллах саналаа бас илэрхийлж байна.

**Н.Наранбаатар:** Мөнхсоёл гишүүн.

**Б.Мөнхсоёл:** Өглөөний мэнд хүргэе. Туулын хурдны замын төслийн энэ асуудал нийгэм даяар нэлээн тархсан, социал медиагаар ч гэсэн тодорхой хэмжээний мэдээлэл мөн иргэдийн дунд талцал хуваагдал энэ тэр явагдаж байна. Маш чухал асуудал. Ихээхэн хэмжээний төсвийн зарцуулалт хийгдэж байгаа учраас ХҮН намын зөвлөлөөс энэ ажлын хэсэг гараад ажилласан юм. Би өөрөө эдийн засгийн үр ашгийг тооцох ажлын хэсгийг ахалж ажилласан. Тэрэн дээр одоогийн байгаа 2,34 их наяд төгрөг маань эргээд энэ авто зам, замын барилга байгууламжийн өртгийг тооцох дүрмийнх нь дагуу тооцоод үзэхээр тухайлбал техник технологийн хяналтын зардлын 5 хувь ч гэдэг юм уу, гуравдагч буюу захиалагч этгээдийн хяналтын зардал 1 хувь энэ тэр гээд тооцогдоогүй зардлууд байна. Нэмээд энэ бид бүгдээрээ мэдэж байгаа мөнгөний үнэ цэн гэж байдаг, төсөвт өртөг, инфляц болон бусад ханш гэх мэт асуудлуудаас улбаалаад өртөг нэмэгдэх ийм байдал харагдаж байна. Ингээд тооцсоны үр дүнд зардал магадгүй 50-аас 60 хувь доод тал нь өсөх ийм магадлалтай байна шүү гэдэг тооцоог манай ажлын хэсэг гаргасан.

Тэгээд ямар ч байсан энэ төсөл дээр дахиж эргэж харах, Туулын голоор заавал дайрах албагүй байх энэ потенциал нөхцөл хувилбарыг судлах гээд маш олон ийм саналууд, зөвлөмжүүд гарч байгаа. Энэ дээр ажлын хэсэг үүсэх нь магадгүй зөв байх. Эсвэл одоо байгаа зүйлс, одоо зөндөө мэдээлэл гарчихсан юу байна тооцоо судалгаанууд байна. Тэгэхээр ажиллаж байна гэж цаг үрэлгүйгээр зүгээр мэдэгдэл юм хум дүгнэлт гаргах ёстой ч юм уу энэ дээр би эргэлзэж байна.

Манай Батболд гишүүний санаачилсан энэ ажлын хэсэгт орж байгаа бүх гишүүд энд алга байна. Тэгэхээр би энэ ажлын хэсгээ хэрхэн яаж ажиллах гэж байгаа вэ гэдэг талаар асуумаар байна. Ингээд товчхон дуусгачихъя.

**Н.Наранбаатар:** Ажлын хэсэгтэй холбоотой тогтоол дараа юм. Одоо бидний ярьж байгаа болохоор ажлын хэсэг байгуулах уу, үгүй юү гэдэг. Тэрний дараа нь, тэгвэл Батболд гишүүн хариулъя.

**Р.Батболд:** Сүүлийн үед яах вэ энэ Туулын хурдны замтай холбоотой асуудал маш их гараад байна байгаль орчин, өртөг зардалтай холбоотой. Тэгэхээр яах вэ бид Төсвийн байнгын хорооны хувьд энэ 2,34 их наяд гэж байгаа энэ их хэмжээний төсөв санхүүжилтийг яг үнэхээр зарцуулагдах ёстой юм уу, үгүй юү гэдэг тал дээр нь судалгаа хийе, харьцуулсан судалгаа хийж үзье. Мөн энийг гаргасан энэ

төсвийг гаргаад байгаа нийслэлтэй ярилцъя, ямархуу арга аргачлалаар ийм төсөв гаргачихсан юм гэдгийг үзэж хяная, шалгая гэдэг байдлаар энэ ажлын хэсгийг зохион байгуулах гэж байгаа. Тэгэхээр энийг яаралтай нэг тийш нь шийдсэн нь дээр байх. Зарим нэг мэдээллээр яг энэ өртөг маань өөрөө 30 дахин илүү биш, 30 хувиар илүү өртөгтэй байна гэдэг ийм тооцоо байгаад байгаа. Тэгэхээр энийгээ магадалъя гэдэг үүднээс ажлын хэсэг байгуулж байгаа, байгуулъя гэсэн санал гаргасан.

**Н.Наранбаатар:** Даваагийн Цогтбаатар гишүүн санал хэлнэ.

**Да.Цогтбаатар:** Та бүхэнд өглөөний мэнд хүргэе. Туулын хурдны замын төслийн эдийн засгийн үр ашиг, төсөвт өртөг, ТЭЗҮ-д хяналт тавих ажлын хэсэгт орж ажиллах саналаа өгсөн. Тэгээд энэ төсөл дээр байгаа нэрэн дотор бол нэр алга байна. Тэгээд албан ёсоор нэр оруулж өгөөч, зохион байгуулж өгөөч гэж энэ Төсвийн байнгын хорооны даргад хүсэлтээ илэрхийлж байна.

Яагаад гэхээр энэ чинь зөвхөн Туул гол дагаж байгаа маргаан дээр л асуудал үүсээд байгаа шүү дээ. Тэгээд Улаанбаатар өөрөө яг урагшаа энэ Туул гол дээр тавигдаж байгаа тэр хурдны зам гэж яриад байгаа зам руугаа орохын тулд бидэнд энэ Олимпын гүүр гээд нэг гүүр байна, Энхтайваны гүүр гээд нэг гүүр байна, тэгээд энэ Нарны зам дээр Нарны гүүр гээд нэг гүүр байгаа, тэгээд Гурвалжингийн гүүр. Энэ 4 гүүрээр урагшаа очоод шууд тэр хурдны зам руу чинь гарч чадах эсэх, тэгээд яг тэр Туулынхаа хурдны зам руу орчхоод түгжрэл чинь бас яаж буурах эсэх, тэгээд дэлхий даяараа эко ногоон гэдэг рүүгээ явж байхад манайх бүүр эсрэгээрээ яваад байгаа. Яагаад бид заавал Туул гол дээрээ Туулынхаа ар талын хөвөөг дагаад ч юм уу, урд талынхаа хөвөөг дагаж болохгүй яг гол дээрээ тавих гээд байгаа энэ асуудлуудад энэ эдийн засаг талаас нь, үр ашиг талаас нь, яг түгжрэлээ яаж бууруулж байгаа талаас нь орж ажиллах гэхээр ажлын хэсэгт нь оруулахгүй байна. Уг нь бол яг энэ ажлын хэсэг байгуулагдаж байна гэдэг энэ санал дотоод групп дээр бичигдэнгүүт нь саналаа өгсөн. Тэгээд ямар ч саналаа өгөөгүй байгаа гишүүдийг хүртэл нэмээд оруулчихсан. Ямар ашиг сонирхолтой юм.

Дээрээс нь энэ төсөв нь өөрөө 2,3 их наяд буюу бараг л улсын төсвийн 10 хувьтай тэнцэх хэмжээний мөнгийг түгжрэл бууруулах эсэх нь мэдэгдэхгүй, цаашдаа үнэ нь өсөх эсэх нь мэдэгдэхгүй ийм зам руу оруулж байгаа энэ асуудлыг хамгийн гол нь нээлттэй, ил тод байдлаар ярилцъя л гэдэг дээр саналаа байнга илэрхийлж явж байгаа. Тэрнээс энэ зам зөв, буруу гэдэг дээр ерөөсөө яриагүй. Гол нь бид эдийн засгийн үр өгөөжтэй байж чадах уу, байгаль орчиндоо ээлтэй байж чадах уу гээд. Өнгөрсөн хугацаанд барилга, хот байгуулалтын чиглэлээр, зам, тээврийн чиглэлээр нэлээн удирдах албан тушаалд ажиллаж байсан улсууд, ялангуяа энэ Монгол Ардын нам /МАН/-ын төлөөний удирдах албан тушаал хашиж байсан улсуудтай уулзахаар энийг эрс буруушаасан л ийм ярианууд өгч байна лээ. Тэгэхээр энийг яг нээлттэй, ил тод байдлаар ярилцъя л гэдэг ийм л санал байгаа юм.

**Н.Наранбаатар:** Сайнзориг гишүүн санал хэлнэ.

**П.Сайнзориг:** Яах вэ төсөл, хөтөлбөрүүдийг Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн дагуу тодорхой түвшинд шалгалт иргэд, олон нийтийн мэдээллээр хангах үйл ажиллагаа хийж болно. Энэ ч гэсэн яваад л байх шиг байна. Тэгэхдээ ер нь зүгээр яах вэ ажлын хэсэг гаргаж байгаа бол тийм субъектив байдлаар хандах хүнээр ахлуулмааргүй байна шулуухан л хэлье. Батболд гишүүн

санаачилж болно. Тэгэхдээ энэ дээр өөрөө хэт субъектив байгаа шүү дээ. Тэгэхээр Ардчилсан нам /АН/-ын Г.Ганбаатар гишүүнээр ч байдаг юм уу, арай бас нэг асуудал төвийг голчийг бариад явчих энэ хүнээр нь ахлуулчхаач гэж 1 дүгээрт хүсэлт байна.

2 дугаарт яах вэ нийслэлээс сонгогдсон гишүүдээс яагаад байдаггүй юм бол Батболд гишүүнээ? Энэ чинь нийслэлийн иргэдийн хувь заяаны асуудал байгаа байхгүй юу. Тэгээд ядаж санхүү төсвийн асуудал мэдлэгтэйгээр нь Булгантуяа даргыг оруулчхаасай гэж хүсэж байна. Би больё гэхэд, Хассуурийн Ганхуяг гишүүнээс бусдууд нь энд ингээд нийслэлээс сонгогдсон гишүүд ерөөсөө байхгүй шүү дээ. Та тэгэхээр санаачилж байгаа хүний хувьд энэ дээр боломжтой бол сольж болох юм уу, үгүй юу? Эсвэл манай бүлгийн дарга байж байна Батжаргал даргаас нэр өгөөд оруулж ирж болох юм уу, үгүй юу? Ийм байдлаар бас нэг анхаарал хандуулаач гэдэг ийм бодол байна.

Тэгээд яах вэ зүгээр мэдээж энэ дээр нь нэг зүйл байгаа. Уг нь бид хэдийн нөгөө аудитын сэдэв баталсан санагдаад байна өнгөрсөн жил. Аудитын сэдэв баталж байхад чинь Туулын хурдны замын бүтээн байгуулалтын үйл ажиллагаа дээр аудит хийх асуудал орсон санагдаад байгаа юм. Энэ үйл ажиллагаа ер нь хаана яваад, ямархуу үе шаттай явж байдаг юм, эсвэл энэ зүйлээ сонсож болдоггүй юм уу? Энэ чинь Улсын Их Хурлын хяналт шалгалтын нэг томоохон хэлбэр л байгаад байгаа шүү дээ аудит хийлгэнэ гэдэг чинь. Тэгэхээр энэ зүйлүүдтэй уялдуулж болохгүй юу л гэдэг ийм зүгээр 3 асуудал байна. Өөрөөр хэлбэл Батболд дарга санаачилж болно. Тэгэхдээ та өөрөө зүгээр боломжтой бол ойлголцоод, Гомбын Ганбаатар байдаг юм уу, АН-аас өөр хэн байна энэ гишүүдээр нь ингээд ахлуулчхаж болох юм уу, үгүй юү?

Энэ МАН-аас орж байгаа 3-аас ч байдаг юм уу, ядаж нийслэлээс Наранбаатар дарга сонгогдсон гишүүдээс хүмүүс оруулж өгөөч гэдэг л ийм байна. Нөгөө аудит хийлгэж байгаа асуудлаа уг нь сонсчихвол бараг энэ чинь л бидний нөгөө асуудлыг тодруулах гээд байгаа юм гараад ирэх юм биш үү? Энэ чинь манай Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд байгаа шүү дээ аудитын сэдэв дээр батлагдсан. Ийм 3 юмыг тодруулъя.

**Н.Наранбаатар:** Аудит дээр зөвлөх тайлбар өгье. Хэддүгээр микрофон бэ? Гандулам зөвлөхийн микрофоныг өгөөдхөөч.

**Б.Гандулам:** Та бүхний энэ өдрийн мэндийг хүргэе. Төсвийн байнгын хороо Гандулам. Сайнзориг гишүүний асуултад хариулъя. Төсвийн байнгын хорооны 2025 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн Байнгын хорооны тогтоолоор аудитын 2026 онд гүйцэтгэх аудитын сэдвийг баталсан байгаа. Тэр аудитын сэдвийн 9 дэх нь Туулын хурдны зам мега төслийн үр нөлөөтэй төлөвлөсөн байдал гэдэг аудит хийх аудитын сэдэв батлагдсан. Энэ аудитын сэдэв бол Байнгын хороон дээр тогтоолоор батлагдсан хугацаагаараа аудит гүйцэтгэх хугацаанд 2026 оны 01 сарын 5-наас 12 сарын 4-ний хугацаанд гүйцэтгэхээр ийм батлагдсан байгаа. Тийм учраас одоогоор аудит гүйцэтгэж байж аудитын тайлан Төсвийн байнгын хороо болон холбогдох байгууллагуудад ирэх хугацаа хараахан болоогүй байгаа.

**Н.Наранбаатар:** Бүрэлдэхүүнтэй холбоотой асуудал чинь дараагийн асуудал. Одоо бол зөвхөн ажлын хэсэг байгуулах шаардлагатай юу, үгүй юу гэдгээ

эхлээд хэлэлцэж дуусаад санал хураана. Тэрний дараа бүрэлдэхүүн орж ирнэ, тэндээ дахиад санал хураана. Булгантуяа гишүүн үг хэлнэ.

**Х.Булгантуяа:** Би одоо нэг ийм жишиг рүү орох гэж байгаа юм болов уу гэж бодож байна. Бид орон нутгийг аль болохоор бие даасан санхүүгээ авч явдаг байгаасай гэж хүсэж байгаа. Дээрээс нь нэмээд ялангуяа манай Дорноговь аймаг, Өмнөговь аймаг, Ховд аймаг төвлөрүүлдэг аймаг болж байна, Дархан, Эрдэнэт гээд ийм аймгууд, Сүхбаатар аймаг бас байгаа тийм ээ Батсуурь гишүүн бас улсын төсөвт тодорхой хэмжээний орлого төвлөрүүлдэг ийм аймгууд болж байгаа. Энэ зөв зүйтэй юм. Тэгээд эдгээр аймгууд нь өөрсдөөсөө олсон орлогыг, дээрээс нь ялангуяа манай Өмнөговь аймаг улсын төсөвт хамгийн ихээр төвлөрүүлдэг аймаг учраас ер нь улсын төсвөөс хамаг мөнгөө өгчхөөд, өөрснөө нэг ДЦС-ын мөнгө ч гэсэн улсын төсвөөс гуйгаад байхааргүй өөрснөө ирээдүйн орлогоороо бонд босгодог, санхүүгийн харилцаанд ордог байя гэдэг асуудлыг миний мэдэж байгаагаар сүүлийн 10 гаруй жил яриад, тэгээд үүнийг хамгийн эхлээд нийслэл Улаанбаатар хот эхлүүлж байгаа юм байна гэж би ойлгосон.

Энэ хурдны замынх нь нарийн тооцоолол энэ тэрийг нь би инженер хүн бишийн хувьд сайн мэдэхгүй байна. Гэхдээ нөгөө талдаа орон нутаг хэрвээ өөрөө төсөл хөтөлбөр хийе гэхэд нь Улсын Их Хурал /УИХ/ дээр бүгдээрээ нутгийн өөрөө удирдах байгууллагын эрхэд нь халдаад, төсвийн тухай харилцаагаар тэртээ тэргүй явж байгаа юмыг нь энд авчирч ирж хэлэлцэх гэж, хэлэлцдэг болох гэж байгаа юм уу? Тэгвэл Өмнөговь аймаг, Дорноговь аймаг гээд энэ том аймгуудын хувьд санхүүгийн хувьд тэгвэл эд нар бие даах хүсэл сонирхол их бага болох болов уу гэж би харж байгаа юм. Бид уг нь аль болохоор өөрснөө орлогоо олоод, өөрснөө зарлагаа нөхөөд явдаг байхыг уриалаад байгаа шүү дээ. Манай Төсвийн байнгын хорооны дарга өөрөө Өмнөговь аймгаас сонгогдсон Улсын Их Хурлын гишүүний хувьд говийн бүсээс сонгогдсон сайн мэдэж байгаа. Тэгэхээр 1 дүгээрт энэ харилцаа руу нь бид нутгийн өөрөө удирдах байгууллага бодвол энд чинь бас аудит, нийслэл чинь өөрөө нийслэлийн аудиттай, нийслэлийн бараг бүхий л байгууллагын бүтэц байдаг. Тэгэхээр энэ юмнуудаараа орсон байлгүй дээ. Дээрээс нь нэмээд Зам, тээврийн хөгжлийн төв, тэгээд Зам, тээврийн хөгжлийн төв гээд ингээд эд нарыг нь хянадаг байгууллагуудаар хянагдсан байлгүй дээ. Эдгээр байгууллагуудаас нь давж бүгдээрээ нарийн, бүүр нарийн инженерчлэлийн дүгнэлт хийх гэж байгаа юм уу, бүүр замын нарийн мэргэжлийн эдийн засгийн өгөөжийн?

2 дугаарт нь яг эдийн засгийн үр өгөөж яривал жишээлбэл би энэ хэлэлцээрт өөрөө орж байсан хүний хувьд сайн мэдэж байгаа юм. Дарханы замыг гэхэд бид Европын сэргээн босголт, хөгжлийн банк /ЕСБХБ/-аас бид хоёрхон урсгалтай байна гээд ганцхан зам байж болохгүй байна, аюулгүй байдлаасаа 2 эгнээтэй ийм 2 зам байх хэрэгтэй байна гээд энэ хэлэлцээрийг хийж байхад Азийн хөгжлийн банк /АХБ/, олон улсын байгууллагууд эдийн засгийн үр өгөөжийг нь тооцоод энэ бол эдийн засгийн хувьд ашиггүй байна, санхүүжүүлмээргүй байна гэж хэлж байсан. Тухайн үед бид юу гэж хэлж байсан бэ гэхээр тийм ээ магадгүй энүүгээр тээвэрлэж байгаа ачаа энэ тэрийн хувьд эдийн засгийн үр өгөөж бага байж магадгүй. Гэхдээ энэ Монголчуудын хувьд аюулгүй байдлын асуудал болчихоод байгаа юм гэж байж бид үүний санхүүжилтийг олж авч байсан юм. Тэгэхээр өөрөө энэ эдийн засгийн үр өгөөж гэдгээ нэг сайн хараарай.

3 дугаарт Батболд гишүүнээ би таныг нийслэл Улаанбаатар хотоор явж түгжрэлийн асуудлаар иргэдтэй уулзсан гэж би ерөөсөө мэдэхгүй байна. Би таныг

аль нэг тойрог дээр, нийслэлийн дүүрэг дээр очиж ард түмний саналыг авсныг би мэдэхгүй байна. Харин өнөөдөр энд сууж байгаа Сайнзориг гишүүн, би гээд манай нийслэл Улаанбаатар хотоос сонгогдсон гишүүд бид 2028 онд энэ 4 жилийн хугацаанд нийслэл Улаанбаатар хотын хамгийн тулгамдсан асуудлын нэг түгжрэлийг бууруулахад юу хийсэн бэ гэдэг асуултад бид хариулт өгнө. Та тэр асуудлыг авч гарах гэж байгаа юм уу тэгвэл? Нийслэл Улаанбаатар хотод хэдхэн маш том асуудал байгаад байгаа юм. Энэ нийгэм, эдийн засгийн хувьд маш том үр дагавартай байгаа юм. Тэгэхээр би та энэ хувь хүнийхээ хувьд 28 онд та нийслэл Улаанбаатар хотын түгжрэлийн асуудлыг та хариуцах уу? Та тийм саналыг авсан юм уу би энэ төсөл хөтөлбөрийг хариуцна гэж? Бид очиж хариулна. Би өөрийнхөө 270 мянган сонгогчдод манай Баянзүрх.../минут дуусав/

**Н.Наранбаатар:** Алтанхуяг гишүүн санал хэлнэ.

**Н.Алтанхуяг:** Өглөөний амгаланг айлтгая. Энэ Ажлын хэсэг байгуулах нь зөв зүйтэй юм. Манай Их Хурал чинь бол олон нийтийн мэдэх эрхийг хангах ийм бас нэг давхар үүрэг байгаа шүү дээ. Тэгэхээр энэ ажлын хэсгээ байгуулаад, энэ Туулын хурдны зам гэдэг маань ер нь юу болчихоод байгаа юм гэдгийг олон нийтэд мэдээлэх нь зөв. Ер нь энэ олон нийтэд мэдээлэл өгөхгүй, дээр нь мэргэжлийн хүмүүсийн үгийг сонсохгүйгээр баахан юм оруулж ирээд л Их Хурал ч юм уу, эсвэл бие даасан манай нийслэл бие даасан мөнгөтэй ч гэнэ үү тийм юм хэлээд хийгээд байдаг их буруу. Дээр нь энэ чинь зүгээр нэг мөнгөний тухай яриагүй 2,3 их наяд төгрөгийн төсөвтэй болчихсон явж байгаа байхгүй юу. Тэгээд трасс нь яагаад. Энэ 13 онд ингэсэн юм 13 байх, би мартчихаж дээ. 13 онд Гудамж төсөл гэж байхдаа энэ Туулын хурдны зам гэдэг юмыг тэр үед нь хийчихвэл, тэгэхдээ энэ Туулын хойд талын эрэг шүү, Туулын хойд талын эргээр нь ингээд нэвт явуулаад ингээд хийчихвэл энэ Улаанбаатарын түгжрэл ер нь их зөв стратегийн хувьд зөв болох байна, 13 жилийн өмнөх юм би ярьж байна шүү. Ингэж нэг зураг гаргаад явж байсан юм, тэгээд тэр үеийн төсөвт өртгийг нь би сүүлд нэг харахад 500 орчим тэрбум төгрөг байсан юм байна лээ.

2 дугаарт нь трасс нь бол одоо тэр хэлээд байгаа 1км орчим л нөгөө усан дээгүүр гарах тийм юм байсан юм байна лээ. Одоо 7км явна гээд байгаа шүү дээ тэр усан дээгүүрээ гэх мэтчилэн ийм, ийм ойлгомжгүй юм болчихсон учраас энэ ажлын хэсгийг байгуулаад ажиллаж байгаа нь зөв байна. Хэн нь ахалдаг юм бэ нэг нь ахлаад олигтойхон шиг ажиллаад өгөөрэй. Би сая босоод Ганбаатар гишүүнийг ахлаач, энэ АН-ын бүлгээс ахалчихвал арай дээр юм биш үү гэж хэлсэн. Ганбаатар маань үгүй гээд тэгж байх юм. Уг нь энэ тэгчихвэл зүгээр. Батболд би нөгөө нэг АН-ын бүлэг ахалчихвал жаахан серъёзны ажиллаж магадгүй.

Ийм 2, 3 юм тодруулмаар байгаа юм. Трассыг яагаад өөрчилчхөөд байгаа юм бэ? Яах вэ энэ дотор байна л даа. Би тэр ТЭЗҮ Гэдэг дотор нь явж байгаа юм байна. Төсөвт өртөг нь яагаад 4 дахин нэмэгдчихээд байгаа юм бэ? Дараагаар нь арван хэдэн жилийн дараа гэж хэлэх байх л даа, арван хэдэн жилийн дараа төсөвт өртөг ингэж өөрчлөгдөхгүй л дээ. Тэгэхээр энэ дээр тайлбар өгөх хэрэгтэй. Тэгээд нийслэл бас дахиад асар их мөнгөтэй байгууллага болжээ. Өчнөөн бонд босгож байна энэ чинь бас зээл шүү дээ. Тэгээд энэ их мөнгөөр юу хийгээд байгаа юм бэ?

Дахиад дэлхий дээр байдаггүй нэг юм бид хийчихсэн юм шиг байна лээ. Энэ манай нийслэл яахлаараа нүүрсний уурхайтай байдаг юм бэ? Энэ хаанахын, ямар гээчийн юм байдаг юм бэ? Ингээд энэ орон нутгийн төсөв мөнгө олдог арга бүх юм

бол жаахан дампуурч яваа юм биш үү? Ийм юм ер нь дэлхий дээр байхгүй шүү дээ. Тэгэхээр би энэ ажлын хэсэг байгуулахыг дэмжиж байна. Харин оръё гэсэн гишүүдийг нь оруулаад, жаахан өргөтгөөд явмаар байна.

Өөр нэг юм хэлчихмээр байна Наранбаатар даргаа. Иймэрхүү хяналт шалгалтынхаа юмыг энэ цөөнхөөр ахлуулаад, цөөнхийнхөө гишүүдийг жаахан олон болгочихмоор байна, олонх болгочихмоор байна. Ингэвэл нэг жаахан бодитой юм болно. Одоо бид хэчнээн хяналт шалгалт хийв, Их Хурал даяар л өчнөөн л юм ярьдаг, өчнөөн л хүн оруулж ирдэг, байцаадаг, мөрддөг, тэгээд ямар үр дүн гарсан юм бэ? Хамгийн сүүлд Оюутолгой /ОТ/ хийлээ, үгүй ээ хэдэн өдөр баахан шүлсээ үсэргэж ярилаа, баахан юм боллоо. Тэгээд ОТ-н гэрээнд өөрчлөлт оруулахгүй юм бол ярьсны хэрэг юу байх юм бэ? Өдөр болгон 13 тэрбум төгрөг, 14 тэрбум төгрөг өнөөдөр сонголын дараа алдаад байвал бас энэний үүрэг хариуцлага ер нь юу байх юм бэ? Нэг ийм дайчин давшингуй ерөөсөө нэг ажиллаж өгөхгүй юм. Би өнөөдөр зориуд нэг цаг хоцорч ирлээ. Зориуд, хоцрох юу байх вэ өрөөндөө сууж байгаад ирлээ. Өчигдөр би Байнгын хорооны хурал Хууль зүйг 2 цаг хүлээлээ. Үгүй ээ ингэж яаж ажиллах юм бэ нөхөд минь. Энэ бас нэг шүүмжлэл яваад байгаа шүү дээ. Бидний ийм нэг жижиг сажиг юмнаас болоод хүмүүсийн итгэл алдраад байна шүү дээ. Цагтаа цуглаад хурдан.../минут дуусав/

**Н.Наранбаатар:** Алтанхуяг гишүүн 3, 4 зүйл асуусан юм. Тэр нь нөгөө өмнөх Байнгын хорооны хурал дээр НЗД, орлогч нар ирээд асуулт, хариулт яваад, мэдээллээ хийгээд дуусчихсан юм. Өнөөдөр зөвхөн ажлын хэсэг байгуулах уу, үгүй юү гээд. Тэгээд байгуулагдахаар бол цаашаа нэлээн асуултууд явах байх. 2-т нь, дараагийн асуудал дээр яаж болно. 2-т нь болохоор Дэгийн хууль дээр ийм юм байгаад байгаа юм. Ажлын хэсэг Байнгын хорооноос байгуулахдаа олонх, цөөнхийн харьцааг харгалзаж байгуулна гээд Дэгийн хуулиа л бид дагаж явахаас өөр аргагүй л болчихоод байгаа юм.

Гишүүд үг хэлж дууслаа. Санал хураалт явагдана ажлын хэсэг байгуулах уу, үгүй юу гэдэг дээр эхлээд. Дараа нь ажлын хэсэг дээрээ ярих юм.

Би Улсын Их Хурлын гишүүн Батболдоос гаргасан Туулын хурдны зам төслийн эдийн засгийн үр ашиг, ТЭЗҮ, төсөвт өртөгтэй холбоотой асуудлыг шалган судлах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах саналыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулна. Гишүүд санал хураалтдаа бэлдээрэй. Гишүүд бэлдчихсэн үү? Энэ дээрээс яаж харагдаад байна вэ. Дэмжье гэсэн Ажлын хэсэг байгуулахыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт. Санал хураалтад 19 гишүүн оролцсоноос 9 гишүүн дэмжиж, 47,4 хувиар дэмжигдсэнгүй. Алтанхуяг гишүүн горимын санал хэлье.

**Н.Алтанхуяг:** Энэ эсвэл энэ Ардын нам та нар ингээд ажлаа хий. Энэ ард түмний хүсэл сонирхлын дагуу ажлын хэсэг байгуулъя, хянан шалгая гэхээр зэрэг тэгье гэж нэг худлаа царайлж оруулж ирснээ олонх нураагаад унагаачихдаг. Тэгвэл үхсэнээ хийж биднийг энд суулгаж байдаг юм. Та нар тэгвэл ажлаа хийцгээ, тийм. Бид ямар ч хэрэггүй юм байна шүү дээ. Үгүй ээ та нарыг чинь нэг овоо ажлын хэсэг байгуулах юм байна гээд их мундаг идэвхтэй орсон чинь 19-өөр унагаагаад хаячхаад май гэдэг, ингэдгээ боливол яасан юм бэ? Эсвэл танай Ардын намынхан гишүүдээ оруулж ирээд саяынхыг дахиж хураа. Эсвэл ард түмэнд гараад хэл бид энийг хянаж шалгах сонирхол алга гэдгээ хэл. Ямар гээч нь ийм хачин улс байдаг байна.

**Н.Наранбаатар:** Батсуурь гишүүн горимын санал зөвхөн гаргах хэрэгтэй.

**Ж.Батсуурь:** Бүгдэд нь өдрийн мэнд хүргэе. Эрх баригчид сүүлийн үед арай дэндэж байна. Ер нь болж бүтэхгүй юм нийгмээр дүүрэн байна. Тэгээд тэрийг шалгая ярья гээд тэгэнгүүт ерөөсөө тэр болгоныг олонхоороо нухчин дарж байна. Түрүүн Их Хурал дээр Харбины гэрээ унасан. Тэгээд оффтейк гэрээнүүдийг шалгах асуудлууд бүгд унадаг. Түр хороо байгуулъя гэнгүүт өөрсдийг нь шалгах, өөрсдийнх нь асуудлыг олон нийтэд мэдээлэл өгөх асуудал дээр бас унагадаг. Тэгээд өнөөдөр нийгэмд хамгийн бухимдалтай байгаа зүйлийг ажлын хэсэг гэдэг чинь шууд анхнаасаа буруу гэж хэлэх гэж байгаа зүйл биш шүү дээ. Зөвийг нь зөвөөр нь, бурууг нь буруугаар нь хэн сайн ажиллаж байна вэ, хэн нь муу ажиллаж байна вэ, ямар тооцоотой байгаа юм, олон улс дэлхий нийтийн жишиг нь ямар байгаа юм, одоо Монголд бүрдэж байгаа байдал нь ямар байгаа юм энэ асуудлыг л шийдэх гэж байгаа шүү дээ. Ингэвэл танай ер нь Байнгын хороонууд чинь ч явахгүй байгаа, Их Хурал чинь ч явахгүй байгаа. Иймэрхүү маягаар байвал энэний дараагийн асуудалд бид оролцохгүй, ирцээс хасаад аль.

Өнөөдөр та нар 9 цагаас авхуулаад цаг гаруй хүлээлгэжээд, цаг гаруй хүлээлгэжээд эхний асуудлуудаа ингэдэг энэ бол та нарын гэм биш зан. Дандаа гуйлгачин царайлаад ирцээ бүрдүүлүүлнэ, тэгээд өөрсдийнхөө асуудлуудыг эхэнд тавьж асуудлуудаа шийдүүлнэ. Тэгээд өрөөлийн буюу нийтийн эрх ашгийн.../үг тасрав/

**Н.Наранбаатар:** Батсуурь гишүүнээ горимын саналаа гаргах юм уу, үгүй юм уу?

**Ж.Батсуурь:** Байж бай, байж бай би үгээ дуусгаадахъя.

**Н.Наранбаатар:** Горимын саналтай холбоотой л хэлнэ.

**Ж.Батсуурь:** Байж бай горимын саналаа хэлж байна.

**Н.Наранбаатар:** Дараа нь өөр санал гаргах хүн байна уу?

**Ж.Батсуурь:** Нийтэд хамааралтай.../үг тасрав/

**Н.Наранбаатар:** Горимын санал шүү, горимын санал шүү.

**Ж.Батсуурь:** Нийтэд хамааралтай, ард түмэнд хамааралтай энэ асуудлуудыг ярингуут.../үг тасрав/

**Н.Наранбаатар:** Горимын санал хэлэх ёстой, үгүй ээ харин горимын санал хэлэх ёстой шүү дээ, Дэгээрээ явах ёстой. Дэгээрээ явах ёстой.

**Ж.Батсуурь:** Та нар ингэж маяглаад байвал үдээс хойш энэ Төрийн байгуулалтын байнгын, энэ Төсвийн байнгын хороо чинь явахгүй шүү. Наранбаатараа чи үг хэлүүлэхгүй иймэрхүү маягаар асуудалд хандвал та нар өөрсдөө ирцээ бүрдүүлж чадахгүй, бид наргүйгээр явж чадахгүй.

**Н.Наранбаатар:** Би дэгээрээ явах ёстой л гэж хэлж байна шүү дээ. Би дэгээрээ явах ёстой, би хурал даргалагч хуулиа сахиулах үүрэгтэй шүү дээ. Таны горимын санал чинь юу юм бэ л гэж байна. Горимын саналаа хэлчихье, Батсуурь гишүүн горимын санал.

**Ж.Батсуурь:** Горимын санал хэлж байна шүү дээ. Та нар ямар учиртай юм бэ? Энэ парламент 24 оноос хойш юу хэлэлцсэн юм бэ? Тэгээд өнөөдөр бужигнаж, бужигнаж дөнгөж нэг асуудал эхлэх болохлоор хүлээлгэж, хүлээлгэж нэг юм ирцээ бид нараар бүрдүүлнэ, хүний гараар могой бариулна, тэгээд энэ горимын санал биш ямар санал юм бэ, энийг горимын санал гэхгүй ямар санал гэх юм бэ? Та нар ирцээ бүрдүүлж чадахгүй байна, ажил чинь явахгүй байна, ажлыг чинь явуулаад, ирцийг чинь бүрдүүлээд, асуудлыг чинь шийдье гээд өгөхлөөр өөрсдийг нь шалгах, ард түмний мэдэх эрх, бусдын мэдэх эрх, буруу, зөвийг нь ялгах ажлын хэсэг гэнгүүт л шууд байхгүй болгож байдаг. Өөрсдөө муудахаа болохлоор бие биеийнхээ хулгай зэлгий, худал, үнэн, авсан, өгсөн бичиг баримттайгаа ярьдаг. Тэврэлдэхлээрээ асуудлыг нь шийдье ярья гээд тэгэнгүүт ингээд ажлын хэсэг байгуулуулахгүй. Энд болохгүй юм юу байгаа юм бэ? Батболд, Ганбаатар, Ганзориг, Ганхуяг, Заяабал, Тэмүүлэн, Үүрийнтуяа ингээд танайхаас зөндөө л хүмүүс байна шүү дээ. Ажлын хэсэг чинь буруу зөрүү гаргана гэвэл танай намынх олонх байна шүү дээ. Ажлын хэсэг байгуулна гэдэг чинь бүгдийг буруу болгоод хаячихна гэсэн үг огт биш байхгүй юу. Тэнд ямар зүйл байна гэдгийг ард түмэнд мэдэх эрхийг л өгч байгаа. Тэр Харбины гэрээн дээр та яаж байна вэ, ингэж болохгүй.

**Н.Наранбаатар:** Горимын санал нь юу вэ?

**Ж.Батсуурь:** Дахиж, горимын санал дахиж хураагаад байх. Дахиж хураагаадах энэ ажлын хэсгээ байгуулах.

**Н.Наранбаатар:** Горимын санал, Батсуурь гишүүн горимын санал гаргасан. Ганбаатар гишүүн, дахиж хураах горимын санал гаргачихсан шүү.

**Г.Ганбаатар:** Ингэж болохгүй, Наранбаатар дарга та зүгээр нэг ажлын хэсэг байгуулъя гэсний төлөө нэг ийм хандлагаар хандаж болохгүй шүү дээ. Нээрээ ний нуугүй хэлэхэд сая Батсуурь гишүүн үнэн л ярьж байна шүү дээ, Алтанхуяг дарга ч гэсэн үнэн л ярьж байна шүү дээ. Харбины гэрээг яасан та нар зүгээр л иргэдийн сонсох тэр янз бүрийн ойлголттой байгаа бол тэрийг нь залруулаад өгье л гэсэн, олонхоороо түрүү барьсан. Сая зүгээр нэг Туул голын хурдны зам дээр энэ ер нь юу болоод байгаа юм бэ Ажлын хэсэг байгуулъя гэхэд одоо хар даа ажлын хэсэг чинь ингээд Батболд, Ганбаатар, Ганзориг, Ганхуяг, Заяабал, Тэмүүлэн, Үүрийнтуяа 7 хүний чинь 4 нь танай намаас байж байна. Дөнгөж сая миний хажууд сууж байгаа Заяабал гишүүн зөвшөөрсөн дээр дарах гэж байхад нь амжаагүй юуг нь хураачихлаа. Ажлын хэсэгт орсон Ганзориг гишүүн сая орж ирж байна. Ийм байдлаар та нар ингээд явж болохгүй шүү. Энэ чинь иргэдийн сонсох, иргэдийн мэдэх эрхийг ингэж боомилж болохгүй шүү.

Ер нь энэ парламент гэдэг чинь ард иргэдийн төлөөллийг хангаж байх ёстой байгууллага шүү дээ. Иймэрхүү маягаар та нар тэгээд ичихгүй ингээд сууж байдаг. Дахиж санал хураалгая. Дээрээс нь ирцээ ахиж бүрдүүлье. Дээрээс нь энэ чинь хар даа ажлын хэсэгт орох 7 хүнээс чинь 4 нь танай намаас байж байна. Ахиад тэр дотор чинь ахиад 2 нь Ганзориг гишүүн сая орж ирж байна. Тэгээд ийм байдлаар ингээд явбал Төсвийн байнгын хороо цаашдаа хуралдаж чадахгүй шүү. Ер нь яг ний нуугүй

хэлэхэд энэ Туулын хурдны зам чинь төсөвт өртөг нь хэт өндөр байна гэдгийг эдийн засагчид яриад байна. Тендерт ялсан компани нь хулхи байна гээд яриад байна. Тэр битгий хэл ХҮН намын зөвлөл хуралдаад энэ чинь урьд ижил төстэй юутай харьцуулахад 4 дахин өндөр байна гээд яриад байгаа шүү дээ. Үгүй ээ тэгвэл 4 дахин өндөр байг больё доо, 50 хувь өндөр байлаа гэхэд тэр хэл ам болоод байгаа боловсролынхоо салбар чинь 1,2 их наяд л дутаад байгаа юм байна лээ шүү дээ бүх эмч нарын цалинг нэмэхэд. Үгүй ээ тэгээд иймэрхүү юман дээр бид иргэдийнхээ мэдэх эрхийг боомлоод байх юм уу, бас парламентын гишүүдийн эрхэд халдаад байх юм уу, боль л доо та нар.

**Н.Наранбаатар:** Батсуурь гишүүнийг ирцээс хасъя, өөрөө хүсэлт гаргасан, Алтанхуяг гишүүнийг хасъя. Горимын санал Мөнхсоёл гишүүн. Энхтүвшин гишүүнийг ирцээс хасъя. Цогтбаатар гишүүн горимын санал. Дараалаад л хэлчихье.

**Да.Цогтбаатар:** Энэ бидний энэ хурал гэж нэрлээд байгаа энэ зүйлийг иргэд харж байгаа байх. Тийм учраас хэлье гэж бодож байгаа юм. Харбины гэрээг нээлттэй, ил тод л ярья гэсэн юм. Тэгсэн чинь бүгдээрээ нийлж байгаад унагаачхаж байгаа юм. Энэ ил тод байдал, хариуцлагатай байдал юу ч байхгүй байгаа юм. Тэгээд энэ Туулын хурдны зам дээр 2,3 их наядын асуудлыг зөвхөн Монголд зориулж байгуулсан компани дээр ямар ч даатгал, олон улсын даатгал энэ ажил яг цагтаа, яг дүндээ багтааж хийгдэнэ гэсэн даатгалын тогтолцоо ажиллаагүй юман дээр, энэ асуудал дээр нь нээлттэй хэлэлцүүлэг хийе, ил тод байя, хариуцлагатай байя гэхээр бүгдийг нь нөгөө улаан намын цагаан байрны дарангуйлагч хулгайчид чинь ингээд бүгдийг нь хаачхаж байгаа нөхцөл байдал энэ шүү гэдгийг 1 дүгээрт энэ мэдээллийн шинж чанартай энийг үзэж байгаа хүмүүст хэлж байгаа юм.

2 дугаарт нь Энхтүвшин гишүүн хүртэл уг нь энэ Туулын хурдны замын асуудал яригдаж байхад маш зоригтойгоор эсэргүүцээд, шүүмжлээд, ил тод ярья гэж байсан хүн нь хүртэл одоо ингээд ямар байдлаар Энхтүвшин гишүүнд нөлөөлсөн юм бүү мэд, одоо больё гэхихсэн сууж байна. Уг нь бид бүгдээрээ ил тод ярья л гэж байгаа юм. Монголд дөнгөж шинээр байгуулагдсан компани 2,3 их наяд төгрөгийн тендер авч болдог юм бол 3 сая 600 мянган хүн бүгдээрээ компани байгуулаад энэ хэмжээний, больё 2, 2 тэрбум төгрөгийн тендер авъя л даа. Яагаад энийг ил тод ярихгүй байгаа юм бэ? Тэгээд ил тод ярья гэхээр гуйж, гуйж ирцээ байгуулчхаад, нэг худлаа тоглоомын цаас оруулж ирээд нэг ийм ирц дээр нь, энэ ажлын хэсэг дээр нь нэг худлаа нэр уншиж нэг баахан чулуу хөөлгөж байснаа унагаачихдаг шүү дээ. Ийм байж болохгүй биз дээ? Бид жоохон ажил хэрэгч, энэ хуралдаанд чинь бүгдээрээ Улсын Их Хурлын гишүүд нь хариуцлагатай байя, ёс зүйтэй байя, хуралдаандаа бүгдээрээ оролцъё гээд байсан, оролцъё гээд ороод ирэхээр зүгээр хулгай хийчхэж байгаа байхгүй юу. 2,3 их наядын Туулын хурдны зам бол яг шударгаар хэлэхэд хулгай.

Тэгээд энийг нийслэлийнх нь иргэд талбай дээр гарч ирээд эсэргүүцээд яриад байхад, хэлэлцүүлээд өг л гэж байгаа юм, ил тод яриад өг гэж байгаа юм. Тэгээд ил тод яриад өг гэдгийг нь яагаад хаагаад байгаа юм бэ? Иргэд чинь мэдэх эрхгүй юм бол иргэдээр яадаг юм. Бүгдээрээ МАН-ынхан энэ цагаан байрандаа очиж сууж байгаад хамаг асуудлуудаа шийдээд явчихмаар байна Наранбаатар даргаа. Одоо Төсвийн байнгын хорооны хурал ч гэсэн хурал биш боллоо. Энэ санал хураалтаа хүчингүй болгохгүй юм бол Төсвийн байнгын хорооны өнөөдрийн хуралдааны ирцээс бас намайг хасаж өгнө үү. Уг нь энэний дараагийн асуудал дээр бид Орон нутгийн хөгжлийн сангаар үе үед хийгдсэн хулгайг дахиад ярья гээд энэ хулгай дээр

нь маш их олон асуудал байгаа, маш их хариуцлагагүй байдал байгаа. Ингээд ярьж гэхээр бүгдээрээ хүч түрээд явчихдаг, ямар ч хариуцлага хүлээдэггүй. Улаан нам буюу МАН цагаан байрны хулгайчууд сүүлийн 10 жил хийсэн хулгайгаа л нуух гэж байгаа нэг ийм хуралдааны бид хэрэгсэл болмооргүй байна. Ил тод яриад, хариуцлага нэхээд, иргэддээ мэдээллийг нь өгч чадахгүй юм бол энд суух хэрэг алга.

**Н.Наранбаатар:** Мөнхсоёл гишүүн горимын санал.

**Б.Мөнхсоёл:** Ер нь байдал ингээд нөгөө эмх цэгцгүй, зохион байгуулалт муутайгаас болоод жоохон буруу эргэчихлээ шүү дээ. Сая манай Цогтбаатар гишүүн маань буруу хэлчихлээ. Энхтүвшин гишүүн дэмжиж саналаа өгсөн байна шүү. Би бас түрүүн хэлсэн ХҮН намын зөвлөлийнхөн энэ асуудал дээр бүүр анхнаас нь оролцсон, маш олон бичгүүдийг тодорхой холбогдох байгууллагууд, дарга нарт нь явуулсан, мэдээ мэдээлэл хүссэн. Тэгэхдээ одоо бэлэн байгаа мэдээллүүд дээр судалгаа хийгээд, эдийн засгийн янз бүрийн тооцоо томъёоллуудаа ашиглаад бид дүгнэлтээ гаргаад хэлчихсэн юм, хэвлэлийнхэнд, нийтэд зарлачихсан юм. Энэ эдийн засгийн хувьд үр ашиггүй байна, байгаль экологийн асуудал л байна, түгжрэлийг зорьсон хэмжээндээ 30 хувь биш, магадгүй 15 хувь хэмжээ буурч магадгүй гэсэн гэх мэт ийм маш сайн тооцоотой ийм дүнгүүдээ хэлчихсэн байгаа шүү.

Нэгэнтээ энэ Төсвийн байнгын хороо маш чухал, төсвийн мөнгийг зөв оновчтой, үр ашигтай зарцуулах талаар тархи толгой оюунаа уралдуулдаг ийм гишүүд байгаа юм чинь ажлын хэсэг орж ирж байгаа бол дэмжье гэсэн харамсалтай нь уначихлаа. Тэгэхдээ миний бодлоор энэ ажлын хэсгийг ахлах гэж байгаа Батболд гишүүн маань энэ бусад гишүүдтэйгээ зөвшилцсөн юм уу, ажлын хэсэгт орсон гишүүд нь байхгүй байж таараад энэ санал уначих шиг боллоо. Тэгэхээр ийм нийгмийг доргиосон, маш нухацтай авч үзэх ёстой энэ асуудал дээр ийм хайнга хандаж болохгүй. Саналыг дахиж хураах дээр санал нэг байна гэсэн ийм протоколд үлдээе.

**Н.Наранбаатар:** Цогтбаатар гишүүнийг ирцээс гаргая, өөрөө хүсэлт гаргасан. Батжаргал гишүүний горимын санал.

**Ж.Батжаргал:** Гишүүдийнхээ энэ өглөөний амар амгаланг айлтгая. Бид санал бодол, байр сууриа илэрхийлж болно. Гэхдээ бас нэгэн рүүгээ бүх юмыг чиглүүлж ярьж болохгүй. УИХ дахь МАН-ын бүлэг ямарваа нэгэн байдлаар энэ асуудлыг ажлын хэсэг байгуулах, байгуулахгүйн тухай хэлэлцээгүй. Улсын Их Хурлын тухай хууль, Дэгийн тухай хууль, Хяналт шалгалтын тухай хуулийнхаа дагуу мэргэжлийн Байнгын хороо тухайлсан сэдвээр холбогдох хүмүүсийн мэдээллийг сонсоод, энэ дээр ажлын хэсэг байгуулж ажиллах нь зүйтэй юм байна гэсэн санал боловсруулаад, тодорхой Байнгын хорооны гишүүнээс, гишүүдээс санал гараад ингээд ажлын хэсэг байгуулагдахаар орж ирсэн юм байна. Өнөөдөр Төсвийн байнгын хороо хангалттай ирцтэй байсан, сая санал хураалт явагдлаа гишүүд өөр өөрсдийн байр суурь, бодлынхоо хүрээнд саналаа өгцгөөсөн. Тэрнийг аль нэг нам руу нялзааж, асуудалд хандаж таарахгүй. Хэдэн биедээ бас жоохон хүндэтгэлтэй хандах ёстой. Энэ чинь юм л бол баруун хойд талын хар боохой гэдэг шиг юм ярьцгааж болохгүй шүү дээ энэ чинь.

Тийм учраас энэ асуудлаа зөв шийдэх ёстой. Горимын санал гаргах эрхтэй улсууд нь гаргаад байгаа юм уу, үгүй юм уу энэ чинь? Эсрэг, татгалзсан санал дээр саналаа өгч чадаагүйгээр гарч ирсэн улсууд л байр сууриа илэрхийлэх ёстой биз дээ энэ чинь.

**Н.Наранбаатар:** Энхтүвшин гишүүн горимын санал гаргая. Энхтүвшин гишүүний микрофоныг өгье.

**Д.Энхтүвшин:** Өнөөдөр Төсвийн байнгын хороогоор хэд хэдэн чухал асуудал хэлэлцэхээр төлөвлөсөн байсан. Тэгээд эхний асуудал дээр АН-ын гишүүд ирцээс гараад, гарч байгаа учраас энэ нь өөрөө буцаад дараагийн асуудлуудад нөлөөлөхөөр байгаа учраас, нөлөөлөхөөр байна. Тэгэхээр тухайлбал өнөөдрийн энэ хэлэлцэх асуудал бол гадаад зээллэгтэй холбоотой, Сэлбэ дэд төвийг бизнес арилжааны чиглэлээр явж болох төслийг төсвийн хүрээнээс гаргаад, төсвийн сахилга батыг алдагдуулаад явах ийм эрсдэлтэй. Өмнөх ЗГ-аас ч гэсэн ийм санал тавьж байсан эдийн засаг дахь төрийн оролцоог нэмэгдүүлэх, хувийн хэвшлийн оролцоог бууруулах нь, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс ч гэсэн энэ Сэлбэ дэд төвийг энэ гадаад зээлийн энэ хуульд тусад нь төсвийн хүрээнээс энэ хязгаарлалтуудаас тусад нь авч үзэх нь тийм үндэслэл харагдахгүй байна гэдэг тайлбарууд тавьсаар байтал ажлын хэсэг дээр унасан саналыг өнгөрсөн долоо хоногт Улсын Их Хурлын чуулганаар босож ирсэн байгаа. Тэгээд энийг унагаах хэрэгтэй, унагаах зөв шаардлагатай гэж үзэж байгаа. Гэтэл АН энэ санал хураалтад орохгүй бол 2/3 хүрэхгүй учраас тэгээд энэ агуулгаар ирцээс гаргаж өгөхийг хүсэж байна. Баярлалаа.

**Н.Наранбаатар:** Энхтүвшин гишүүнийг ирцээс гаргая өөрийн хүсэлтээр. Дараа нь Ажлын хэсэг байгуулах тухай Төсвийн байнгын хорооны тогтоолын төсөлтэй холбогдуулан, тийм. Улсын Их Хурлын гишүүн Батболдоос гаргасан Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн 47,4 хувиар Ажлын хэсэг байгуулах санал дэмжигдээгүй тул энэ асуудлыг хэлэлцэж дууслаа. Батсуурь гишүүн горимын санал гаргасан тэгээд өөрөө гараад явчихсан байна. Горимын саналаар санал хураалт явуулах ёстой юу? Дэгээрээ энэ дээр горимын санал явж болохгүй юм байна.

10.40 цаг

### ***Хоёр.Орон нутгийн хөгжлийн сангийн 2024 оны бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүн, үр нөлөөнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан***

3 дахь асуудал. Төрийн аудитын газрын гүйцэтгэсэн Орон нутгийн хөгжлийн сангийн 2024 оны бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүн, үр нөлөөнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг хэлэлцье. Ажлын хэсгийг оруулаарай. Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя. Албан тушаалтнууд Сандагийн Магнайсүрэн Монгол Улсын Ерөнхий аудитор, Шаравсүрэнгийн Мөнхбаяр Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор, Уртнасангийн Батсүрэн Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер.

Төрийн аудитын тухай хуулийн 33.6-д Монгол Улсын Ерөнхий Аудитор энэ хуулийн 11, 12 дугаар зүйлд заасны дагуу гүйцэтгэсэн аудитын тайланг Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороонд хүргүүлнэ гэж заасны дагуу Орон нутгийн

хөгжлийн сангийн 24 оны бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүн, үр дүнд суурилсан төлөвлөлт, төлөвлөлтийн шилжилтийн үйл явц, үр дүн сэдвээр гүйцэтгэсэн Үндэсний аудитын газрын гүйцэтгэлийн аудитын тайланг Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороонд ирүүлсэн. Мөн Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 15.2.2-т төрийн санхүү, төсвийн хараат бус хяналтыг хэрэгжүүлэх хүрээнд төрийн аудитын байгууллагаас гүйцэтгэсэн аудитын тайлангийн дүгнэлт, зөвлөмж, түүний биелэлтийн талаарх тайланг Төсвийн байнгын хороо тухай бүр хэлэлцэнэ гэж заасан. Үндэсний Аудитын газрын гүйцэтгэлийн аудитын тайланг Монгол Улсын Ерөнхий аудитор Магнайсүрэн танилцуулна. Ажлын хэсгийн 5 дахь микрофоныг өгье.

**С.Магнайсүрэн:** Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, 6 дугаар зүйлийн 6.3.1, 6.3.3, 7 дугаар зүйлийн 7.1.2, 7.2 дахь хэсэгт заасан бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын Ерөнхий аудитын баталсан төлөвлөгөөний дагуу Орон нутгийн хөгжлийн сангийн 2024 оны бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүн, үр нөлөө сэдэвт гүйцэтгэлийн аудитыг аймаг, нийслэл дэх төрийн аудитын газрууд хийж гүйцэтгэн аудитын тайлан, шийдвэрийг Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороо, Сангийн яам, Ашигт малтмал, газрын тосны хэрэг эрхлэх газар зэрэг холбогдох байгууллагуудад хүргүүлээ. Аудитыг Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг холбогдох хууль журамд заасны дагуу төлөвлөн бүрдүүлж, хуваарилсан байдал, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө, хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээг зохих үр дүн, үр нөлөөтэй хэрэгжүүлсэн байдал, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн зарцуулалтыг зохих журмын дагуу хянаж, тайлагнасан эсэхэд чиглүүлэн гүйцэтгэлээ.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн Орон нутгийн хөгжлийн сангийн 2024 оны эхний үлдэгдэл 102,3 тэрбум төгрөг байсан бөгөөд Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас 503,5 тэрбум төгрөг, Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлд заасан бусад эх үүсвэрээс 144,7 тэрбум төгрөг тус тус төвлөрүүлэхээр баталснаас 574,9 тэрбум төгрөг төвлөрч, гүйцэтгэл 88,7 хувьтай гарчээ. Тухайн онд 750,5 тэрбум төгрөгийн эх үүсвэрийг 10942 төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр төлөвлөж, 707,8 тэрбум төгрөгийн 9059 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр гэрээ байгуулсан байна. Гүйцэтгэлээр 523,5 тэрбум төгрөгийн 8998 төсөл, арга хэмжээг санхүүжүүлснээс 8082 төсөл, арга хэмжээ бүрэн хэрэгжиж, 916 төсөл, арга хэмжээ хэрэгжилтийн шатдаа, 1987 төсөл, арга хэмжээ хэрэгжээгүй байх бөгөөд жилийн эцэст 157,9 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Аудитаар нийт 158,5 тэрбум төгрөгийн зөрчил илрүүлж, 1 тэрбум төгрөгийн 75 төлбөрийн акт тогтоож, 109,4 тэрбум төгрөгийн зөрчилд 613 албан шаардлага, 46 тэрбум төгрөгийн зөрчилд 702 зөвлөмж өгч, 2,1 тэрбум төгрөгийн 8 асуудлыг хууль хяналтын байгууллагад шилжүүлээд байна. Төрийн аудитын байгууллагаас Орон нутгийн хөгжлийн сангийн бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүн, үр нөлөөнд хийсэн гүйцэтгэлийн аудитаар дараах нийтлэг зөрчил илэрч байна.

1.Орон нутгийн хөгжлийн сангийн орлого төлөвлөснөөс дутуу бүрдсэн, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр /АМНАТ/ болон газрын тосны нөөц ашигласны төлбөрийг буруу тооцоолох, дутуу төвлөрүүлэх, зарим аймагт нэмэлт эх үүсвэрийг

хэт өөдрөг төлөвлөж төлөвлөсөн, орлогын шилжүүлгийг гүйцэтгэлд үндэслэн олгоогүй.

2.Иргэдийн саналаар дэмжигдээгүй, орон нутгийн хөгжлийн бодлоготой уялдаагүй, зураг, төсөв, ТЭЗҮ хийгдээгүй төсөл, арга хэмжээг аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал /ИТХ/ баталсан.

3.Төсөл, арга хэмжээг шууд худалдаж авах, харьцуулалтын арга хэрэглэх зорилгоор төсөвт өртгийг хуваах, шаардлага хангаагүй буюу татвар, нийгмийн даатгалын өртэй, тусгай зөвшөөрөл, ажлын туршлага, тендерийн баталгаа ирүүлээгүй ААН-ийг гүйцэтгэгчээр шалгаруулсан.

4.Бодит гүйцэтгэлд үндэслэн санхүүжилт олгоогүй, зориулалт бусаар зарцуулсан, хийгдээгүй ажилд урьдчилгаа санхүүжилт олгосон, гэрээний алданги тооцоогүй, төсөл, арга хэмжээг чанаргүй, дутуу гүйцэтгэсэн.

5.Хууль журмаар хяналт тавих чиг үүрэг хүлээсэн байгууллага, албан тушаалтан төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд тавих хяналт сул байгаагаас төсөв санхүүгийн сахилга бат алдагдах, хөрөнгө зориулалт бусаар зарцуулагдах нөхцөлийг бий болгож байна.

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйл, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийлээ.

1.Аймаг, сумын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл, арга хэмжээг орон нутгийн хөгжлийн бодлоготой уялдуулан төлөвлөсөн ч иргэдийн саналаар дэмжигдээгүй, Төсвийн тухай хууль болон бусад хууль тогтоомжид заасан шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангаагүй төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, баталдаг дутагдал нийтлэг байна.

2.Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 523,5 тэрбум төгрөгийн 8998 төсөл, арга хэмжээний 2 хувь буюу 17,8 тэрбум төгрөгийн 180 төсөл, арга хэмжээ нь журамд заасан чиг үүрэгт хамааралгүй, урсгал зардлын шинжтэй 84,6 тэрбум төгрөгийн төсөл, арга хэмжээг санхүүжүүлсэн байна.

3.Орон нутгийн хөгжлийн санд 2024 оны сүүлээр төвлөрсөн газрын тосны нөөц ашигласны төлбөрийн орлогыг аймаг, нийслэлд хуваарилаагүйгээс төлөвлөсөн орлого тасрахад нөлөөлсөн байна.

4.Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас аймаг, нийслэлийн орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлгийг батлагдсан хуваарийн дагуу санхүүжүүлсэн хэдий ч орон нутгийн нэмж төлөвлөсөн эх үүсвэрийн бүрдүүлэлт хангалтгүй байна.

5.Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 750,5 тэрбум төгрөгийн 10942 төсөл, арга хэмжээний 26,1 хувь буюу 209 тэрбум төгрөгийн 916 төсөл, арга хэмжээ бүрэн хэрэгжээгүй байгаад анхаарал хандуулах шаардлагатай байна.

6.Захиалагчаас төсөл, арга хэмжээний хэрэгцээ шаардлага, хүртэх үр өгөөжийг тооцоолоогүй, гүйцэтгэгчид ажил, үйлчилгээг чанаргүй гүйцэтгэснээс

зарим аймагт ашиглалтгүй хөрөнгүүд бий болсноос гадна нэгэнт бий болсон эд хөрөнгийн ашиглалтын байдалд холбогдох албан тушаалтны тавих хяналт сул байгаагаас эд хөрөнгө эвдэрч гэмтэх, зориулалт бусаар ашиглагдах зэрэг алдаа зөрчил давтагдсанаар үр ашиггүй зардал үүсэж байна.

7.Удирдлагын мэдээллийн нэгдсэн систем болон Шилэн дансны цахим системд мэдээллийг бүрэн оруулаагүйгээс иргэд, олон нийт ил тод, үнэн, зөв мэдээллийг авч чадахгүй байна.

Дээр дурдсан аудитын дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч ажиллахыг холбогдох байгууллага, албан тушаалтанд зөвлөж, УИХ-д толилуулж байна.

1.УИХ-д, малын тоо толгойн албан татварын хувь хэмжээг бүсчлэн нэгдсэн байдлаар тогтоож, Төсвийн тухай хууль болон Малын тоо толгойн албан татварын тухай хуульд зохих өөрчлөлт оруулах асуудлыг судалж шийдвэрлэх.

2.Сангийн яаманд, орон нутгийн хөгжлийн санд төвлөрсөн ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөрийн орлогыг аймаг, нийслэлд олгохдоо Сангийн сайдын 2021 оны орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журамд заасны дагуу сумдын орлогын гүйцэтгэлд үндэслэн шилжүүлэх.

2.Сангийн сайдын 2016 оны 17 дугаар тушаалаар батлагдсан АМНАТ ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрлийн орлогоос орон нутгийн хөгжлийн санд олгох шилжүүлэх тооцох аргачлалын холбогдох хэсгийг Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйл, ЗГ-ын 2023 оны 457 дугаар тогтоолд нийцүүлэн шинэчлэн батлуулах.

3.Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжилтийг олгохдоо орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журмын 10.3.3 дахь заалтын дагуу тухайн зөрчлийг бүрэн арилгах хүртэл санхүүжилтийг олгохгүй байх арга хэмжээ авч ажиллах.

Ашигт малтмал, газрын тосны газарт, орон нутгийн хөгжлийн нэгдсэн санд хуваарилах газрын тосны нөөц ашигласны төлбөрийн орлогыг үнэн зөв алдаагүй тооцоолж байх. Түүнчлэн бүх шатны ИТХ, Засаг дарга нарт Төсвийн тухай хууль болон холбогдох хууль тогтоомж, журамд заасан шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангаагүй төсөл, арга хэмжээг төлөвлөхгүй байх, журамд заасан чиг үүргээ бүрэн хэрэгжүүлэх, төсөл, арга хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллах зөвлөмжийг тус тус хүргүүлээ.

Төсвийн байнгын хорооны эрхэм гишүүд ээ, Орон нутгийн хөгжлийн сангийн 2024 оны бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүн, үр нөлөө сэдэвт гүйцэтгэлийн аудитын дүнг хураангуйлан танилцууллаа. Анхаарал хандуулсанд баярлалаа.

**Н.Наранбаатар:** Магнайсүрэн даргад баярлалаа. Аудитын тайлантай холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. Заяабал гишүүнээр тасаллаа. Заяабал гишүүн.

**Б.Заяабал:** Баярлалаа. Орон нутгийн хөгжлийн сангийн аудит, Орон нутгийн хөгжлийн сангийн хэрэгжилт, гүйцэтгэлийн аудитын материалуудыг танилцлаа. Тэгээд энэ дээр хэд хэдэн асуудлууд нэлээдгүй яригдахаар асуудлууд байна л даа. Жишээлбэл Орон нутгийн хөгжлийн сангийн энэ аудит хийгдсэн бүлэг болгон дээр эргээд аваад үзэхэд дандаа ийм зөрчлүүд нь нэмэгдсэн, өнгөрсөн жилээсээ жишээлбэл иргэдийн санал дэмжигдээгүй төсөл хөтөлбөрүүд 16,5 хувиар нэмэгдсэн байна, тендер зохион байгуулах зөрчил нь бас буураагүй байна, өсөлттэй байна. Орон нутгийн хөгжлийн сангийн зарцуулалтын хяналт, удирдлагын мэдээллийн системд ил тод, үнэн зөв мэдээлэл бас хангалтгүй хэвээрээ байгаад байна гээд. Ингээд аудит өнгөрсөн жил л бас зөвлөмж гаргаж өгч байсан. Энэ жил дахиад ингээд л зөвлөмж гаргаж өгч байгаа юм байна. Тэгээд алдаа зөрчлүүд нь ерөөсөө ингээд арилахгүй хэвээрээ яваад байдаг. Энийг ер нь яах ёстой юм бэ гэдэг ийм асуудал дээр нэг хариулт өгөөч.

Одоо энэ оруулж ирсэн зөвлөмжөөс нь би асууя гэж бодож байна. УИХ-д олгосон, УИХ руу чиглэж өгсөн зөвлөмж нь байгаа юм. Малын тоо толгойн албан татварын хувь хэмжээг бүсчилсэн нэгдсэн байдлаар тогтоож, Төсвийн тухай хууль, Малын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах саналыг авч хэлэлцэхийг зөвлөж байна гэсэн байгаа юм. Тэгэхлээр энэ чинь малын тоо толгойг эндээс нэгдсэн байдлаар гаргаж болохгүй. Энэ чинь хууль нь угаасаа орон нутагт тухайн малынхаа тооноосоо хамаараад интервал тавиад, орон нутгийн ИТХ-д өгчихсөн ийм хууль шүү дээ. Энэ хуулийн хэрэгжилт нь зөв явж байна уу, ашиглалт нь зөв байна уу гэдэг дээр л аудит үндсэндээ хяналт тавих ёстой байсан. Ингээд өгч байгаа зөвлөмжүүд нь ч гэсэн би оновчгүй байна уу л гэж ингэж хараад байгаа юм.

Сангийн яамны Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тогтоолоор баталсан Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам байгаа юм. Энэ журмын 10 дугаар бүлэг дээр уул нь энэ орон нутгийн хөгжлийн сангийн хэрэгжиж байгаа ажлын төлөвлөх, батлах, санхүүжүүлэх, хэрэгжүүлэх, бүртгэх, тайлагнах, хяналт шалгалтын бүх үйл ажиллагаануудыг энэ удирдлагын мэдээллийн нэгдсэн системээр дамжуулж хянана гээд ингээд оруулчихсан байгаа. Гэтэл энэ хяналт нь ерөөсөө хангалтгүй байгаад байгаа юм. Тэгээд энийг яг хангалттай болгох үүднээс Сангийн яам талд ямар зөвлөмж, аргачлал өгч байгаа юм бэ?

Дээрээс нь орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлт нь 750 тэрбум төгрөгөөр төсөвлөсөн гээд байгаа юм. Гүйцэтгэл нь 574 төгрөг гээд байгаа. Ингээд 200 тэрбум төгрөгөөр энэ сангийн жишээлбэл орлогыг өндрөөр төлөвлөсөн байна л даа. Нийгмийн даатгал, эрүүл мэндийн сан дээр ч бас ийм асуудал гараад байгаа. Тэгээд яагаад сангуудын орлогыг ингэж өндрөөр төлөвлөөд, бодит гүйцэтгэлээсээ өндрөөр төлөвлөөд байгаа дээр ямар дүгнэлт байгаа юм бэ гэдэг дээр.../минут дуусав/

**Н.Наранбаатар:** 5 номерын микрофон Ерөнхий аудитор Магнайсүрэн.

**С.Магнайсүрэн:** Заяабал гишүүний асуултад хариулъя. Энэ бол ингээд манай бүх аймаг, нийслэлийн, аймгийн төрийн аудитын газрууд хийгээд манай Дархан-Уул аймгийн төрийн аудитын байгууллага нэгтгэж, сэдвээр орж ирж танилцуулагдаж байгаа ийм асуудал байгаа. Орон нутгийн хөгжлийн санд жил болгон бид нөгөө санхүүгийн цаглаварт хугацаанд аудит хийхдээ орон нутгийн хөгжлийн сангууд хамрагддаг. Зарим үед түүврээр хамрагдаад ингээд явдаг. Ер нь жил болгон хамрагддаг гэсэн үг.

Зөрчлүүд бол ингээд буурахгүй байна гэдэг дээр ийм асуудлыг манайх нэгдсэн байдлаар хөндөн тавьж, зөвлөмж өгсөн байгаа. Зөрчлүүд нэмэгдээд байгаагийн үндсэн шалтгааныг сая Заяабал гишүүн маш тодорхой хэд хэдэн зүйл дээр хэллээ. Энэ саяын яг дурдагдсан зөрчлүүд байнга давтагдаж ингэж гарч байгаа ийм зүйлүүд байгаа. Тэгэхээр энэ ЗГ-ын энэ орон нутгийн сангийн үйл ажиллагааны журамд заасан тодорхой заалтууд биелэгдэхгүй байгаа энэ асуудал дээр бид хаана хаанаа анхаарал хандуулах шаардлагатай гэж үзээд бид Сангийн сайдад болоод төсөв захирагч нарт бүгдэд нь зөвлөмж өгсөн. Энэ зөвлөмжийнхөө хэрэгжилтийг бид хэрэгжилтийг хангах, дараа дараагийн шатны арга хэмжээ авч хэрэгжүүлэхээс өөр гарцгүй байгаа. Өөрөөр хэлбэл энэ удаагийн өгсөн зөвлөмж хэрэгжихгүй бол бид хуулиараа дараа жилдээ хариуцлагын механизм хөндөж ярих ийм хуультай. Энэ утгаараа бид энийг хэрэгжилтийг бүрэн хангах ёстой гэж үзэж байгаа.

2 дугаарт нь тэр хяналт хэрэгжүүлэх дээр жишээлбэл энэ журмын хяналт дээр Сангийн яам журмынхаа биелэлтэд хяналт тавих ёстой. Тэгээд бүх гүйцэтгэл, шилжүүлэг, шилжүүлгүүдийг ингээд Сангийн яаман дээр холбогдох дүрэм журмын дагуу хийгдэж байгаа учраас энэ хүрээндээ бол энэ хэрэгжилтийг бүрэн хангачих уг нь бололцоо байгаа. Дээр нь тэр удирдлагын мэдээллийн систем болоод цахим шилэн дансны юунд мэдээллийг бүрэн оруулах энэ бололцоонууд байгаа.

Шилэн дансны хуулийн хэрэгжилтийн мэдээлэл нийслэлийн аудитын хүрээнд манайх жил болгон гаргаж байгаа. Энэ жил бид УИХ-д санхүүгийн нэгтгэсэн тайлан болон төсвийн гүйцэтгэлийг оруулж ирэхдээ Шилэн дансны хуулийн хэрэгжилтийн асуудлаар дэд тайлан оруулж ирэхээр ингэж төлөвлөж тусгайлан авч үзэж байгаа. Яагаад вэ гэвэл шилэн дансны хэрэгжилт дээр анхаарах олон зүйлүүд байгаа. Жил болгон давтагдаж байгаа учраас ингэж оруулж ирнэ гэж тооцож байгаа юм.

Орлогыг өндөр төлөвлөөд байгаа дээр хэд хэдэн зүйлүүд байна. 1 дүгээрт, орлогоо бол дутуу, юу буруу тооцоолж хэт өөдрөгөөр төсөөлсөн нэг ийм зөрчил байгаа. Нөгөө талаар болохоор зэрэг орлогод, орлоготой холбоотой зарим асуудлууд нь тухайн жилийнхээ гүйцэтгэл орлогын байдлаас болоод тасраад, тэр нь дараагийн жил рүү шилжихдээ арай өөрөөр төсөөлөгдөөд, хүлээгдэж байгаа гүйцэтгэлээр ингээд төлөвлөж явж байгаа учраас зарим зүйлүүд ингэж буруу төлөвлөгдөж байгаа ийм зүйлүүд ажиглагдаж байна. Дээр нь орлоготой холбоотой энэ эцэслэн шийдэж байгаа Сангийн яаман дээр шийдэгдэж байгаа учраас энэ орлогын төлөвлөлтөө тооцоо судалгаа сайтай хийх ёстой гэдэг ийм зөвлөмжийг бид өгч байгаа. Ингээд манай, өөр юу байлаа, болчхож байна уу? Би шаардлагатай бол нэмээд яая.

**Н.Наранбаатар:** Заяабал гишүүн тодруулах уу? Батжаргал гишүүн асуулт асууна.

**Ж.Батжаргал:** Баярлалаа. Энэ орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн бүрдэл, төсөл, арга хэмжээний санхүүжилт, үр нөлөө гээд энэ зүйл дээр гүйцэтгэлийн аудит хийгдээд, аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмж орж ирж байгаа юм. Тэгэхээр ер нь энэ орон нутгийн хөгжлийн сангаар хийгдэж байгаа хөрөнгө оруулалтын арга хэмжээнүүд буюу энэ төсөл, арга хэмжээн дээр бид нэлээн нарийн хяналт тавихгүй бол бас тийм асуудал нэг мөр ойлгогдож, нэг мөр хэрэгжиж чадахгүй байгаад байгаа юм уу гэмээр ийм зүйл байгаад байгаа юм.

Би аудитын дүгнэлт дотор ер нь ерөнхий дүгнэлтүүд яваад байх юм уу хэдүүлээ, яг болж өгөхгүй байгаа юмных нь учир шалтгаан нь юундаа байгаад байгаа юм, үүнийг нь хангах хүрээнд эрх зүйн орчин тал дээр нь ямар асуудал дээр, ямар хууль дээр, ямар зохицуулалт хийвэл боломжтой юм энэ эд нараа зөвлөмжөөр их тодорхой өгмөөр байгаа юм. Энэ талаас хийсэн судалгаа юмнууд ямархуу байдаг юм бэ гэдэг нэг ийм асуудал байна гэж.

2 дугаарт тодорхой зөрчлүүд илэрсэн байна. 180 төсөл, арга хэмжээ ч гэх шиг ингээд тодорхой заагдчихаж байгаа байхгүй юу. Хамааралгүй урсгал зардалтай холбоотой асуудал санхүүжүүлчихжээ гэж. Энэ дээр хариуцлагын ямар арга хэмжээнүүд аудитын байгууллагаас авагдсан юм бэ? Зориулалт бусаар хөрөнгө мөнгө зарсан байна. Тэгвэл үүнийг буцаан төлүүлэх, төвлөрүүлэх төлбөрийн акт юмнууд ер нь ямархуу байдлаар гарсан юм бэ? Тэрний чинь гүйцэтгэл, үр дүн ер нь ямархуу явж байгаа юм гэдэг асуудал нэн чухал байна л даа. Энэ чинь 24 оны гүйцэтгэл явж байгаа учраас.

Дараагийн нэг зүйл энэ орон нутагт гэдэг юм уу, ЗГ-т УИХ тодорхой хуулийн хязгаар дотор эрх өгчихдөг юм. Дан дамаа энэ малын тоо толгойн албан татварыг сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлуудад эрхийг нь заагаад өгчихсөн. Малын төрөл бүр дээрээ тоо толгойд нь төдөөс төчнөөн гэдэг юм тавьчхаад байгаа. Үүнийг сумын хурлууд янз бүрээр хэрэглэж байгаа үнэн. Уг нь зүй нь тэр бэлчээрийн даац чадамж, мал аж ахуй /МАН/ -н салбарын эдийн засгийн үр өгөөж, бүтээмж эргэлтэд орж байгаа байдал.../минут дуусав/

**Н.Наранбаатар:** Ажлын хэсгийн 5 номер хариульъя.

**С.Магнайсүрэн:** Батжаргал гишүүний асуултад хариульъя. Үндэсний аудитын газар Магнайсүрэн. Ер нь манай аймгууд яг нөгөө аймаг, аймаг дээрээ орон нутгийн хөгжлийн сангаар хэрэгжиж байгаа, бүх сумд бас байгаа. Энэ орон нутгийн хөгжлийн сангууд, дээр нь орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан гээд Сангийн яамнаас нөгөө шилжүүлэг хийдэг зориулалттай ийм хөрөнгийг төвлөрүүлдэг сан. Энэнтэй холбогдуулаад ингээд үзсэн. Бид яг тодорхой зөвлөмж өгөхийг хэд хэдэн зүйл дээр чухалчилсан. 1 дүгээрт, энэ ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөрийн орлогыг аймаг, нийслэлд олгохдоо энэ орлогын гүйцэтгэлд нь үндэслэж шилжүүлээч, орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журамд заасны дагуу гэж нэг ийм зөвлөмж өгсөн.

2 дугаарт нь болохоор зэрэг Сангийн сайдын АМНАТ, ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрлийн орлогоос орон нутгийн хөгжлийн санд олгох шилжүүлэг тооцох аргачлалын 3.3.1 дэх хэсгийг бол яагаач, Төсвийн хуулийн 60 дугаар зүйлийн 60.2.7, ЗГ-ын 2023 оны 457 дугаар тогтоолд нийцүүлж шинэчлэн батлаач гээд. Мөн дараа нь орон нутгийн хөгжлийн сангаа нэгдсэн сангаас санхүүжилтийг олгохдоо орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журмын 10.3.3 дахь заалтын дагуу зөрчлөө бүрэн арилгасны дараа энэ санхүүжилтээ олгооч. Өмнөх зөрчлүүд нь ингээд хураагдаад байна, давтагдаад байна гэдэг ийм зүйлүүдийг хэлсэн. Энэ бол яг л асуудлыг зохицуулж байгаа Төсвийн хууль, Сангийн үйл ажиллагааны журам гэсэн үндсэн 2 эрх зүйн актын хүрээнд ийм, ийм асуудлыг шийдвэрлээд, энэ уялдааг нь хангаач гэдэг ийм байдлаар зөвлөмжөө өгсөн. Бусдаар бол түрүүн Заяабал гишүүн хэлсэн энэ мэдээлэлтэй холбоотой асуудлууд энэ тэр бол нөгөө хэрэгжүүлээд заалт нь байж байгаа. Тийм учраас хэрэгжилт, хяналтаа сайжруулаач гэсэн ийм талаар зөвлөмжийг 1 дүгээрт өгсөн байгаа.

2 дугаарт нь, хариуцлагатай холбоотой асуудлыг энэ удаа бид 158,5 тэрбум төгрөгийн зөрчил илрүүлсэн. 1 тэрбум төгрөг дээр бол 75, 1 тэрбум төгрөгийн дүнтэй 75 төлбөрийн акт тогтоосон, 109,4 тэрбум төгрөгийн зөрчил дээр нь 613 албан шаардлага, 46 тэрбум төгрөгийн зөрчил дээр 702 зөвлөмж өгсөн, 2,8 тэрбум төгрөгийн үнийн дүнтэй 8 асуудлыг бид хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн. Шаардлагатай бол бид мэдээллийг ингээд нарийвчлаад танд 8 асуудал нь ямар, ямар асуудал байгаа юм, 75 төлбөрийн акт юу гээд ингээд нарийвчилж өгөх бололцоо бидэнд мэдээлэл байгаа.

Орон нутгийн үйлчилж байгаа, орон нутгийн чиглэлээр үйлчилж байгаа хуулийн хүрээнд интервалтай энэ эрх өгдөг асуудлыг бид орон нутгийн эрх хэмжээг өргөтгөх энэ бол хуулийн ийм бодлогын асуудал. Энэтэй холбогдуулаад бидний Их Хуралд зүгээр санал болгож байгаа, Их Хуралд бид зөвлөдөггүй, зүгээр л санал өгдөг, санал оруулдаг, санал болгодог, Их Хурлын анхааралд оруулдаг гэсэн үг. Энийг болохоор зэрэг энэ малын тоо толгойн албан татварын хувь хэмжээг нэгдсэн байдлаар тогтоовол яасан юм бэ гээд энэ манай аймгуудаас гарч ирж байгаа саналыг нэгтгэж ингэж тавьсан байгаа. Бусад асуудлаар бид энэ АМГТГ болоод холбогдох төсөв захирагч нарт бол тодорхой ийм зөвлөмжүүд өгсөн байгааг бид тайлан дээрээ дэлгэрэнгүй оруулсан байгаа. Баярлалаа.

**Н.Наранбаатар:** Сайнзориг, Жаргалсайхан нарын гишүүдийг асуулт асуух дараалалд нэмж оруулаарай. Батжаргал дарга тодруулъя.

**Ж.Батжаргал:** Тийм, энэ орон нутгийн хөгжлийн сан дээр бид дан ганц тэр АМНАТ, хайгуул ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөрийн орлогоос гадна энэ малын тоо толгойн албан татварын төлбөр, дээр нь тэр өнөө нийгмийн хариуцлагын хүрээнд хэн нэгэн янз бүрийн юм гуйгаад яваад байдаггүй, орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа ААН, байгууллагууд, тэр тусмаа уул уурхайн салбарынхан тухайн орон нутагт юм хийж бүтээнэ нийгмийн хариуцлагын хүрээнд гэж байгаа бол орон нутгийн хөгжлийн санд нь шууд шилжүүлж байхаар хуульчилж өгсөн, 2022 онд билүү дээ би тэгж санаж байна, 23 онд билүү. Тэрүүгээр ер нь орон нутагт хэдий хэмжээний юм ордог юм бэ, орж байна вэ? Тэр хуулийн хэрэгжилт ер нь ямархуу байна вэ?

**Н.Наранбаатар:** Хариулъя ажлын хэсгийн 6 номерын микрофоныг өгье.

**Ш.Мөнхбаяр:** Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газар Мөнхбаяр. Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 62.5-д заасан эх үүсвэрээр бол 82 тэрбум 825,6 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэл нь 44 тэрбум 969,8 сая төгрөгөөр буюу 54,3 хувьтай байгаа. Хамгийн өндөр дүнгээр төлөвлөсөн аймгуудын хувьд болохоор Орхон аймаг 55 тэрбум 361,2 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэл нь 25 тэрбум 361,2 сая төгрөг, Ховд аймаг 6 тэрбум 240 сая төгрөг төлөвлөж, 7 тэрбум 728 сая төгрөгөөр гүйцэтгэлтэй байгаа. Ийм аймгууд бол энэ орлогод орлого тасрахад нөлөөлж байгаа юм.

**Н.Наранбаатар:** Батболд гишүүн асуулт асууя.

**Р.Батболд:** Туулын хурдны замтай холбоотой өртөг зардлыг нь зөвхөн үзчихье гэсэн чинь ажлын хэсэг байгуулаад явъя гэдэг энэ саналыг маань

дэмжсэнгүй 1 дүгээрт. Тэгэхээр энэ хулгайгаа хаацайлж байна л гэж үзэхээс өөр аргагүй болоод байна.

2 дугаарт гэвэл гадаад зээлийн ашиглалттай холбоотой энэ нэг хуулийн төсөл явж байгаа. 2 том явуулах ёстой төслийг дагуулаад бизнесийн зарчмаар явж болох ийм төслийг оруулж ирчхээд, тэрийгээ хуулиар хамгаалаад хулгай хийж явах гэж байгаа. Тэгэхээр энэ асуудлуудыг хэлэлцэхээс татгалзаж байгаа учраас ирцээс хасаж өгнө үү.

**Н.Наранбаатар:** Батболд гишүүн ирцээс хасаж өгнө үү гэсэн санал гаргасан, ирцээс хасъя. Ганбаатар гишүүн, Гомбын Ганбаатар гишүүн асуулт асууя.

**Г.Ганбаатар:** Энэ хэлэлцэж байгаа асуудалтай холбоотой асуулт алга. Өнөөдөр Төсвийн байнгын хорооны хурлын эхний асуудал Туулын хурдны замын төсөвт өртөг болоод үр өгөөжийн талаар нэг ажлын хэсэг байгуулах байсан. Тэгээд эрх баригч нам та бүхэн олонхоороо ажлын хэсэг байгуулахыг татгалзаж байх шиг байна. Ер нь цаашдаа нэг юм бодоорой. Энэ чинь иргэдийн мэдэх эрх шүү. Ажлын хэсэг нь ч бай, сонсгол нь ч бай Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулиараа олгогдсон эрх. Харбины гэрээ юу болсон, одоо Туулын хурдны замтай холбоотой асуудал. Өнөөдөр ахиад уг нь энэ хэлэлцэх асуудлын 3 дээр өнөөдөр чинь гадаад зээллэгийн ашиглалт гээд Дорноговь аймагт байгуулагдсан нефтийн үйлдвэр тэр 1,7 тэрбум доллар, ахиад дээрээс нь Эрдэнэбүрэнгийн цахилгаан станц бас 1 тэрбум доллар Хятадын Сангийн яам Хятадын Эксим банкттай байгуулсан гэрээ байгаа. Гэтэл АН-ын бүлэг өнгөрсөн долоо хоногт Их хурлаа хийгээд, АН Их хурлаа хийгээд, Үндэсний бодлогын хорооныхоо хурлыг хийгээд 3 өдөр хуралдаж байх явцад энэ төсөл дээр орж ирээгүй байсан Сэлбэ дэд бүтцийн 500 сая долларын асуудал орж ирсэн байгаа юм.

Тэгээд энэ мэт энэ чинь ингээд эргээд бодоход 10 гаруй их наяд төгрөгийн асуудал байгаа байхгүй юу. Тэгээд энэ төсвийн гадуур, дээрээс нь хяналт шалгалт хийе гэхлээр ингээд ажлын хэсгийг нь байгуулж өгдөггүй чинь ямар ёс зүйтэй юм бэ та нар? Эрх баригч намынхан, гишүүд та нар бодох хэрэгтэй шүү дээ. Тэгээд ийм шалтгаанаар өнөөдрийн энэ хуралд бид оролцох боломжгүй. Хувь хүнийхээ хувьд оролцох боломжгүй байна, ирцээс гаргаж өгнө үү.

**Н.Наранбаатар:** Ирцээс гаргаж өгнө үү гэсэн хүсэлт тавьсан, ирцээс гаргая. Мөнхсоёл гишүүн.

**Б.Мөнхсоёл:** Өнөөдөр уг нь маш чухал асуудлууд хэлэлцэгдэх гэж байгаа. Тэгээд уг нь оролцох сонирхолтой. Жишээлбэл энэ орон нутгийн хөгжлийн сан гэдэг дээр 2010 онд Ажлын хэсэг үүсэхэд би шинжээч судлаачаар орж ажиллаж байсан. Төсвийн төвлөрлийг сааруулах зорилготой тухайн иргэдэд санхүүгийн эрх мэдэл өгөх, шийдлээ хамтдаа гаргадаг ийм зорилготой орон нутгийн хөгжлийн сан байгуулагдсан боловч одоо олон жилийн дараа эргээд харахад анхны зорилгоосоо гажчихсан, маш олон ийм сөрөг, сул талуудыг агуулсан ийм асуудал болчихсон байгаа шүү. Энэ асуудлыг эргэж харахаас өөр аргагүй. Энэ хэсгийг ингээд товчхон дуусахаас, яривал их юм бий.

2 дугаарт нь сая эхний асуудал болох би түрүүн хэллээ шүү дээ бүгдээрээ мэдэж байгаа. Иргэд, олон нийт энэ Туулын замын, хурдны замын асуудал төсөл дээр эсэргүүцэж байгаа, ХҮН намын зөвлөлөөс маш гүн гүнзгий тооцоолол

судалгааг хийгээд, энийг одоогийн байдлаар үргэлжлүүлж болохгүй гэдэг дээр санал нэгдээд бид дүгнэлтээ олонд зарлачихсан. Гэтэл энд Төсвийн байнгын хороон дээр дахиад ийм гишүүдээс бүрдсэн Ажлын хэсэг үүсэх гэж байгаа юм байна. Нухацтай үзэлгүй ингээд санал хураалтаар уначхаж байгаад нь харамсаж байна. Тийм учраас энэ санал, энэ ажлын хэсгийг зөв зохион байгуулах ёстой байх, эргэж харах ёстой байх гэдэг утгаараа мөн адилхан ирцээс гарахыг бас энэ микрофон дээр заавал хэлэх ёстой юм байна. Ингээд хэлчихье ирцээс гаргаж өгнө үү.

**Н.Наранбаатар:** Ирцээс хасья гэсэн хүсэлт гаргасан учраас ирцээс. Сайнзориг гишүүн үг хэлье.

**П.Сайнзориг:** Гишүүдийнхээ зарим зүйлүүдийг ойлгохгүй байна л даа. Олонхоороо шийдээд л явдаг институт биз дээ энэ парламент гэдэг чинь Байнгын хорооны түвшинд. Тэгээд олонхын шийдвэр гарвал тэрийг дагаад л явдаг, олонх нь зөвшөөрвөл түүнийг хэрэгжүүлээд л явдаг. Тэгээд ирцээс гарч болно. Тэгэхдээ ирцээс гарахдаа хуультай байх гэж ойлгож байгаа. Тухайн асуудал нь Үндсэн хууль зөрчиж байна гэдэг асуудал дээр л ирцээс гардаг болохоос биш одоо ингээд л ирцээс гаръя, гаръя гээд байхаар ийм дэг жаяг энэ Байнгын хороон дээр байж болох юм болов уу? Байнгын хорооны дарга та нэг тайлбар өгөөч.

2 дугаарт би хэлэлцэж байгаа асуудал дээрээ төвлөрч асууя. Энэ зөвлөмжид байгаа зүйлүүд дээр бид цаашдаа ЗГ-т чиглэл өгөх тогтоол гаргаж болох уу? Байнгын хорооны дарга энэ дээр нэг санал хэлээч. Ялангуяа яах вэ сая Мөнхсоёл гишүүний хэлээд байгаа үнэн. Төсвийн тухай хуулийн тэр орон нутгийн хөгжлийн сантай холбоотой зохицуулалтуудыг боловсронгуй болгох энэ зүйл байна. Магадгүй яг иргэдийнхээ гэдэг юм уу даа яг багийн түвшинд иргэдийнхээ тэр санал авах энэ үйл ажиллагааг илүү их, зарим тохиолдолд боломжтой газрууд дээр нь цахимаар хийх бололцоо бий юү И Монголиагаа ашиглаад? Илүү их оролцоог нь л зөв хангамаар байна. Тэгэхгүй яг бас нэг хурлын ирц бүрдүүлэхдээ ах дүүгээрээ цуглаж байгаад, яг өөрсдөд хэрэгтэй тийм зүйлүүдээ л хийчихдэг, ийм гомдол мэдээллүүд ирээд байдаг юм байна лээ. Яг юу гэдэг юм сумын нийт иргэд явах тийм зам биш, яг хэсэг бүлэг ах дүүсийн өвөлжөө, хаваржаа руу явдаг зам ч гэдэг юм уу, яах вэ нэг талдаа зөв л дөө бэлчээрийн даац хүрэлцэхгүй байгаа энэ үндсэн дээр аль болохоор л машин тэрэг хүрэхгүй байгаа газар луу зам харгүй гаргаад ингээд явдаг зүйлүүд байх юм байна лээ. Тэгэхээр уг асуудлыг нэг тодорхой түвшинд юу хэлэх гэж байна гэхээр хэрэгжилтийн үр дагаврыг нь үнэлээд, намрын чуулганд оруулж ирж танилцуулаач гэдэг чиглэлийг өгчихмөөр байна төсөв батлах үеэр. Тэгээд ер нь юу нь болж байгаа юм, юу нь болохгүй байгаа гэдэг зүйлийг анхаарчихмаар байгаа юм.

2 дугаарт энэ зөвлөмжид өгөөд байгаа би малын тоо толгойн албан татварын хуулийг аймгийн хэмжээнд нэгдсэн батлахыг дэмжээд байгаа юм. Хог хаягдал бас нэг иймэрхүү яваад байгаа юм маш замбараагүй. 330 сум баталдаг. Тэгээд хогийн менежментийг нэгдсэн байдлаар хийж чадахгүй учраас энийг нөгөө эдийн засгийн үр ашгийг нь гаргаж чадахгүй, зөв төлөвлөлт, менежмент хийж чадахгүй байх шиг байгаа юм орон нутгууд. Тэгэхээр Малын тоо толгойн албан татварын хууль болон Хог хаягдлын хуулийг цаашдаа татвар гэдэг утгаар нь ЗГ нэгдсэн байдлаар сумууд биш, аймгууд тогтоодог байдал руу орвол яадаг юм бэ гэдэг асуудлыг судалж оруулж ирж танилцуулаач гээд ЗГ-т нэг үүрэг өгчихмөөр байна. Энэ дээр Байнгын хорооны дарга байж болох уу, үгүй юу?

Ойрын өдрүүдэд бас энэ Ашигт малтмалын хууль орж ирнэ гэж бодож байгаа. Үүнээс орон нутагт хуваарилах тэр хөрөнгүүдийг зөв зохион байгуулмаар байна. Заяабал дарга ярьдаг байсан Олборлох үйлдвэрийн ил тод.../минут дуусав/

**Н.Наранбаатар:** Байнгын хорооны тогтоолын төсөл санаачилж болно. Тийм. Улсын Их Хурлын уу? Тийм болно. Та, тийм ажлын хэсэг байгуулаад ингээд өгч болно. Та саналаа бичгээр гаргаад өгөөрэй. Хариулт. Сайнзориг гишүүн тодруулъя.

**П.Сайнзориг:** Та нөгөө ирцээс хариулт гараад байгаа юмнууд дээр бас нэг албан ёсны ойлголт өгөөч гэж 1 дүгээрт хүсэж байгаа юм. 2 дугаарт би энэ зөвлөмжтэйгөө танилцчихсан. Гол асуудал ерөөсөө ЗГ-т энэ орон нутгийн хөгжлийн сантай холбоотой, энэ АМНАТ болон тусгай зөвшөөрлийн нөгөө хадгалах хугацааны төлбөртэй холбоотойгоос орж ирэх орлого энэ зүйлүүдийг бас нэг Ашигт малтмалын хуулиасаа гадна нөгөө Олборлох үйлдвэрийн ил тод байдлын хуультайгаа уялдуулмаар байгаа юм. Зарим аймгийн удирдлагууд чинь өөрсдөө төрийн бус байгууллага /ТББ/ байгуулчаад нийгмийн хариуцлагын хүрээнд компаниудаас мөнгө аваад, орон нутгийн хөгжлийн санд оруулахгүйгээр тэр ТББ-аараа төсөл, хөтөлбөр санхүүжүүлээд явдаг 2, 3 аймаг байдаг юм байна лээ. Тэгээд ийм зүйлүүд хүртэл ингээд гарчихсан байна. Тэгэхээр энийг ер нь нэг цаашдаа яг Байнгын хорооноос ажлын хэсэг гаргаад, Улсын Их Хурал ЗГ-т чиглэл өгөх тогтоол өгөөд, намрын чуулганд яг энэ асуудлыг нэг хэрэгжилтийн үр дагаврыг нь сонссон, сонсох чиглэлийг өгмөөр байна.

**Н.Наранбаатар:** Энэ ирцтэй холбоотой одоо нэг хүн гарвал ирц хүрэхээ байгаад энэ Төсвийн байнгын хороо чинь цаашаа хуралдах чадамжгүй болчих юм байна. Тэгээд энэ Дэгийн тухай, Улсын Их Хурлын тухай хуульд ирцээс гарна барина гэсэн тийм зохицуулалт байдаггүй юм байна. Энэ дээр зөвхөн юу гэж байгаа вэ гэхээр зэрэг гишүүн хэлэлцэж байгаа асуудалтай шууд холбоотой үйл ажиллагааны дүнд өөрөө болон гэр бүлийн гишүүд нь орлого олж байгаа эсхүл бусад хэлбэрээр ашиг сонирхлын зөрчилтэй бол тухайн асуудлаар хэлэлцүүлэг, санал хураалтад оролцохоос татгалзах гэдэг юм байна. Тийм учраас одоо ирцээс хүн хасах боломжгүй байна шүү. Ганзориг гишүүн асуулт асууя. Яах вэ одоо 15 болчихож байна шүү дээ 29-өөс чинь, тэгээд 15-аас чинь ингээд 1 хүн хасагдчихаар энэ хурал чинь цаашаа явахааргүй болчихож байна шүү дээ. Төрийн ажил ингээд гацах юм уу, яах юм. Гишүүд чинь угаасаа хуралдаа суух үүрэгтэй шүү дээ.

**П.Ганзориг:** Төсвийн байнгын хороо бол уг нь энэ чухал, чухал асуудлуудыг хэлэлцдэг Монгол Улсын төсөвтэй холбоотой, төсөв батлах, гүйцэтгэлд нь хяналт тавих, үр ашгийг нь хянах гээд олон чухал асуудлууд хэлэлцдэг. Өнөөдөр энэ Монгол Улсын хэмжээнд, нийслэлийн хэмжээнд асар том дүнтэй гүйцэтгэж байгаа, татвар төлөгчдийн мөнгөөр гүйцэтгэж байгаа 2,3 их наядын Туулын хурдны замын төслийн ТЭЗҮ болоод бусад зүйлийг хянах энэ ажлын хэсэг байгуулах саналыг оруулж ирсэн, дэмжигдсэнгүй.

2-т Гадаад зээлийн ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлэх тухай энэ хуулийн төсөл дээр бас 3 төслийн гадаад зээлийг нэмэгдүүлэх асуудал орж ирсэн. Энэ дээр 1 дүгээрт энэ Эрдэнэбүрэнгийн УЦС барих төслийг дэмжиж байгаа. Газрын тосны үйлдвэр бас чухал, мэдээж дотооддоо бид нефтиэ хангадаг болох энэ чухал зүйл байгаа. Гэхдээ Сэлбэ дэд төв гээд ингээд нэмэгдээд ороод ирж байгаа гэх мэтчилэн ийм том дүнтэй зээллэгийн асуудлууд орж ирж байгаа асуудал байна. Тэгээд энэ

ингээд өмнө нь бас дэмжигдээгүй асуудал ороод ирж байна, босоод буцаад. Тэгээд иймэрхүү чухал асуудлуудыг хэлэлцэхдээ их нухацтай хэлэлцэхгүй бол бид ингээд дэмжээд л явуулчихдаг. Тэгээд жил болгон сүүлийн үед бол бараг 30, гучин хоёр, гурван их наядаар төсөв батлагдаад, төсвөөс гадуур ч гэсэн энэ зээлийн асуудлууд яваад, гүйцэтгэл нь аудитаас гүйцэтгэлийн аудит орж ирэхдээ бараг 9, 10 их наядын зөрчилтэй гэж орж ирдэг, тэгээд л өнгөрөөдөг. Ингээд Монгол Улсын хөгжлийг гацаасан, төсөв мөнгийг үр ашиггүй зарцуулдаг, ямар ч хариуцлагын тогтолцоо байхгүй ийм юм руу яваад орчихсон.

Тийм учраас эдгээр асуудлыг хэлэлцэж байгаа үед уг нь нухацтай хэлэлцмээр байгаа юм. Тэгээд энэ гишүүд, өмнөх гишүүд нь ч гэсэн дэмжихгүй байгаа учраас энэ хууль журмын зохицуулалтын дагуу ирцээс гаръя гэдэг саналаа хэлээд, та бас гаргачих шиг болсон. Тэгээд бусад гишүүдээ гаргахгүй гэхээр ойлгохгүй байгаад байна. Би ч гэсэн энэ 2 асуудлыг дэмжихгүй. Дэмжихгүй байгаа учраас өмнөх гишүүдээ адилхан бас ирцээс гаргаж өгөхийг хүсэж байна. Тэгээд яагаад 2-т гаргах боломжгүй гэвэл өмнөхүүд нь гарч болоод, дараагийн хэд нь ирц хүрэхгүй болчих гээд байгаа болохоор гарч болохгүй гэдэг тайлбар өгөөд байгаа юм бэ? Энэ чинь хууль бүгдэд нь тэгш үйлчлэх ёстой шүү дээ. Бүгд суух үүрэгтэй бол суух ёстой. Нэг хэсэг нь суугаад ингээд гарч болохгүй гээд суулгаад байдаг. Нөгөө хэсгийг нь болохоор гарга гээд гаргаад, ирцээс нь хасаад явуулчихдаг. Тэгээд энэ асуудал дээр та нэг тодорхой хууль зүйн талаас нь яг ийм өмнөхүүд нь ийм хуулийн, ийм үндэслэлтэй байсан болохоор гаргаад явуулсан юм, одоо эд нь ингээд болохгүй байгаа юм гэдэг тодорхой тайлбар өгөхийг хүсье.

**Н.Наранбаатар:** Ер нь Улсын Их Хурлын гишүүн энэ чуулган, Байнгын хорооны нэгдсэн хуралдаан, Байнгын хорооны хуралдаанд суух үүрэгтэй шүү. Түрүүчийн гишүүд микрофонд хүсэлт хэлээд ингээд ирцээс гарсан. Тэгээд ирцээс гарсан гишүүдийг би буцаж Байнгын хорооны хуралдаанд ирж суухыг хүсэж байна. Тийм. Одоо энэ дахиад хүн ирцээс гарвал, ирцээс гарах тухай тийм дэг, тийм юу байхгүй. Тийм учраас одоо хэрвээ дахиад ирцээс гарна гэвэл энэ төрийн ажил гацна, бидний хэлэлцэж байгаа асуудал цаашаа явахгүй. Жаргалсайхан гишүүн. Та хэлэлцэж байгаа асуудалтай холбоотой л тодруулахаас өөрөөр, тэнд хариулт хэлсний дараа тодруулна. Жаргалсайхан гишүүн.

**Д.Жаргалсайхан:** Та бүхэнд өдрийн мэнд хүргэе. Энэ орон нутгийн хөгжлийн сангийн гүйцэтгэлийн тайлан ярьж байна. Орон нутгийн хөгжлийн сан үндсэндээ зарим сумууд дээр нөгөө ашигт малтмалын орлогоос, тэгээд татвартай холбоотой асуудлуудаас харьцангуй адилгүй байгаа. Газар нутаг, хүн ам, алслагдсан байдал гээд. Тэгээд яг сум дээр яваад очихоор нөгөө орон нутгийн хөгжлийн сангаар ажлуудаа хийчихсэн, тэгээд цаашид яг тийм шаардлагатай ажлууд, хийх шаардлагагүй ажлууд руу ингээд төсөв мөнгө их хуваарилдаг, үрэлгэн загнадаг ийм асуудлууд байгаад байгаа юм. Тэгээд хийж болохгүй ажлууд нь ингээд хуримтлагдчихсан байж байх жишээний. Тэгээд энэ тал дээр ямар санал санаачилга байдаг юм бол? Ер нь энэ орон нутгийн хөгжлийн санг үр ашигтай болох тал дээр гэсэн аудит ямар дүгнэлт байгаа вэ нэг дэх асуудал?

2-т нь тэр иргэдээс санал авах асуудал байгаа. Тэр үндсэндээ их учир дутагдалтай байгаад байгаа. Хэсэг бүлэгхэн хүмүүсийн шаардлагатай, бүүр энэ чинь хувийн өмч рүү эсхүл юу гэдэг юм нийтэд шаардлагагүй тийм ажлууд руу их зарцуулж байгаа асуудлууд байгаад байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ дээр ямар

зөрчлүүд хэр гарч байна вэ, энэ дээр ямар санал санаачилга байгаа юм бэ, ямар дүгнэлт гарсан юм бэ гэдэг асуудал байна?

Сургууль, цэцэрлэг гээд төсвийн байгууллагуудтай холбоотой асуудлууд дээр нэлээн төсөв зарцуулаад ... тийм боломж байгаад байгаа байхгүй юу. Гэтэл зөвхөн засвар гээд байж байгаа юм, засварт л зарцуулж болно гээд. Гэтэл тэр тухайн сургуульд маань хэрэглэгдэхүүнүүд их шаардлагатай байж байдаг. Ширээ, сандлууд, өөр сургуулийн тоног, төхөөрөмжүүд ч гэдэг юм уу. Тэгээд ийм зүйлүүд дээр зарцуулаад явах боломж нь хэр байдаг юм бол, энэ дээр ямар нөхцөл боломж байна вэ?

Дараагийн асуудал бид бүхэн 2026 оны аудитын төлөвлөгөө дээр нийслэлтэй холбоотой асуудлыг нэлээн ярьсан. Тэр тусмаа хэсгийн ахлагчтай холбоотой. Энэ яг төлөвлөгөөнд суугдаад, ажил нь явж байгаа юу?

Дараагийн асуулт бидний хувьд энэ тайлан гээд гаргаж орж ирж байгаа энэ дээр ер нь та бүхэн маань жилийн жилд ингээд л алдаа зөрчлүүд ийм, ийм зүйлүүд байна гээд. Өмнө жилээс энэ жилийн хувьд ямар үр ашиг буюу эсхүл дээшилсэн ч юм уу, эсхүл дордсон ямар дүгнэлт хийгдсэн бэ гэсэн ийм 3 асуулт байна. Асуултын дараа тодруулья.

**Н.Наранбаатар:** Хариулт, хэн хариулах вэ? 5 номерын микрофоныг нээе.

**С.Магнайсүрэн:** Жаргалсайхан гишүүний асуултад хариулья. Үндэсний аудитын газар Магнайсүрэн. Би сүүлээс нь эхлээд хариулж байя. 2026 оны төлөвлөгөөнд нийслэлтэй холбоотой асуудлууд Төсвийн байнгын хороогоор 26 оны сэдэв батлуулах үед гишүүд яриад, тэгээд холбогдох саналууд хураагдаад ингээд суусан. Энэ дотор бол хэд хэдэн асуудал байгаа. Орон нутгуудад шинэ хоршоотой холбоотой асуудал, нийслэл дээр газрын төлбөртэй холбоотой асуудал гээд, тэгээд бас Туулын хурдны зам энэ тэр гээд энэ сэдвүүд суусан. Энэ холбогдох яг цаглаврынхаа дагуу явж байгаа. Саяын таны ярьдаг тэр хэсгийн ахлагч нартай холбоотой асуудал бол одоо бид 4 сарын 25 гэхэд ерөнхийлөн захирагч нарын санхүүгийн аудитыг хийж дуусгана. Энэ үед ингээд санхүүгийнхээ чиглэлээр нэгтгэгдээд гараад ирнэ. Бид 5 сарын 5 гэхэд нэгтгэж Сангийн сайдын хэмжээнд нэгтгэж өгөх ёстой. 6 сарын 10-д гэхэд бид УИХ-д оруулж ирнэ. Энэ одоо бид шууд захирагчаа хийчихсэн, төрийн өмчтүүдээ хийчихсэн, төвлөрүүлэн захирагчдынхаа асуудлыг хийчихсэн. Одоо зөвхөн ерөнхийлөн захирагч нарынх 4 сарын 25-нд дуусна. Тэгэхээр энэ санхүүгийн цаглаварт хугацаанд хийж байгаа энэ аудитын хүрээнд саяын таны асуусан асуудал ингээд тодроод гарч ирнэ.

2 дахь асуудал нь бид орон нутгийн хөгжлийн сантай холбоотой нэгдсэн яг ийм сэдвээр энэ 24 оны асуудлыг нэгтгэж ингэж Байнгын хороондоо танилцуулж байгаа. Өмнө нь бол нөгөө саяын миний ярьдаг цаглаварт хугацаанд хуулийн дагуу жил болгоны нөгөө санхүүгийн аудитын хүрээнд аймаг аймагтаа үзэгдээд, ингээд аймгийнхаа нөгөө захирагчдын төсөв захирагчдын хүрээнд дүгнэлтэд ороод явчихдаг, тус тусдаа явдаг байсан бол энэ удаа ингээд нэгтгээд Байнгын хороонд танилцуулж байгаагаараа онцлог байж байгаа. Тэгээд бид бол тавьсан аудитын шийдэл буюу зөвлөмж дээрээ хэрэгжилтийг нь хангах чиглэлээр хуулийн хүрээнд холбогдох арга хэмжээг авч ажиллана.

Тэр сургууль, цэцэрлэгийн засвартай холбоотой, ер нь орон нутгийн хөгжлийн сангаас бол иргэдийн эрүүл мэндийг хамгаалах, боловсрол, соёл, инновац, шинжлэх ухаан, цахим технологийн асуудал, дэд бүтцийг сайжруулах асуудал, орчны тохижилт, ногоон байгууламж, байгаль орчны асуудал, ундны ус хангамж, эрүүл ахуйг сайжруулах асуудал, тэгээд сум, аймаг, хот, сум, дүүргийн нөгөө хөгжлийн төлөвлөгөө, ТЭЗҮ-тэй, төсөл, хөтөлбөрийн ТЭЗҮ, мөн бэлчээрийн менежмент, мал сүргийн чанар, үйлдвэрлэг байдлыг сайжруулах, малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүний чанарыг нэмэгдүүлэх, өрхийн орлогыг дэмжих чиглэлээр иргэдийг чадавхжуулах сургалт, мөн ажлын байр бий болгох гэсэн ийм чиглэлээр үндсэндээ орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хөрөнгийг зарцуулж байх ийм юутай дүрэм хууль дүрэм журамтай. Тэгэхээр энэ хүрээнд асуудлууд явдаг.

Боловсролын хүрээнд жишээлбэл энэ дотор иргэдийн эрүүл мэндийг хамгаалах, боловсрол, соёл, инновац, шинжлэх ухаан, цахим технологи гэж байгаа. Энэ хүрээндээ энэ боловсролын сайжруулах чиглэлээр жишээлбэл таны ярьж байгаа тоног төхөөрөмжтэй холбоотой асуудал тухайн аймаг орон нутгийнх нь хурал нь төлөвлөөд, иргэдийнхээ саналыг аваад, ингээд шийдээд явахад энэ дээр ямар нэгэн явах зүйлгүй, харшлах зүйлгүй, энэ хүрээндээ шийдэгдээд явчих бололцоотой байх гэж харж байна. Өөр чинь юу байлаа, болчихсон уу? Өмнөх онтой холбоотой, өмнөх онтой холбоотой зүйл нь болохоор зэрэг.../минут дуусав/

**Н.Наранбаатар:** Гүйцээж хариулъя.

**С.Магнайсүрэн:** 2022 онд 101,5 тэрбум төгрөг, 2023 онд 162,7, 24 онд 158,4 тэрбум төгрөгийн ийм зөрчлүүдийг бид нэгтгэж тавьж байсан юм байна. Тэгэхээр энэ бол яах вэ 23 онтойгоо харьцуулахад харьцангуй бага. Тэгэхдээ ер нь тэр түвшиндээ, ер нь өмнөх 22 онтой харьцуулахад нэлээд өссөн, эрс өссөн ийм байгаа. Төлбөрийн актын тухайд бид хэлсэн 75 төлбөрийн акт 24 онд тавьсан 956,2 тэрбум төгрөгийн, 8 асуудлыг бид 2,1 тэрбум төгрөгийн 8 асуудлыг хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн, 46 тэрбум төгрөг дээр зөвлөмж өгсөн 702 зөвлөмж, албан шаардлагыг 109,3 тэрбум төгрөг дээр дахиж ийм зөрчил гаргахгүй шүү, таслан зогсоогоорой гэдэг 613 албан шаардлага өгсөн байх жишээтэй.

**Н.Наранбаатар:** Тодруулах уу? Тодруулъя Жаргалсайхан гишүүн.

**Д.Жаргалсайхан:** Орон нутгийн хөгжлийн сантай холбоотой гүйцэтгэлийн тайлан бол бидний хувьд сайн ашиглаж чадахгүй, үр дүнгүй ажлууд их яваад байгаа. Тэгээд энэ дээр аудитынхан бол маш сайн орон нутагтайгаа хамтарч ажиллаж, үүрэг чиглэл өгч байхгүй бол бидний хувьд энэ бол бас нэг үр дүнгүй л их юмнуудыг зогсоох, бас үр ашигтай болгох асуудал байгаа.

Өнөөдрийн хуралдаан дээр нээлттэй биш байна гэдэг дээр манай гишүүд бол санал их гаргаж байна. Тэгээд санал хураалтад бол орж чадсангүй. Тэгэхдээ миний хувьд бол бас энэ нээлттэй байхыг хүсэж байна. Ер нь бидний хувьд бас нэг хэл ам ихтэй энэ том төслүүд бол Улсын Их Хурлын гишүүд, тэр тусмаа Төсвийн байнгын хорооны гишүүд бол мэдэж байх ёстой. Энэ бол нэг номерын асуудал. Тийм учраас өнөөдөр энэ хэлэлцэж байгаа асуудалтай холбоотой бол би бас ирцээс гармаар байна. Энийг бол эсэргүүцэж байна. Төсвийн байнгын хорооны гишүүдийг мэдэх эрхээр нь ингээд хязгаарлаж байгаад эсрэг байр суурьтай байна. Ирцээс гаргаж.../минут дуусав/

**Н.Наранбаатар:** Би хууль ирцээс гаргаж өгөх тухай асуудал байхгүй. Хууль уншиж өгье. Монгол Улсын Үндсэн хуулийн тодорхой заалтыг илтэд зөрчсөн асуудал хэлэлцсэн эсхүл Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахыг эсэргүүцэхээс бусад шалтгаанаар нам, эвслийн бүлэг, гишүүн хуралдаанд оролцохгүй байх буюу түүнийг орхиж гарахыг хориглоно л гэсэн юм. Гишүүд асуулт асууж дууслаа. Аудитын тайлантай холбогдуулан үг хэлэх гишүүд нэрсээ өгнө үү? Сайнзориг гишүүнээр, Батжаргал гишүүнээр тасаллаа. Сайнзориг гишүүн, Батжаргал гишүүн юм байна дарааллаар.

**Ж.Батжаргал:** Баярлалаа. Тэгэхээр орон нутгийн хөгжлийн сангийн энэ бүрдэлт, энэ сангаас хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээ, түүний үр дүнгийн асуудлыг бид онцгой анхаарах ёстой юм. Цаашид энэ орон нутгийн эрх мэдлийг нэмэгдүүлье, эдийн засаг, төсвийнх нь эрх чөлөөг сайжруулъя гэдэг талаар ихээхэн ярьж байгаа. Тэр ч битгий хэл энэ орон нутгийн хөгжлийн санд хуваарилагддаг хөрөнгө буюу АМНАТ-ийн орон нутгийн хөгжлийн санд нэгдсэн санд өгч байгаа 10 хувийг процентыг нь нэмэгдүүлье гэж байгаа. Тийм учраас энүүгээр хийгдэх хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажлын мөнгөн дүн нэмэгдэнэ. Тэгэхээр энэ рүү тавьдаг эрх зүйн зохицуулалт юмнуудаа илүү боловсронгуй болгож, төлөвлөлтийн шат, гүйцэтгэл, үр дүнгийнх нь асуудал руу нэлээн онцгой анхаарал хандуулсан эрх зүйн орчин бүрдүүлэх тал дээр нь Төсвийн байнгын хороо онцгой анхаарал хандуулж ажиллах ёстой. Тийм учраас би ер нь энэ Төсвийн байнгын хорооноос энэ асуудлыг хэлэлцсэнтэй холбогдуулж ЗГ-т түрүүн Сайнзориг гишүүн ч хэлнэ лээ тодорхой чиглэл өгч энүүнийг нэг анхаарах нь зөв байна гэдэг нэг ийм асуудал байгаа юм.

2 дахь зүйл би энэ шинэ тутам харилцаа зохицуулаад байгаа хуулиудын хэрэгжилт, үр дүнг ахиулах, үүнийг сайжруулах зорилгоор бид тодорхой арга хэмжээнүүдийг хийх ёстой болчихоод байна уу гэж ингэж ойлгоод байгаа. Энэ орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа тэр ААН, байгууллагууд нийгмийн хариуцлагын хүрээнд хийх гээд байгаа ажлаа орон нутгийн хөгжлийн сангаар нь дамжуулж хийж байхаар хуульчлаад өгчихсөн. Тэгээд энэ хуулийн хэрэгжилт, үр дүнг илүү сайн судалж үзэж, энэ чиглэл дээр авч хэрэгжүүлэх арга хэмжээ, хийх ажлынхаа чиглэл юмнуудыг их тодорхой болгох ёстой болов уу гэсэн ийм байр суурь байна.

Дараагийн нэг хэлмээр байгаа зүйл энэ орон нутагт олгож байгаа эрх мэдэл ер нь УИХ-аас тодорхой интервал дотор хувь хэмжээ тогтоох татварын ийм эрх хэмжээ өгчхөөд байгаа шүү дээ. Тийм учраас энэ Малын тоо толгойн албан татварын тухай хууль эд нарыг эргэж нэг нэлээн сайн харж үзэж, зүгээр аймгийн хэмжээнд нэгтгээд, аймгийн хурал аймгийнхаа түвшинд мөрдөгдөх тийм шийдвэр гаргачих нь ямар байдаг юм бол. Уг нь яах аргагүй энэ асуудал тухайн бүс нутаг, энэ бэлчээрийн даац, угаасаа МАА-н салбарын өөрийнх нь эдийн засгийн эргэлт, бүтээмж энэ юмнаасаа хамаарч тогтож байхаар л зүйлчилж өгсөн. Тэгэхээр үүнийг ер нь нягталж, зохистой болгох тал дээр нь Их Хурал анхаарлаа хандуулж ажиллах ёстой юм болов уу гэж. Би энэ талаас нь бодоод байна. Тэгэхийн тулд мэдээж дахиад ЗГ луу өгөх чиглэл дотроо энэ чиглэлийн асуудлыг оруулж, ер нь ямархуу байдлаар эрх мэдэл юмнуудыг нь зөв зохистой тогтоох юм гэж ингэж ойлгоод байгаа. Ер нь газар тариалангийн салбар, энэ МАА-н үйлдвэрлэлийн зөв хослолын асуудлыг яриад, судалгаа хийгээд үзэхэд улсын хэмжээнд тавхан сум малын нэг төрөл дээр яг татвар ноогдуулах дээд хязгаартаа тулгаж тогтоосон байдаг.../минут дуусав/

## **Н.Наранбаатар:** Сайнзориг гишүүн үг хэлнэ.

**П.Сайнзориг:** Ирцдээ орчхоод гараад явсан гишүүдээ уриалж байна. Орж ирээд хэдүүлээ ажлаа хийцгээе. Манай Наранбаатар дарга ер нь зөөлөн хүн л дээ, зөөлчлөөд байгаа юм уу, хуульд байхгүй шаардлага тавиад ингээд л Байнгын хорооны дарга руу дайрцаагаад байх юм. Тийм учраас гишүүдээ орж ирээд ажлаа хийцгээе гэж уриалмаар байна.

2 дугаарт хэдүүлээ нэг зүйлийг ойлгоцгоомоор байна. Эрх мэдлийн төвлөрлийг л уг нь сааруулна гэж маш олон жил яриад, энэ чиг үүргүүдийг шилжүүлэх асуудал зөвхөн хувийн хэвшил биш юм байна, орон нутаг руу шилжүүлэх, орон нутаг руу, аймаг руу, нийслэл рүү, сум дүүрэг рүү шилжүүлэх асуудал юм байна гэж л бид хууль баталсан. Тэгээд орон нутгийг энэ зам харгуйгаа барь гэдэг чиг үүргийг өгсөн. Энэ Нэгжийн тухай хууль хэрэгжээд 3, 4 жил болж байна шүү. Хуучин бүх зүйлүүдийг энд төвлөрүүлээд шийддэг байсан бол орон нутаг аж ахуйн нэгжийн орлогын албан татвар /ААНОАТ/ болон тодорхой орон нутгийн төсөвт ордог энэ татваруудыг зориулалтын дагуу ашигла гэдэг шаардлагыг бид тавиад байгаа шүү дээ.

Сая тэгээд ярьж л байна. Энэ Туулын хурдны зам дээр байгаа мөнгийг аваад тэтгэвэр нэмээч гээд. Замын хураамжийг чинь замд нь л зарцуулна гэдэг хуультай байхгүй юу. Хэдүүлээ ингээд нэг ийм попролтоор улс төр хийх энэ тэр амархан. Тэгэхдээ энэ өөрөө эргээд зориулалтын бус зарж байна уу, өөр зүйлүүдээс аваад ингээд санхүүжүүлээд байна уу гэдэг энэ тэр бол тусдаа асуудал байх.

2 дугаарт энэ барилга болон Замын тухай хууль, замын хууль тогтоомжтой холбоотой хуулиар энэ төсөвт өртгүүдийг нь тогтоодог Барилга хөгжлийн төвөөсөө эхлээд энэ Замын хөгжлийн төвүүд байж байгаа. Үнэхээр энэ асуудлуудыг мэдье гэвэл тийшээ ингээд албан бичгээ явуулаад ч юм уу, гишүүд мэдэж болно шүү дээ. Юмыг ингээд улс төржүүлэхдээ их гаргуу юм. Тэгэхээр хэдүүлээ нөгөө орон нутгийг энэ асуудлыг чи хариуц, төсөв мөнгөө гарга гэххээд одоо ингээд булаацалдаад яг Улсын Их Хурлын маань асуудал маань Нийслэлийн иргэдийн Хурал шиг ингээд л чиг үүрэг булаацалдаад, тийшээ гүйж ороод хутгалдаад ингээд явах юм. Тэгээд энэ маягаараа ер нь орон нутгуудад том төслүүдийг хэрэгжүүлэх бололцоо олгохгүй юм байна. Өмнөговь аймаг чинь бас 500 тэрбумын бонд босгочихсон эрчим хүчний эх үүсвэр барина гээд явж байгаа. Энэ дээр бас л хутгалдах юм байна. Болохгүй, хянаж шалгая.

Тэгэхээр хэдүүлээ нөгөө юм юманд нөгөө чиг үүргийн хэрчилт буюу энэ чиг үүргийг орон нутаг гэсэн бол эндээ хуулийн дагуу явж байгаа энэ үйл ажиллагаа дээр нь хуулийн хүрээндээ л энэ асуудлууддаа хандмаар байна. Үнэхээр тэр төсөв өртөгтэй нь холбоотой юмнуудаа бодвол тэр Барилга хөгжлийн төв байдаг юм уу, Замын хөгжлийн төв рүү нь албан бичгээ явуулаад л, эсвэл тэд нарыг дуудаад л энэ дээр нээлттэй сонсчхож болно шүү дээ. Ийм зүйлүүд байх юм. Тэгээд ер нь зүгээр бүх зүйлүүдийг ингээд УИХ татаж авч, хутгалдаж шийдэх ёстой гэж энэ явбал энэ улс төржилтийн энэ үймээн дунд чинь юу шийдсэн юм бэ сүүлийн 30 жил, том төслүүд яваагүй биз дээ? Яах вэ бид хэд том л гээд байна, асуудлууд нь хуримтлагдаад байгаа учраас томорчихсон болохоос биш энийг чинь аль дээр шийдсэн бол шийдэгдээд л явчих байсан асуудал.

Тэгэхээр бид хэд энэ орон нутгийн эрх мэдэл рүү хутгалдаж орж, энд УИХ биш Нийслэлийн иргэдийн Хурал болох гээд байгаа энэ зүйлүүдээ хэдүүлээ бас больё. Үнэхээр асуудал байвал тэр хүмүүсийг нь албаны хүмүүсийг нь дуудаад уулзаж, хэлэлцүүлгээ нээлттэй сонсох бүрэн бололцоо нь байна. Энэ зүйлүүдээ ингээд явах ёстой. Түүнээс биш бүх зүйлүүдийг энд мэднэ, энд шийднэ гэвэл энэ улс чинь 126 гээд ерөөсөө бүхнийг мэдэгч л болчихоод байна шүү дээ. Тэгэхээр орон нутгийн шат шатанд нь сонгогдсон, ард түмнээс сонгогдчихоод байгаа тэр төлөөлөгч чинь бас юу хийх юм бэ, тэр Нэгжийн хууль чинь юу болох юм бэ, Хот, тосгоны хууль чинь юу болох юм бэ, Төсвийн хууль чинь юу болох юм бэ. Бид хэд л өөрсдөө батлаад өгсөн шүү дээ, хэрэгжүүл гээд гээд үүрэг өгсөн. Тэгэхээр ийм зүйлүүд дээр улс төржихгүй, ингээд асуудал цаашдаа олонхоороо шийдээд явъя.

**Н.Наранбаатар:** Цогтбаатар гишүүн үг хэлнэ. Үг. Цогтбаатар гишүүний микрофоныг өгөөрэй. Цогтбаатар гишүүний микрофоныг өгөөрэй, хуруугаа уншуулах л юм. Гишүүд үг хэлж дууслаа.

11.39 цаг

### ***Гурав.Хүү, торгуулийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалтад хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан***

3 дахь асуудал. Төрийн аудитын байгууллагын гүйцэтгэсэн хүү, торгуулийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалтад хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг хэлэлцэж эхэлье. Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя. Сандагийн Магнайсүрэн Монгол Улсын Ерөнхий аудитор, Чойжилын Болд Нийслэл дэх Төрийн аудитын газрын ахлах менежер, Даваасүрэнгийн Даариймаа Нийслэл дэх Төрийн аудитын газрын ахлах аудитор.

Төрийн аудитын тухай хуулийн 33.6-д Монгол Улсын Ерөнхий аудитор энэ хуулийн 11, 12 дугаар зүйлд заасны дагуу гүйцэтгэсэн аудитын тайланг Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороонд хүргүүлнэ гэж заасны дагуу хүү, торгуулийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалтад хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороонд ирүүлсэн. Мөн Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 115.2.2 Төрийн санхүү, төсвийн хараат бус хяналтыг хэрэгжүүлэх хүрээнд төрийн аудитын байгууллагаас гүйцэтгэсэн аудитын тайлангийн дүгнэлт, зөвлөмж, түүний биелэлтийн талаарх тайланг Төсвийн байнгын хороо тухай бүр хэлэлцэнэ гэж заасан. Хүү, торгуулийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалтад хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг Монгол Улсын Ерөнхий аудитор Магнайсүрэн танилцуулна.

**С.Магнайсүрэн:** Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Хүү, торгуулийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалт сэдэвт гүйцэтгэлийн аудитыг аймаг, нийслэл дэх төрийн аудитын газрууд хийж гүйцэтгэн, аудитын тайлан, дүгнэлтийг Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороо, Сангийн яаманд хүргүүлээд байна.

Төрийн аудитын байгууллагаас 2023, 2024 онд хүү, торгуулийн орлогыг холбогдох хууль журамд нийцүүлэн бүрдүүлэн зарцуулж, хяналт хэрэгжүүлсэн байдалд хийсэн аудитын талаар товч танилцуулъя.

1.Хүү, торгуулийн эх үүсвэрээс 2023, 2024 онд нийт 322,7 тэрбум төгрөгийг төвлөрүүлэхээс 361,2 тэрбум төгрөгийн орлогыг төвлөрүүлж, орлогын 97,2 хувийг орон нутгийн төсөвт, 2,8 хувийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

2.Орон нутгийн төсөвт 2023, 2024 онд нийт 322,7 тэрбум төгрөгийн торгууль ноогдуулж, төлөвлөгөөгөө 101 хувиар биелүүлсэн нь өмнөх оны торгуулийн үлдэгдэл дараа онд төвлөрч байгаатай холбоотой байна.

3.Орон нутгийн төсөвт хүүгийн орлогыг 2023 онд 58,9 тэрбум төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 2 тэрбум төгрөг буюу 3,4 хувь, 2024 онд 56,3 тэрбум төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 23,1 тэрбум төгрөг буюу 41 хувь төвлөрсөн байна. Хүүгийн орлогын төлөвлөгөө 59-өөс 97 хувиар дутуу биелж байгаа нь ЗГ-ын гадаад зээлийн хөрөнгийг дотоодод дамжуулан зээлдүүлэх зээлийн гэрээнд заасан хүүгийн хувь хэмжээг үндэслэн эргэн төлөлтийн хуваарийг төлөвлөсөнтэй холбоотой байна.

4.Зөрчлийн тухай хуулиар ноогдуулсан торгуулийн орлогыг тухайн байгууллага зарцуулахгүй, орон нутгийн төсөвт төвлөрүүлэх хуулийн зохицуулалттай бөгөөд хүү, торгуулиас бүрдсэн орлогын тодорхой хувийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, авто замын засвар шинэчлэлийн ажилд зарцуулсан байна. Орон нутгийн төсөвт төвлөрсөн орлогоос гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд 55,9 тэрбум төгрөг буюу 15,9 хувь, авто замын санд 48,3 тэрбум төгрөг буюу 13,8 хувь, орон нутгийн төсвийн суурь орлогод 246,9 тэрбум төгрөг буюу 70,3 хувийг тус тус зарцуулжээ. Аудитаар нийт 32,3 тэрбум төгрөгийн зөрчил илрүүлж, үүнээс 2,9 тэрбум төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт, 12,4 тэрбум төгрөгийн зөрчилд 41 албан шаардлага, 17 тэрбум төгрөгийн зөрчилд 163 зөвлөмжийг шалгагдагч байгууллагад хүргүүлээд байна.

Төрийн аудитын байгууллагаас хүү, торгуулийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалтад хийсэн аудитаар дараах нийтлэг зөрчил илэрч байна. Үүнд 1.Сангийн яамнаас хянасан хүү, торгуулийн орлогын төлөвлөгөөг тухайн шатны ИТХ-аас бодит нөхцөл байдал, судалгаанд үндэслэлгүй, үндэслээгүй, харилцан адилгүй хувь хэмжээгээр өсгөж, бууруулж баталсан.

2.Орон нутгийн төсөв батлах, хуваарилах эрх бүхий байгууллагууд орон нутагт төвлөрүүлсэн хүү, торгуулийн орлогыг төсвийн орлогын нэр төрлөөр баталсан ч, сумдын түвшинд харилцан адилгүй, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиг үүргийг хэрэгжүүлэх төсвийг тухайн жилийн төсөвт хуваарилаагүй байна.

3.Авто замын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт нийслэл, орон нутгийн авто зам дээр хөдөлгөөний аюулгүй байдлын зөрчил гаргасан, авто замын талаарх хууль тогтоомжийг зөрчсөн этгээдэд ноогдуулсан торгуулийг Авто замын санд төвлөрүүлэхээр заасан ч хуулийн хэрэгжилт хангалтгүй байна.

4.Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд 2023, 2024 онуудад зарцуулсан 50,4 тэрбум төгрөгийн 8,2 хувь буюу 4,1 тэрбум төгрөгийг зориулалтын дагуу зарцуулаагүй байна. Тухайлбал эдийн засгийн ангилал хооронд шилжүүлж зарцуулсан, төлөвлөгөөнд тусгагдаагүй болон зохион байгуулалтын шинжтэй арга

хэмжээний зардал, тоног, төхөөрөмж худалдан авах, хоол, унааны зардлуудыг санхүүжүүлсэн тохиолдлууд байна.

5.Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар арилжааны банканд байрших данснүүдэд төвлөрсөн төлбөр төлөгч иргэн, ААНБ-ын нэр, данс, гүйлгээний утга, зориулалт нь тодорхойгүй, нийтэд зарлаагүй, зарласан хугацаа хэтэрсэн 2,9 тэрбум төгрөгийн мөнгөн хөрөнгийг улсын төсөвт төвлөрүүлээгүй байна.

6.Эрх бүхий байгууллагаас хяналт шалгалт зохион байгуулсан ч хүү, торгуулийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалтад тавих хяналтыг хангалттай хэрэгжүүлж чадаагүй байна.

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйл, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд, 1.Хүү, торгуультай холбоотой харилцааг зохицуулж байгаа зарим хууль, эрх зүйн актын уялдаа нийцлийг хангуулж, боловсронгуй болгох шаардлагатай. 2.Сангийн яамнаас хянасан хүү, торгуулийн орлогын төлөвлөгөөг тухайн шатны ИТХ-аас бодит нөхцөл байдал, судалгаанд үндэслээгүй, харилцан адилгүй хувь хэмжээгээр өсгөж, бууруулж баталж байна, баталсан. 3.Хүү, торгуулийн орлогоос гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд болон авто замын санд хуваарилах санхүүжилтийг дутуу олгосон, хуваарилсан хөрөнгийн 4,2 хувийг зориулалтын дагуу зарцуулаагүй нь нийгмийн хэв журмыг бэхжүүлэх, соён гэгээрүүлэх үндсэн зорилтын үр дүнг бууруулсан гэж үзэхэд хүргэж байна. 4.Байгууллага хоорондын мэдээллийн нэгдсэн сан бүрдээгүй, хүү, торгууль ноогдуулсан нэгж нэхэмжлэлийн дугаар тодорхойгүйгээс орлогын төлөвлөгөөний биелэлтийг байгууллага бүрээр гаргах боломжгүй байна. 5.Хүү, торгуулийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалтад тавих хяналт хангалтгүйгээс 321,8 тэрбум төгрөгийн хугацаа хэтэрсэн торгуулийн орлого төлөгдөөгүй байна.

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах зөвлөмжийг өгч байгаа.

Нэг.Сангийн яаманд, 1.хүү, торгуулийн орлого бүрдүүлэгч байгууллагуудын хооронд мэдээллийн санг бий болгож, хууль, эрх зүйн актын нийцлийг сайжруулан, үйл ажиллагааг нь нэгдсэн бодлогоор хангах. 2.Улсын төсөвт төвлөрч буй хүү, торгуулийн орлогыг харьяалах орон нутгийн төсөвт төвлөрүүлж, төрийн сангийн хүү, торгуулийн орлогын дансны эх үүсвэрийг ангилах. 3.Хугацаа хэтэрсэн торгуулийн үлдэгдлийг үе шаттайгаар барагдуулах арга хэмжээ авч ажиллах.

Бусад төсвийн ерөнхийлөн захирагч нарт дараах зөвлөмжийг өгч байна. 1.Хүү, торгуулийн орлого бүрдүүлэгч байгууллагуудын тооцоо судалгаа, зөрчлийн бүртгэл, нэгдсэн мэдээлэл, бодит нөхцөл байдалд тулгуурлан орлогыг төлөвлөх. 2.Хүү, торгуулийн орлогыг холбогдох хууль тогтоомжийг баримтлан хуваарилах, орлогыг зориулалтын дагуу зарцуулах. 3.Хүү, торгуулийн орлого төлөвлөх, бүрдүүлэх, хуваарилах, зарцуулах, хэрэгжүүлэх үйл ажиллагаанд холбогдох хууль тогтоомжийг чанд мөрдөж, хяналтын чиг үүргээ хэрэгжүүлэх зэрэг болно.

Төсвийн байнгын хорооны эрхэм гишүүд ээ, Хүү, торгуулийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалт сэдэвт гүйцэтгэлийн аудитын тайланг хураангуйлан танилцууллаа. Анхаарал тавьсанд баярлалаа.

**Н.Наранбаатар:** Магнайсүрэн даргад баярлалаа. Аудитын тайлантай холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. Цогтбаатар гишүүнээр тасаллаа. Цогтбаатар гишүүн асуулт асууя.

**Да.Цогтбаатар:** Баярлалаа. Энэ асуудалтай холбоогүй өмнөх асуудал дээр миний нэр ороогүй учраас өмнөх асуудалтай холбогдуулж ярих гээд байгаа юм. Орон нутгийн хөгжлийн сангийн төсөвтэй холбоотойгоор орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр иргэдийн саналаар дэмжигдээгүй, төлөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл, арга арга хэмжээг төлөвлөж, хэрэгжүүлдэг зөрчил 2023-аас 2024 онд нэмэгдсэн гээд ингээд дүгнэчихсэн байгаа юм. Тэгээд энэ дээр болохоор энэ аймгуудын орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагаанд иргэдийн санал өгсөн байдлыг сонгуулийн насны хүн амын тоотой нь харьцуулбал ер нь дунджаар нэг хамгийн ихдээ 30 хувь, 30 хувийн иргэд саналаа өгч байхад тэнчээ ажил явж байна. Бусад нь бүүр 10 хувьтай байгаа. Энэ жишээлэхэд Архангай аймагт бол сонгуулийн насны 30 хүн, 30 хувь нь саналаа өгөөд, тэгээд энэ арга хэмжээнүүд нь төсөл хөтөлбөр болоод яваад байгаа юм.

Тэгээд энэ орон нутгийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөхөд иргэд, олон нийтийн оролцоог хангах үйл ажиллагаа хангалтгүй, иргэдийн мэдлэг, мэдээлэл дутмаг, идэвх оролцоо бага байгааг нь далимдуулаад баахан ийм хулгай хийчихсэн байгаа юм. Жишээлэхэд энэ Баянхонгор аймагт аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр тэрбум 280 сая төгрөгийн 5 төсөл, арга хэмжээ, Баянговь сумд 1 төсөл, арга хэмжээ, Баянлиг сумд 221 сая төгрөгийн төсөл, арга хэмжээ, 2 нь зураг төсөвгүй, техникийн тодорхойлолт бүрэн хийгдээгүй, үндэслэлгүй боловсруулсан гэж байгаа. Тэгээд чанаргүй, дутуу гүйцэтгэлтэй төсөл, арга хэмжээ гэхээр Баянхонгор аймагт 2023-аас 24 онд жишээлэхэд анхан шатны баримтгүй, дутуу гүйцэтгэлтэй, техникийн тодорхойлолтод заасан шаардлагыг хангаагүй тоног, төхөөрөмжийг нийлүүлсэн, ажлын зураг төсвийн дагуу гүйцэтгээгүй, хийгдсэн ажлууд нь чанаргүй, дутуу байхад захиалагч байгууллагаас ямар нэгэн арга хэмжээ аваагүй, санхүүжилтийг нь олгосон ажлыг хүлээлгэн өгөөгүй, тэгээд чанар муу хийгдсэн шалтгаанаар ажлыг хүлээж аваагүй, ажил дутуу, зарцуулалтын тайлан, анхан шатын баримтгүй гээд. Энэ Өвөрхангай аймагт, одоо энэ Баянхонгор аймагт ингээд жишээлэхэд бодохоор 312 тэрбум төгрөг.

Тэгээд энэ Өвөрхангай аймаг дээр болохоор төсөл, арга хэмжээ чанаргүй хийгдсэн ажлуудыг техникийн тодорхойлолтоос зөрөөтэй, бараа дутуу нийлүүлэгдсэн 3,8 тэрбум төгрөг. Энэ Баянхонгор аймгийн Баян-Овоо суман дээр жишээлэхэд сонгуулийнхаа мөнгийг хийчихсэн байгаа байхгүй юу 2023 онд 800 сая төгрөгийн төсөвтэй ажил хийгээд, энэ гүйцэтгэгч компанийнх нь дансаар мөнгийг нь оруулаад сонгуульдаа аваад, мөнгөө хэрэглэчихсэн. Одоо энэ мөнгө нь дутуу дахиад явж байгаа гэх мэтчилэн энэ хулгайнууд дээр хэн хариуцлага хүлээх ёстой вэ? Уг нь би энд ЗГХЭГ гэдэг юм уу, энэ Монгол Улсын ЗГ-тай холбоотой албан тушаалтнууд нь орж ирээд аудиттайгаа цуг та нар зөв үнэлсэн, дутуу үнэлсэнгүй, болсон байна, болоогүй байна гэдгээ ярих юм бодсон чинь зөвхөн аудитынхан суугаад байгаа юм. Хариуцлага гэдэг нэг ч юм байхгүй. 1 минутаа нэмээд авч болох уу дарга?

**Н.Наранбаатар:** Тодруулга, нэмж 1 минут өгье.

**Да.Цогтбаатар:** Хариуцлага гэдэг ойлголт ерөөсөө Монгол Улсад байхаа больчихсон. Энэ улаан намын цагаан байрныханд хариуцлага ерөөсөө үйлчлэхээ больчихсон. Энэний тод илрэл нь энэ аудит нэг арай худалдагдчихаагүйгээр үнэнээр тайлан бичиж орж ирээд байх шиг байгаа юм. Ямар ч хариуцлага байхгүй, бүгдээрээ дээр, дооргүй хулгай. Бид энэ Туулын хурдны зам дээр чинь хулгай орчхоод байгаа юм биш үү, ил тод ярилцъя гэхээр ажлын хэсэг байгуулж өгдөггүй. Байнгын хорооны дарга нь хулхидаж байгаад энэ Улсын Их Хурлын гишүүдээ чуулганд оруулж ирээд, ирцийг нь бүрдүүлэнгүүтээ хурлаа хийгээд яваад өгдөг.

Энэ дараагийнх нь асуудал дахиад энэ Гадаадын зээлийн ашиглалтыг нэмэгдүүлэх хууль гээд орж ирнэ. Тэгэхээрээ өмнөх Төсвийн байнгын хороон дээр байхгүй байсан асуудлаа дахиад оруулаад ирчихсэн, Сэлбэ дээр дахиад хулгай гарах гэж байна. Сангийн яамны сайд нь өөрөө барилгачин байж энэ барилгын дэд төв дээр энэ Сэлбэ дээр Сангийн яамны саналаар юм уу, яаж байгаа юм, дахиад мэдэхгүй ингээд хулгай хийх гэж л оруулж ирээд байдаг тэр хуулийг нь одоо бид баталж өгөөд байдаг ийм нөхцөл байдал хавтгайрах гэж байна. Энэ дээр аудитын байгууллага одоо би энэ хэнтэй хариуцлага ярих ёстой юм бэ энэ дээр хариулт өгөөч.

**Н.Наранбаатар:** Цогтбаатар гишүүн миний нэрийг дурдсан учраас тайлбар хэлье. Та хуралдаа суух үүрэгтэй шүү, Улсын Их Хурлын гишүүн хуралдаа суух ёстой. Та ардаа олон ард түмнийг төлөөлж, олон сонгогчдыг төлөөлж ирсэн бол хуралдаа суух ёстой, үүрэгтэй шүү, ажлаа хийх ёстой шүү та. Таныг хулхидаж оруулж ирээд байсан юм байхгүй шүү, та суух үүрэгтэй шүү. Танаас би дэг сахихыг шаардах эрхтэй шүү. Дэгээрээ ажлаа хийх ёстой шүү та, хуралдаа суух ёстой шүү. Би хуралдааны дэг сахиулах эрхтэй шүү. Магнайсүрэн дарга хариулт, ажлын хэсгийн 5 номер.

**С.Магнайсүрэн:** Цогтбаатар гишүүний асуултад хариулъя. Үндэсний аудитын газар Магнайсүрэн. Өмнөх асуудал дээр бид нэлээн дэлгэрэнгүй ярьсан. Энэ удаагийн аудитаар бид 158,5 тэрбум төгрөгийн зөрчил илрүүлж, 1 тэрбум төгрөгийн 75 төлбөрийн акт тогтоосон, 109,4 тэрбум төгрөгийн зөрчилд 613 албан шаардлага, 46 тэрбум төгрөгийн зөрчилд 702 зөвлөмж, 2,1 тэрбум төгрөгийн 8 асуудлыг хууль хяналтын байгууллагад шилжүүлэхээр ингэж шийдэл нь, аудитын шийдлийн нэгтгэл гарсан байж байгаа. Саяын таны ярьсан алдаа зөрчлүүд манай тайлан дээр энэ ялангуяа Баянхонгор аймгийн холбогдох энэ дурдагдсан асуудлууд орсон.

Саяын энэ гараад байгаа зөрчлүүдтэй холбогдуулаад бид ингээд аймаг, хуучин аймаг, аймаг дээрээ ингээд нөгөө хуулийн хугацаанд хийх цаглаварт хугацаат хийгддэг санхүүгийн аудитын хүрээнд орон нутгийн хөгжлийн сангууд ингээд сан тэр аймаг аймгийнхаа ерөнхийлөн захирагч дээр ингээд нэгтгэгдээд явдаг байсан бол энэ удаа бид бүх аймгийнхаа нэгтгээд, Дархан-Уул аймаг дээр нэгтгэж авчирч байгаад ингээд нэгтгэл тайлан танилцуулж байгаагаараа онцлог байгаа. Тэгээд энэ хүрээндээ холбогдох зөвлөмж, шийдлүүдээ сая танилцуулсан. Ингээд Байнгын хороон дээр ЗГ-т холбогдох чиглэл өгөх ийм тогтоол шийдэл гаргахаар сая яригдаж ингэж дууслаа. Тийм учраас энийг би зөв бай, энэ холбогдох асуудлуудыг шийдэх нь зүйтэй байх гэсэн энэ юутай санал нэг байгаа юм. Тэгээд энэ аудитын шийдвэрийн хэрэгжилтийг хангах асуудлаар бид онцгойлон анхаарч ажиллана. Ер нь тэгж ажиллаж байгаа, цаашдаа ч гэсэн энэ асуудал дээр онцгойлон

анхаарч ажиллана. Таны саяын дурдсан асуудлуудаар би тусгайлаад танд явцын мэдээллийг ингээд өгөөд явъя гэж бодож байна. Баярлалаа.

**Н.Наранбаатар:** Цогтбаатар гишүүн тодруулъя.

**Да.Цогтбаатар:** Сая Байнгын хорооны дарга Туулын хурдны зам дээр эдийн засгийн үр ашиг, төсөвт өртөг, ТЭЗҮ-д хяналт тавих, шалгалт хийх ажлын хэсэг байгуулъя гэдэг энэ асуудлыг хэлэлцэх юм байна л гэж бодож байгаа шүү дээ. Хуралдаа цагтаа ирж орж байгаа. Та бол МАН-ын бүлгийн дарга биш, та надад ямар үг хэлэх, юу гэж ярихыг заах эрхгүй. Баянхонгор, Өвөрхангай, Архангай аймгийн 3 аймгийн хангайн бүсийн тойргийн сонгогчид сонгоод нааш нь явуулчихсан юм. Тэгээд ингээд ил тод юмаа ярь гэхээр чи тэгж хэл, ингэж хэл гээд байх юм. Бид үгээ хэлмээр байна. Тэгээд бид энд ажлын хэсэг байгуулах гэж байна, гишүүн нь болж ажилд нь ороод, энийг чинь яг энэ нийслэлийн иргэдийн мэдэх эрхийг нь хангая гэхээр та нар албан ёсоор зохион байгуулалттай угаагаад гаргачхаж байгаа биз дээ. Тэгээд энэ чинь тоглоом байна гэж хэлээд сая Батсуурь гишүүн, Алтанхуяг гишүүн бүгдээрээ энийг чинь эсэргүүцээд л гарлаа шүү дээ. Та яагаад энэ Байнгын хорооныхоо хурлыг зарчмынх нь дагуу.../үг тасрав/

**Н.Наранбаатар:** Та хэлэлцэх асуудалтай холбоотой үг хэлэх ёстой. Гишүүд асуулт асууж дууслаа. Аудитын тайлантай холбогдуулан үг хэлэх гишүүд нэрсээ өгье? Батжаргал гишүүнээр тасаллаа. Батжаргал гишүүн.

**Ж.Батжаргал:** Хүү, торгуулийн орлогын бүрдүүлэлт дээр тодорхой аудит хийгээд, тайлан дүгнэлт орж ирж байгаа юм. Тэгэхээр бид энэ авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээнүүдийн уялдааг нь гэдэг юм уу, гүйцэтгэлийн үр дүнг нь бүрэн хангаагүй зохицуулалтууд хийгээд байгаа нь ажлын үр дүнд муугаар нөлөөлөөд байгаа юм. Хүү, торгуулийн орлогыг машинд уншуулчихаад, тэгээд тэр нь шууд тухайн тавигдаж байгаа хүний данснаас хасагдаад, төсвийнхөө данс руу ордог энэ үйл явц нь байхгүй. Энэ чинь яг нарийндаа энэ тээврийн хэрэгслийн торгууль ч гэдэг юм уу, энэ юмнууд чинь үндсэндээ бүгд замын хураамж энэ тэрүүд чинь тэр шалган нэвтрүүлэх дээрээ, уг тээврийн хэрэгслийг дахиад өөрийнх нь данстай холболт өгчихсөн тэндээсээ хураамж, тэр торгууль бүх юм нь орох ёстой газрууд руугаа гүйгээд ордог энэ нэг систем юмнуудыг бид бүрэн нэвтрүүлэхгүйгээр энэний үлдэгдлийн тухай асуудал ярих боломжгүй.

Тийм учраас энэ хуримтлагдсан үлдэгдлүүдийн асуудал гараад байгаа юм. Тэгэхээр үүнийг Төсвийн байнгын хороо анхааралдаа авч, ер нь улсын хэмжээнд нэгэнт бид энэ мэдээлэл технологийн гэдэг юм уу, энэ системийг өргөн хүрээтэй нэвтрүүлж, аль болохоор иргэдэд чирэгдэлгүй, хүндрэлгүй байх нөхцөлийг бий болгож байгаа бол зөрүүлээд үүнийг ер нь төгс байж болох тэр арга механизмыг нь уяж өгөхгүйгээр энэ явах боломжгүй гэдгийг 1 дүгээрт хэлмээр байна. Үүнийг анхаармаар байна гэж.

2 дугаарт энэ хүү, торгуулийн орлогоос тэр Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 19.2-оор урьдчилан сэргийлэх арга хэмжээ рүү зарцуулдаг хөрөнгүүд байгаад байгаа юм. Үүнийг ер нь тэр хуулийнх нь заасан хэмжээнд гаргаж өгөхгүй байгаад байгаа юм. Тийм учраас энийг цаашид энэ төлөвлөлтийн шатад нь хянаж, хангуулах. Асуудал үүсчихсэн хойно хэн нэгэнд арга хэмжээ авдаг гэдэг юм уу торгодог биш, тэрнээс иргэдээ урьдчилан сэргийлэх, мэдлэгжүүлэх, мэдээлэлжүүлэх, энэ сэрэмжлүүлэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээнүүдээ өргөн

хүрээтэй хийх бололцоо боломж, түүнд чиглэгдэх хөрөнгийнх нь хэмжээг бүрэн гүйцэт ашиглах тухай асуудал байгаад байгаа юм. Үүнийг ер нь нэлээн сайн онцгой анхаарал хандуулах ёстой. Ийм байдлаар энэ ярьж байгаа асуудлыг үр дүнтэй болгох ёстой гэж.

Төгсгөлд нь би нэг зүйлийг хэлье. Энэ УИХ гэдэг асуудлаа олон талаасаа ярилцаад, олонхынхоо шийдвэр дээр тулгуурлаж шийдвэр нь гарч байдаг, түүнийгээ дагадаг ийм л үйл явц шүү дээ. Энэ ажлын хэсэг байгуулах асуудлыг УИХ дахь МАН-ын бүлэг дээр огт яригдаагүй. Энд ямарваа нэгэн бодлогын гэдэг юм уу, янз бүрийн юм хайрцаглагдаагүй. Ажлын хэсэг байгуулъя гэж санаачилга гаргасан гишүүн нь өөрөө ажлын хэсэгт ийм гишүүд байх юм байна гэдэг юмаа мэргэжлийн Байнгын хороотойгоо яриад л оруулж ирсэн зүйл юм билээ шүү дээ. Тийм учраас энэ дээр хэн нэгнийг буруутгаад байх боломжгүй. Тэр тусмаа нэг нам руу энийг наах гэж оролдоод хэрэггүй. Бүгдээрээ өөд өөдөөсөө хараад суугаад, өөр өөрсдийнхөө байр суурь, үзэл бодол дээр тулгуурлаад саналаа л өгч байгаа. Тэр нь олонх, цөөнхөөрөө асуудал нь ялгараад л гарч байгаа. Тийм учраас энэ дээр ийм байдлаар хандмааргүй байна. Асуудлаа ярьж байгаа.../минут дуусав/

**Н.Наранбаатар:** Гишүүд тайлантай холбогдуулан үг хэлж дууслаа. Хүү, торгуулийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалтад хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг хэлэлцэж дууслаа.

12.00 цаг

***Дөрөв.Гадаад зээллэгийн ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлэх тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Н.Алтаншагай нарын 21 гишүүн 2025.12.12-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/***

Дараагийн асуудалдаа орьё. Гадаадын зээллэгийн ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлэх тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг хэлэлцэж эхэлье. Ажлын хэсгийг оруулъя. Ажлын хэсгийг танилцуулъя. Ерэн-Өлзий Эрчим хүчний яам /ЭХЯ/-ны Төрийн нарийн бичгийн дарга /ТНБД/, Дэлгэржаргал Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга, Хишигдалай Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Газрын тосны бодлогын газрын дарга, Гантогтох Сангийн яамны Өрийн удирдлагын хэлтсийн дарга, Ганзориг Сангийн яамны Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга, Үнэнбат НЗДТГ-ын Хууль тогтоомж, гэрээ, эрх зүйн газрын дарга, Эрдэнэбадрах НЗДТГ-ын Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга, газрын дарга, Чинзориг Монголын газрын тос боловсруулах үйлдвэр төрийн өмчит компани /ТӨК/-ийн Гэрээ, эрх зүйн газрын дарга, Мөнх-Эрдэнэ Монгол газрын тос боловсруулах үйлдвэр ТӨК-ийн Технологийн албаны дарга гэсэн ийм хүмүүс байна.

Нэгдсэн хуралдаанаар Гадаад зээлийн ашиглалт, үр ашиг нэмэгдүүлэх тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг явуулах үед олонхын дэмжлэг авсан зарчмын зөрүүтэй саналыг хуулийн төсөлд нэмж тусган, төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн хувилбарыг та бүхэнд тараасан. Хуулийн төслийн эцсийн хувилбарын төсөлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу? Гишүүд нэрээ өгье. Батжаргал гишүүнээр тасаллаа. Энхтүвшин гишүүн асуулт асууна.

**Д.Энхтүвшин:** Энэ гадаад зээллэгтэй холбоотой хэлэлцүүлгүүд, энэ хуулийн хэлэлцүүлэг эхнээсээ зохион байгуулалттайгаар Байнгын хорооны гишүүдийг

төөрөгдүүлсэн байдалтайгаар ингэж явж ирсэн, арга заль хэрэглэж ирсэн. Ер нь энэ Сэлбэ дэд төвийг хасчихсан, ажлын хэсэг дээр Сэлбэ дэд төвийг хасчихсан байж байгаад, ажлын хэсгийн саналыг дэмжиж явж байгаад өөрөөр хэлбэл энэтэй холбоотой ямар ч хэлэлцүүлэг явагдаагүй, энэ хасагдсан байна гээд. Тэгээд энэтэй холбогдуулаад зарим нэг зүйл, заалтуудад өөрчлөлт оруулах гэсэн боловч тайлбарлаж чадахгүйгээр тэрийгээ авч үлдэнэ гэж гүрийсээр байгаад аваад үлдсэн. Тэгээд чуулганы хуралдаан дээр Улсын Их Хурлын гишүүдийг лоббидчихоод энэ заалтыг буцаагаад оруулж ирсэн.

Тэгэхээр энэ заалттай холбогдолтой тодорхой яг байр сууриуд илэрхийлсэн байгаа. ЗГ-ын хуралдаанаас энэ Сэлбэ дэд төвтэй холбоотой асуудал байна төсвийн зардлыг, сахилга батыг алдагдуулах юм байна. Энэ хувийн хэвшлийн оролцоог бууруулж, төрийн оролцоог нэмэгдүүлэх юм байна. Макро эдийн засгийн тогтворгүй байдалд бас нөлөөлөх юм байна. Төсвийн тогтвортой байдлын зөвлөл дээр энэ Сэлбэ дэд төсөл яагаад хамрагдах үндэслэл ерөөсөө харагдахгүй байна. Нийтийн санхүүгийн энэ тогтолцоог өөрчилж байгаа учраас төсвийн бодлогын орон зай цаашдаа гаргаж энийг анхааруулах ёстой болохоос энэ төсөл Сэлбэ дэд төвтэй холбоотой төслийг оруулах шаардлагыг ерөөсөө харахгүй байна гэдэг асуудал яригдсан байгаа юм. Энэ тогтоол хуулийн энэ судалгаан дээр ч гэсэн ер нь бол энэ төслүүд төрийн оролцоотой төслүүд маш их цаг хугацаа алддаг, өртөг зардал нэмэгддэг гэдэг асуудлууд яригдсан, гүйцэтгэл нь дутуу байдаг.

Тэгэхээр энэ шийдэл нь өөрөө төсвийн хүрээнээс гаргаж, төсвийн энэ хязгаарлалтуудаас гаргаж байгаа нь бол яг энэ асуудлыг шийдэж чадахгүй байгаа. Тэгэхээр энэ судалгаа нь ч гэсэн, үндэслэлүүд нь ерөөсөө хангагдахгүй ийм төслийг арга заль хэрэглэж байгаад буцаагаад оруулж ирж байна. Тэгэхээр энэ төслийг бол Сэлбэ дэд төвийг хасах ёстой гэж бодож байгаа. Хэрвээ хасахгүй бол энэ хуулийн төслийг эсэргүүцэх, энэ хуулийн төслийг унагаах чиглэлээр ажиллана гэж бодож байна.

Ажлын хэсэг дээр ч гэсэн, ажлын хэсгийн даргаас асуухад ерөөсөө асуултад хариулж чадахгүй, Сангийн яам хариул гээд. Тэгээд одоо энэ ямар ч нэрдээ таарахгүй заалт хүртэл сүүлд нь оруулаад ирчихсэн, тэрийг өөрчлөн найруулж нэг юм орж ирсэн байна. Хаанаас орж ирсэн нь мэдэгдэхгүй, Сангийн яам би оруулж ирээгүй гэж байхад нэг заалт гэнэт оруулаад ирсэн гэх мэтчилэн ингэж болохгүй. Би нийслэлд одоо яг хэлье. Та нарт ер нь энэ төсөлтэй холбоотой авлигал, хулгайн талаар аль хэдийн яриад эхэлчихсэн байгаа, хамжигчид болно шүү. Яг зохион байгуулалттайгаар энэ хуулийн Сэлбэ дэд төвийг оруулж ирэхийг нийслэлийн хамааралтай гишүүд бол яг зохион байгуулалттайгаар хийж энийг босгож ирсэн. Би жишээлбэл нийслэлийн удирдлагуудад туслах үүднээс хэлж байна. Та нар яг энэ төслөөс болж дараа нь эрүүгийн хариуцлагад оногдохоор ийм хэмжээний асуудал болно шүү, тагнуул.../минут дуусав/

**Н.Наранбаатар:** Хариулт, нэмж тодруулах уу? Ажлын хэсгийн ахлагч Алдаржавхлан гишүүний микрофоныг өгье, хариулъя. Алдаржавхлан гишүүний микрофоныг нээе.

**Ж.Алдаржавхлан:** Манай Энхтүвшин гишүүн хэтэрхий их тийм кино шиг юм бодоод байх шиг байна. Тийм юм болоогүй. Би анхнаасаа энэ төслийг хасах асуудлыг хотын даргатай ярьж, бид 2 зөвшилцсөн. Ер нь хасъя гэдэг дээр байр сууринд нэгдсэн. Би өөрөө ч одоо эцсийн хэлэлцүүлэг хүртэл ийм бодолтой байгаа.

Тухайн үед би яах вэ хоцорч орж ирэх үеэр энэ санал хураалт явчихсан байсан. Тэгээд манай хэд маань хэтэрхий их нарийн бодож, төлөвлөсөн ажил мэтээр яриад байгаа юм. Тийм зүйл байхгүй.

Ер нь зүгээр энэ Сэлбийн асуудал дээр одоо ч гэсэн та хэд маань байр сууриа илэрхийлэх нээлттэй шүү дээ. Ер нь тэр яагаад ажлын хэсгийн ахлагчийн тайлбарлаж чадахгүй байсан гэдэг, тэрийг чинь бид хангалттай тайлбарласан. Зээллэг гэдэг үг яагаад орох ёстой вэ гэдэг асуудал дээр манай Сангийн яамныхан, Их Хурлын гишүүд хангалттай тайлбар өгсөн шүү дээ. Тэгээд өөрт чинь таалагдахгүй тайлбар өгчихлөөр тайлбар биш, болохгүй байж болохгүй л дээ. Ямар ч байсан миний хувьд анхнаасаа энэ төсөл дээр хасах саналтай явсан. Тэрийгээ би тухайн үед хотын даргатай ярьж оруулсан.

Энэ 3 дугаар саналын хувьд Их Хурлын гишүүдээс санал гарсан учраас бид яг өөрчлөн найруулсан. Одоо энэ заалтыг чинь шууд хасчхаж болохгүй юм байна лээ. Шууд буцаж татаж болохгүй юм байна лээ эцсийн хэлэлцүүлгийн явцад. Одоо бидэнд үлдсэн ганцхан арга нь юу вэ гэвэл энийг өөрчлөн найруулах. Өөрчлөн найруулахдаа ерөнхий болгож энэ хуульд айхтар зөрчилдөхгүйгээр бид өөрчлөн найруулж оруулж байгаа юм. Тэрнээс биш өөр санаа байхгүй.

**Н.Наранбаатар:** Энхтүвшин гишүүн тодруулъя.

**Д.Энхтүвшин:** Энэ төсөлтэй холбоотой тэгвэл асууя. Энэ төслийн санхүүжилт нийтдээ 18 мянга орчим айлын орон сууц бий болгохоор тооцсон байгаа. Тэгэхээр энэ жилдээ Монголчууд бид 19 мянга орчим, 20 орчим мянган айл орон сууц барьдаг. Тэгэхээр энэ зах зээл дээр маш том нийлүүлэлт болно. Тэгэхээр энэ гэрээ гүйцэтгэгчдийн бараг талаас илүү нь Хятадын компаниуд байгаа. Тэгэхээр энэ талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгөөч энэ гүйцэтгэл дээр?

Дээр нь санхүүжилт, энэ бондтой холбоотой, энэ метр квадрат талбайн өртөгтэй холбоотой, яг энэ гүйцэтгэлээ хангаж чадах эсэх талаар мэдээлэл өгөөч? Өмнө нь энэ чиглэлийн бизнесүүд яг гүйцэтгээд хийж байсан, харьцуулсан судалгаа юм байдаг бол тэрийгээ өгөөч, тэгээд энэ бондын төлөлтүүдээ яаж хийх гэж байгаа юм бэ энэ талаар тодорхой мэдээлэл өгөөч? Одоо болтол үүсчихсэн бонд дээр ямар хэмжээний хүүгийн зардал, алдагдал хүлээж байгаа энэ талаар бас мэдээлэл өгөөч?

**Н.Наранбаатар:** Ажлын хэсгийн ахлагч Алдаржавхлан гишүүн хариулъя.

**Ж.Алдаржавхлан:** Энэ бид угаасаа нийслэлийн төслийг миний бидний хувьд анхны хэлэлцэх эсэх дээр ажлын хэсэг дээр хассан учраас энэ тухай мэдээллийг ажлын хэсэг гүнзгийрүүлж аваагүй. Тэрийг хүсвэл нийслэлийн төсөл хариуцсан улсууд өгч болно.

**Н.Наранбаатар:** Ажлын хэсэг нийслэлээс хариулъя. Ажлын хэсгийн 6 дугаар микрофоныг нээе, нэр, албан тушаалаа хэлээд хариулна.

**Л.Эрдэнэбадрах:** Энхтүвшин гишүүний асуултад хариулъя. Нийслэлийн Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Эрдэнэбадрах. Сэлбэ дэд төсөл маань нийтдээ 8500 гаруй орон сууцын төсөл. Энэ төсөл маань бид 2024 нийслэл 500 сая долларын гадаад бондыг олон улс, нийслэл анх удаа гадаад бонд гаргаж, 24 онд

амжилттай арилжаалж, бид гадаад бонд босгосон байгаа. Гадаад бонд энэ төсөлтэй холбоотойгоор 2025 онд 303 тэрбум төгрөгийн гүйцэтгэл гарсан байгаа гэсэн үг. Үлдэгдэл мөнгийг нь яасан юм бэ гэхээр бид системийн банкнуудад хүүтэйгээр хадгалсан байгаа. Өнгөрсөн жилийн хувьд авч үзвэл 199,5 тэрбум төгрөгийн хүүгийн орлого олсон. Бид бондын төлбөр, хүүгийн зардалд бид 2025 онд 104 тэрбум төгрөгийн.../минут дуусав/

**Н.Наранбаатар:** Гүйцээж хариулъя.

**Л.Эрдэнэбадрах:** Тэгэхээр бид хэд тухайн 500 сая долларыг 7,75 хувийн хүүтэйгээр, 3 жилийн хугацаатай босгосон, 2027 онд энэ төлөгдөхөөр байгаа. Энэ мөнгө маань 2027 онд бид энэ Сэлбийн борлуулалтын орлогоос төлнө гэж төлөвлөөд ингээд тооцоод ингээд явж байгаа. Энэ жилийн хувьд авч үзвэл Сэлбэ дэд төв дээр бид тооцоогоор гүйцэтгэлээр 1 их наяд төгрөгийн гүйцэтгэл гарна гээд төсөөлөөд явж байна. Тэгэхээр 2026 он гарснаар гүйцэтгэл гараагүй, барилгын ажил 20 хувийн, 22 хувийн гүйцэтгэлтэйгээр ингээд эхлээд явж байгаа учраас бид гүйцэтгэл бол хүлээгдэлтийн байдалтай одоогоор байна.

**Н.Наранбаатар:** Энхтүвшин гишүүн тодруулъя.

**Д.Энхтүвшин:** Энэ 500 сая долларын бонд, ЗГ-ын баталгаа гаргаж энэ гаргасан бонд дээр ЗГ-ын 24 биш ээ, Улсын Их Хурлын 24 оны 17 дугаар тогтоол дээр түгжрэлийг бууруулах зорилгоор гэсэн байгаа. Тэгэхээр яг энэ төсөл түгжрэлийг хэмжиж байгаа оргил ачааллын үе дэх энэ машины хурд хэд болж, яг энэ төсөл хэрэгжсэнээр хэд болж буурах юм бэ гэдэг мэдээлэл өгөөч? Дээр нь орон сууцны метр квадратын өртөг хэд болох юм гэдэг дээр мэдээлэл өгөөч?

**Н.Наранбаатар:** 7 номерын микрофоныг нээж өгье.

**М.Үнэнбат:** Энхтүвшин гишүүний асуултад хариулъя. Нийслэлийн Хууль тогтоомж, гэрээ, эрх зүйн газар Үнэнбат. Энэ төсөл маань бол 20 минутын хот концепцын хүрээнд 8500 айлын орон сууц баригдана 1 дүгээрт. 2 дугаарт юу байна вэ гэхээр энэ бол агаар, орчны бохирдол нийслэлд тулгамдаад байгаа асуудлуудыг 1 дүгээрт шийдэж байгаа. 2 дугаарт энэ 2024 оны төсвийн тухай хуульд УИХ-аас гадаад зээл гаргах эрхийг нь аваад, ЗГ-т энэ хууль, журмын дагуу оруулаад, тэгээд өрийн хэрэгслийн дагуу гадаадын энэ бонд, бондоор энэ зүйл санхүүжүүлж явж байгаа. Тэгэхээр өнөөдрийн хэлэлцэгдэж байгаа хуулийн бас нэг зорилго юу байна вэ гэхээр энэ, өнөөдрийн байдлаар 4 сая 250 мянган төгрөгийн тооцоолол гарчихсан байгаа 1м2-ын үнэ нь. Тэгэхээр бид бүхэн тэгэхээр энэ үнээрээ худалдан борлуулна гэсэн тооцоололтой ажиллаж байгаа. Энэ өртөг тооцохын тулд гишүүнээ энэ чинь.../минут дуусав/

**Н.Наранбаатар:** Асуултаа нэмээд тодруулаад, товч, тодорхой тэр өртөг асуусан байна шүү дээ. Түгжрэлийг хэрхэн бууруулах юм, хэдэн хувиар бууруулах юм, хэдэн нэгж доошлох юм гээд товч, тодорхой хариулаадах. 7 номерын микрофоныг нээгээд өгчихье.

**М.Үнэнбат:** Энэ түгжрэлтэй холбоотой зохицуулалтын хүрээнд та асуулаа. Ер нь 20 минутын хот концепцын хүрээнд 5 сургууль, 3 цэцэрлэг, тэгээд энэ төрийн үйлчилгээний байгууллагууд тэнд төвлөрөх юм. Тэгэхээр энэнтэй холбоотой авдаг, энэ яг түгжрэл бууруулахтай холбоотой энэ тоог нь танд яг ингээд бүүр баримт

тоотойгоо эргээд албан бичгээр танд хүргүүлэе манайхаас. Метр квадратын өртгийн тухай та гишүүнээ одоо энэ чинь газар чөлөөлөлтийн зардал, дээрээс нь одоо орж байгаа барилгын материалын үнэ, тэгээд тэрнийх нь, тэгээд бондын хүү эд нарыг бүгдийг нь тооцсон бүр нарийвчилсан задаргаа танд хүргүүлэе. Яг одоо би бол тэдэн төгрөг байна гэж хэлэхэд би энэ чинь учир дутагдалтай болоод байна.

**Н.Наранбаатар:** Ажлын хэсэг уг нь тооцоо судалгаатай орж ирэх ёстой, тэгээд тооцоо судалгааг бичгээр хүргүүлэх хэрэгтэй байна. Батжаргал гишүүн асуулт асууна.

**Ж.Батжаргал:** Гадаадын зээлийн ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлэх тухай хууль орж ирж байгаа юм. Энэ нэг удаагийн үйлчлэлтэй, тодорхой нэр бүхий төслүүд дээр. Тэгэхдээ үүнийг цаашид бид ингэж явууламгүй байна. Энэ Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Төсвийн тухай хууль, Өрийн удирдлагын тухай хууль гээд энэ хуулиуддаа оруулах ёстой өөрчлөлтүүдээ оруулаад, үнэхээрийн үйл ажиллагааныхаа үр дүнгээр анхны авсан хөрөнгөө нөхчих ийм томоохон улс орны эдийн засаг, нийгмийн амьдралд үр нөлөөтэй төслүүдийг ЗГ хоорондын зээлийн хэлэлцээрээ соёрхон батлаад л, манай Хөгжлийн банк нь тэр улсынхаа банктай гэрээгээ хийгээд л, тэгээд л гүйцэтгэгчээ сонгон шалгаруулаад л, ажлаа явуулдаг энэ зарчим руугаа орохгүй бол болохгүй байна. Тэгэхээр үүнийг би Сангийн яамыг, Эдийн засаг, хөгжлийн яамыг анхааралдаа авч, энэ Төсвийн хүрээний мэдэгдэл өргөн барихдаа энэ асуудлуудаа шийдэж оруулж ирэхгүй юу гэдэг нэг ийм зүйлийг зориуд хэлмээр байна.

2 дахь зүйл энэ үнэхээрийн энэ улс орны эрх ашигт нэн тэргүүнд шаардлагатай байгаа 2 том төслөө дагуулаад арилжааны хэлбэрээр явчхаж болохоор төсөл оруулж ирээд ингээд асуудал үүсгээд байх юм. Орон сууцны хороолол энэ тэр байгуулах учиртай. Тэнд бид дулааны гэдэг юм уу, эрчим хүчний гэдэг юм уу эх үүсвэр, дэд төвүүдийг нь хийж өгөөд, инженерийн шугамуудыг нь хийж өгөөд, бусад нь арилжааны хөрөнгөөрөө л явах ёстой шүү дээ энэ. Нийслэл энэ бондын хөрөнгөө тэгвэл тэр нийслэлийнхээ Орон сууцны корпорац руугаа өгөөд л, тэндээсээ ипотекийн зээл хэлбэрээрээ гаргаад л, энэ төслийнхөө хэрэгжилтийг хурдасгачхаж болно шүү дээ уг нь бол. Тэгэхээр энд барилга барих мөнгийг нь энд хийгээд оруулах гээд ингээд улсуудын гишүүдийн байр суурийн зөрүү үүсгээд баймгүй байгаа байхгүй юу энэ үнэхээрийн.

Тийм учраас одоо энэ нэг гуя дагаж хүзүү гэдэг шиг юм хиймгүй байгаа юм. Үүнийг ер нь бид нэлээн хатуу барьцгаах ёстой. Тийм учраас би магадгүй энэ гишүүд байр сууриа илэрхийлж, энийг 2/3-дож авах ёстой гэж ойлгоод байгаа. Угаасаа суурь дэд бүтэц, дэд төв нь хийгдчихсэн юм бол үүн дээр бид хөрөнгө гаргах гээд байдаг нь ямар учиртай юм. Болохгүй шүү дээ энэ чинь. Энэ төрийг чинь жоохон энэ бизнес арилжаа юмнаас нь холдуулж, хувийн хэвшлийнхээ орох оролцоо юмыг нэмэгдүүлэе, ингэж байж хувийн хэвшлүүдээ босгож ирье гэж ярьцгаагаад байгаа биз дээ. Тэгэхээр баялаг бүтээгчдийн мөнгөөр эргэн төлөгдөх, өртөг зардлыг нь нөхөх ийм бондын хөрөнгө босгож байгаад тэрийгээ буцаагаад хэвийн арилжааны хэлбэрээрээ явж болдог чиглэлүүдийг санхүүжүүлэх гэж оролдож байгаа.../минут дуусав/

**Н.Наранбаатар:** Асуулт уу? Ажлын хэсгийн ахлагч Алдаржавхлан гишүүний микрофоныг өгье.

**Ж.Алдаржавхлан:** Яг л бид тантай санал нэг байсан учраас ажлын хэсэг хассан юм. Тэгээд харамсалтай нь өчигдөр, өнгөрсөн 5 дахийн чуулган дээр босчихсон шүү дээ. Ажлын хэсэг хасаж оруулсан, байр суурь нэг байгаа. Би өөрөө хоцроод ирсэн юм. Тэрнээс хойш хардлагад орчхоод байгаа, энэ Энхтүвшин, Батболд энэ тэрийн хардлагад орчхоод байгаа.

**Н.Наранбаатар:** Өөр асуулт бий юу нэмж? Мөнхбаясгалан гишүүн асуулт асууя.

**Л.Мөнхбаясгалан:** Энэ Гадаад зээлийн ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлэх тухай хууль гээд энийг би анхнаасаа дэмжиж явсан хууль. Учир нь манайх 13 их наядын зээл соёрхон баталсан байдаг. Энэнээс 6,2 нь зөвхөн Алтанширээгийн газрын тосны үйлдвэр дээр авсан зээл байхгүй юу. Энэний 4,7-г нь бид ашиглаж чадахгүй байна гээд бодит байдал дээр энэ тодорхой төслүүд нь шууд үр ашгаа өгөх, зээлээ нөхөх, стратегийн ач холбогдолтой гэж оруулж ирсэн. Гэтэл нөгөө талд чинь Дамдинням сайдаар ахлуулсан Монгол Улс агаарын хөлгийн түлшээ Оросын Холбооны улсаас авах 15 жилийн гэрээ ороод ирж байгаа юм. Өнөөдөр энд Дамдинням сайд байхгүй. Тэгвэл бид өнөөдөр энэ газрын тосны үйлдвэрээр яах гэж байгаа юм бэ? 2028 оны 1 дүгээр улиралд энэ газрын тосны үйлдвэр чинь ашиглалтад орох ёстой. Бид Энэтхэгийн Эксим банкнаас 6,2 их наяд шүү дээ, энэ Монголын 30 жилийн түүхэнд байгаагүй өндөр өртөг бүхий зээл байхгүй юу. Энийг ашиглая гэж энэ хууль чинь орж ирж байгаа юм.

Дээрээс нь Эрдэнэбүрэн орж ирж байгаа юм. Тэгэнгүүт Нямбаатар залилангаа хийгээд, Сэлбэ дэд төвийг дундуур нь шургуулаад оруулаад ирж байгаа байхгүй юу. Тэгээд өнөөдөр Оросын Холбооны улстай 15 жилийн гэрээ байгуулаад, агаарын хөлгийн түлшээ тэндээс авбал 100 хувь дотоодынхоо агаарын хөлгийн түлшийг хийх ёстой, үүрэгтэй, жилдээ 80 мянган тонн түлш гаргах хүчин чадал бүхий энэ газрын тосны үйлдвэрээр яах гэж байгаа юм манайх? Нэг бол тэр Оросын Холбооны Улстай агаарын түлш 15 жилээр авах тэр хэлэлцээрээ зогсоо, нэг бол энэ Алтанширээгээ одоо боль. 6,2 их наяднаасаа зарцуулж чадаагүй 4,7 их наяд нь үлдчихсэн байгаа юм бол одоо зогсоо л доо. Яагаад биднийг ингэж зээл төлүүлэх гээд байгаа юм бэ Монголын ард түмнээр? Ёстой нөгөө бурангуй засгаас үнэнийг хайснаас бударгана хайсан тэмээ хөөвөл төсөр гэдэг шиг юм болоод байгаа байхгүй юу.

Нэг талдаа худлаа яриад, нэг талдаа худлаа яриад. Аль нь залилан юм. Би энийг Дамдиннямыг байвал асуумаар байгаа юм. Бид агаарын хөлгийн түлшээ Оросоос 15 жилээр авбал тэрүүгээр яах юм бэ, энэ үйлдвэрээр яах гэж байгаа юм бэ яг үнэндээ? Одоо 4,7-гоо буцаа л даа. Тэгэхээр өмнөөс ийм юм ярьдаг юм санамж бичиг үйлдчихсэн юм, тэгээд үйлдвэр маань 28 оны 1 дүгээр сард ашиглалтад орчихвол бид энэ УИХ-аар соёрхон батлуулсан зээлээсээ болих юм гэнэ. Үгүй ээ, УИХ-аар соёрхон баталсан зээл гэдэг чинь нэг, баталсан гэрээ гэдэг чинь нэг өөр, санамж бичиг чинь тэрэнтэй яагаад ч дүйхгүй. Тэгэхээр Монгол Улсад өнөөдөр газрын тосны үйлдвэр хэрэгтэй юм уу, хэрэггүй юм уу? Эсвэл Оростой заавал энэ 15 жилийн гэрээг батлах ёстой юм уу, аль нэгийг нь зогсоо. Тэгэхгүй бол энэ яг залилан болж байгаа юм. Нямбаатарын залилангийн төсөл ороод ирчихсэн дээрээс нь. Одоо мэдээгүй байсан чинь ороод ирчихлээ гэдэг юм ярьж байгаа байхгүй юу. Энэ хуулийг.../минут дуусав/

**Н.Наранбаатар:** Асуулт уу? Алдаржавхлан гишүүн, ажлын хэсгийн ахлагч хариулж болно, Сангийн сайд хариулж болно. Аль нь хариулах уу? Мэндсайхан сайд хариулъя.

**З.Мэндсайхан:** Энэ хууль их ач холбогдолтой хууль Мөнхбаясгалан гишүүнээ. Та энийг бас дэмжиж анх гарын үсэг зурсан гишүүдийн нэг. Газрын тос, Эрдэнэбүрэнгийн үйлдвэрийн энэ УЦС 2-ын энэ жил ашиглах гэж байгаа зээлийнх нь хэмжээ хүсэлт нь 1,8 их наяд байгаа юм. Төсвийн тухай хуулиараа бидний энэ жилийн гадаад зээлийн ашиглах хэмжээ 1,2 их наяд. Тэгэхээр энэндээ багтахгүй байгаа учраас бид энэ хуулийг өргөн барьсан.

Таны ярьж байгаа газрын тосны үйлдвэрийн ОХУ-тай гэрээ хийгээд бид ашиггүй болох гээд байна гэж. Энэ газрын тосны үйлдвэр стратегийн хувьд маш ач холбогдол бүхий үйлдвэр, дотоодын дизель, бензиний 55 хувийг хангана. Би яриагаа дуусгачихъя. Онгоцны түлшний 80 мянгыг үйлдвэрлэх хүчин чадал бүхий суурь хүчин чадал нь. Өнөөдрийн манай хэрэглээ 85 мянга байгаа. Цаашдаа энэ хэрэглээ чинь өсөөд явна. Тэгэхээр бид агаарын тээврийн эрсдэлгүй, найдвартай байдлыг хангах үүднээс түлшний хувьд бид найдвартай эх үүсвэр байх ёстой. ОХУ-аас бид өөрсдөө дотооддоо 80 мянга дээд тал нь максимумдаа 80 мянгыг үйлдвэрлэхэд илүү гарснаа бид Оросоос аваад явна. Түүнээс биш юу гэдэг юм 80-ыг үйлдвэрлээд энэ агаарын тээвэр чинь тэлэхгүй, өсөхгүй гэсэн салбар биш шүү дээ. Энэ жилийн суурь хэрэглээ нь л 84 байгаа. Манай үйлдвэрийн чинь дээд хүчин чадал 80 байхгүй юу. Тэгэхээр энэ агаарын салбарын чинь хэрэглээ цаашдаа өсөн нэмэгдээд явна. Тэр хүрээндээ бид ОХУ-аас аюулгүй энэ иргэний нисэхийн агаарын тээврийнхээ аюулгүй баталгаатай байдлыг л хангах үүднээс энэ гэрээг хийж байгаа.

**Н.Наранбаатар:** Мөнхбаясгалан гишүүн тодруулъя. Мөнхсоёл гишүүнийг асуултад нэмчхээрэй.

**Л.Мөнхбаясгалан:** Мэндсайхан сайдаа та яг ойлгоод мэдэж байгаа юм яриад байгаа байхгүй юу. Би наад газрын тосны үйлдвэр дээр чинь ажлын хэсэг ахалсан, ямар ач холбогдолтойг мэднэ. 26 онд 84 мянган тонн агаарын түлш хэрэгтэй гэдэг тооцоо гарсан. Тэр соёрхон батлуулах гээд байгаа хэлэлцээр дээр чинь 80 мянга Монголоосоо аваад, Газрын тосны үйлдвэр ашиглалтад орчихвол 4 мянга Оросын Холбооны Улсаас авна гэсэн нэг ч үг, өгүүлбэр байхгүй, эдийн засгийн үр ашгийн тооцоо нь байхгүй. Тэгээд би хэлээд байна шүү дээ. Газрын тосны үйлдвэр чинь хэрэгтэй юм бол өнөөдөр энэ хуулиа батал, тэр хэлэлцээрээ зогсоох ёстой байхгүй юу. Эсвэл тэрэндээ өөрчлөлт оруул, ингэж л яриад байгаа шүү дээ. Тэрнээс би энэ үйлдвэрийг мэдэхгүйдээ яриад байгаа юм биш, наадхыг чинь мэдэхийн дээдээр мэднэ. Анх дэмжиж байсан гишүүдийнх нь нэг. Би эндээс Сангийн сайд, Алдаржавхлан 2-оос юм асуумааргүй байна. Яагаад гэвэл бид санал нэг байна. Би гол нь Дамдиннямаас энэ асуудлыг ярих ёстой. Үгүй ээ харин тийм. Тэгээд одоо бид яах юм бэ, байхгүй хүн нь тэгээд, үгүй, үгүй энийг.../минут дуусав/

**Н.Наранбаатар:** Мөнхсоёл гишүүн асуулт асууя.

**Б.Мөнхсоёл:** Ийм байгаад байна одоо энэ асуудлыг бүгдээрээ эцэслэн хэлэлцэх энэ шат руугаа орж байгаа шүү дээ. Тийм, эцсийн хэлэлцүүлэг. Тэгээд төдийгөөс өдий хүртэл нэлээн ярилцсан, ажлын хэсгийнхэнтэй ч ярилцсан, ажлын хэсэг дараа нь бас ярьсан. Тэр 3 гол төслийг л дэмжих гээд энэ тусгай хууль гараад байгаа шүү дээ. Анх хэлэлцэхэд л хэлсэн. Уг нь одоо байгаа хууль, зарим нэг

хуулийг зөрчих гээд байгаа, Төсвийн тогтвортой байдлын хуулийн дүрмүүд энэ тэр гээд. Гэтэл нөгөө талдаа энэ гадаадаас зээл, тусламжаар босгосон мөнгөө үрж чадахгүй ийм нөгөө дүрэмдээ баригдаад ийм байдал байгаад байдаг. Бүүр 3 дахь зүйл нь юу вэ гэхээр тухайлбал Энэтхэгийн Элчин сайд нь Төсвийн байнгын хорооны гишүүд, даргатай ингээд уулзаж ярилцаад, учраа хэлээд, инженер, техникийн ажилтнууддаа цалингаа өгч чаддаггүй гээд.

Нөгөө УЦС дээр болохоор бас энэ одоо та нар ажлаа явуулахгүй бол зогсооно шүү, бүх гарах гарц, хохирол, бусад хариуцлагаа Монголын тал өөрсдөө үүрээрэй гээд нөгөө хадны завсар хавчуулагдсан халиуны зулзага хөөрхий гэдэг шиг болчихоод, ядаж энэ үедээ бол тийм, энэ үедээ бол энийг дэмжье гэх маягтай ингээд байнгын тулж хэлэлцээд, наана, цаана саад тотгор, буруу, зөвийг нь ингээд тааруулаад хасаад, засаад явж байтал сая өнгөрсөн чуулган дээр 3 төслийн 1-ийг тэр Сэлбийн дэд төвийн түшиглээд байгаа тэр Гэр хорооллыг орон сууцжуулах төсөл нь ажлын хэсэг дээр зөвшөөрөөд бүгдээрээ олон гишүүд зарчмын зөрүүтэй санал гаргаад хасахаар байсан чуулган дээр миний нэрээр орсон, уначихдаг байна шүү дээ. Тэгээд ийм сонин байдалтай байгаад, ажлын хэсэг дээр, Төсвийн байнгын хороон дээрээ ярьсан зүйлүүдээ хийхгүй болохоор гишүүдийн итгэл алдраад, одоо бүүр ингээд нийтээрээ буцах ч юм шиг ийм байдалтай болчихоод байна шүү. Хаана хаанаа чухал, хариуцлагатай ажиллахгүй бол болохгүй. Зориуд хэлье, протоколд үлдээе. Энийг маш нухацтай хэлэлцсээр ирсэн.

Ер нь Монголын алдаа юу вэ гэхээр уялдаа холбоо муу, нэг талдаа нэг, нөгөө талдаа нэг юм хийгээд хоорондоо зөрчилтэй юм маш их байдаг. Өчигдөр ч гэсэн Их Хурлын ЗГ-ын гаргасан тогтоолын байдал дээр, хэрэгжилтийн байдал дээр хяналт үнэлгээ хийсэн тайланг харахад юу вэ маш олон зөрчил байна лээ шүү дээ. Давхардуулж тогтоол гаргадаг л гэнэ, гарсан тогтоолоо мэддэггүй, дахиж гаргадаг, эсвэл хэрэгжүүлдэггүй, утгагүй, больчихсон юмыг дахиж сэргээж гаргадаг гээд аймаар энгийн алдаанууд аягүй их хийсэн. Энэ улс эх оронд дандаа яригддаг, тайлан болгоны үнэлгээ дээр яригддаг тэр алдаа зөрчлүүд давтагдсаар байгаа. Одоо дахин, дахин яриад байлтай биш, засах л гарц байна. Шинэ ЗГ маш нухацтай ажиллах байх л гэж найдаж байна. Хийх ажил үнэхээр их байна.

**Н.Наранбаатар:** Тодруулж тайлбар хэлэх үү, үгүй юү? Ажлын хэсгийн ахлагч Алдаржавхлан гишүүн.

**Ж.Алдаржавхлан:** Мөнхсоёл гишүүний асуулт, санал байлаа. Ер нь зүгээр гишүүдэд хэлэхэд ажлын хэсэг бол өргөн баригдсан хуулийн хүрээнд л ажилласан. Тэр Дамдинням гишүүний өргөн барьсан хууль, хөөцөлдөж байгаа асуудалд ажлын хэсэг хамааралгүй. Яг өргөн баригдсан хуулийнхаа хүрээнд ажилласан шүү л гэж.

**Н.Наранбаатар:** Мөнхтулга гишүүн асуулт асууна.

**П.Мөнхтулга:** Энэ хуулийн гол зорилго нь энэ жил бид 1,8 их наядын ажил гүйцэтгэчихье гэхээр Төсвийн хууль маань үгүй ээ 1,2-оор л ажил хийе гээд. Тэгээд зөрөө мөнгөн дээрээ бид хүү дээрээ идүүлээд байгаа учраас нэгэнт энэ зээллэгүүдийг хэдүүлээ бизнесийнх нь зарчмаар явуулъя гэдэг, ажлыг хурдасгая гээд. Хөрөнгө оруулалт бол хэдээр орохоосоо илүүтэйгээр хэзээ орох нь их чухал байдаг. Тэгэхээр энэ хуулийн ерөнхийдөө санаачилга нь зөв байгаа юм.

Гэхдээ санаа зовж байгаа нэг асуудал байна. Газрын тосны боловсруулах үйлдвэр дээр очиж ажилласан, сая 500 мянган тонныг боловсруулах хүчин чадалтай үйлдвэр. 1-д сая 500 мянган тонн нөгөө түүхий эд, түүхий нефть маань хаана байгаа юм бэ? Бид эндээс Гадаад зээллэгийн ашиглалтын үр ашгийг нэмэгдүүлэх тухай хууль гээд эндээс төсвийн хүрээнээс нь гаргаад өгөөд байдаг, боломжоор нь хангаад байдаг, бодлогоор нь дэмжээд байдаг. Гэтэл яг газар дээрээ 2028 оны 1 сар гэдэг боломжгүй харагдаж байна лээ ажлын явц. Дээрээс нь түүхий эдийн нөөцөө хаанаас бүрдүүлэх нь ерөөсөө тодорхойгүй. Тамсагаас авна гэж байгаа. Тамсагаас дээд тал нь 700 орчим мянган тонн л гарах болов уу л гэж бодож байгаа. Тэгтэл тэр чинь цаашаагаа дахиад Хятадуудын хэрэглээ нь байгаа. Тэгэхээр ийм нөхцөл байдалтай хууль дээр бид эндээс дэмжээд л байдаг, зээл аваад л байдаг. Гэтэл яг нөгөө үйлдвэр маань бодит амьдрал дээр баригдаж дуусах уу, энэ бүтэлтэй төсөл үү, үгүй юү гээд. Тэгэхээр энэ дээр бидний салбарын нөхдөөс нь хариулт авмаар байгаа юм газрын тос дээр.

**Н.Наранбаатар:** Ажлын хэсгийн 5 дугаар микрофон.

**У.Чинзориг:** Монгол газрын тос боловсруулах үйлдвэр, Гэрээ, эрх зүйн газрын дарга Чинзориг. Гишүүний асуултад хариулъя. Тэр түүхий эд тосны хангамжийн асуудлыг манай төсөл хэрэгжүүлэгч нэгжийн зүгээс яалт ч үгүй л төсөл хэрэгжиж эхэлсэн цагаас хойш л энэ асуудлыг төр засгийн түвшинд тавьж ярьж ирсэн. Энэ бидний хувьд бас их санаа зовж байгаа асуудлын нэг мөн, яалт ч үгүй мөн. Бид өнөөдөр төсөл хэрэгжүүлэгч нэгжийн зүгээс бид өнөөдөр энэ үйлдвэрийг хугацаанд нь ашиглалтад оруулах тийм л зорилготой ажиллаж байгаа. Яг энэ хангамжтай холбоотой асуудлыг салбарын яамнаас нь бас танд илүү зөв хариулна гэж бодож байгаа.

2 дугаар асуултын хувьд өнөөдөр үйлдвэрийн төсөл ЕРС, нийт 4 ЕРС гэрээний хүрээнд хэрэгжиж байгаа. ЕРС-1 гэрээ амжилттай дуусаад 24 онд ашиглалтад орчихсон явж байгаа. Одоо яг ЕРС-2, 3-ын болон 4 дүгээр багц ажлын гэрээнүүд хэрэгжээд явж байна. Өнөөдрийн байдлаар үйлдвэрийн барилга угсралтын ажил 50 гаруй хувьтай ингээд амжилттай хэрэгжээд явж байгаа. Төр засгийн удирдлагууд байнга үйлдвэрийн талбай дээр очиж ажиллаж байгаа. Ноднин гэхэд сүүлд гишүүд очсон. Энэ жил гэхэд ноднинтой харьцуулбал үйлдвэрийн барилга угсралтын ажлын явц нэлээд нүдэнд үзэгдэхүйц, харагдахуйц ахиц гарсан байгаа. Ингээд үйлдвэр 26 он, 27 он гээд үндсэндээ 2 жил, 28 онд ашиглалтад орно гэсэн төлөвлөгөөтэйгөөр ингээд энэ 3 жилийн хугацаанд энэ бүтээн байгуулалтын ажлыг, барилга, угсралтын ажлыг маш шахуу түлхэж ажиллана.

Энэ дээр ч гэсэн Энэтхэгийн ЗГ болон гүйцэтгэгч компаниас маш их анхаарал хандуулж, чухал ач холбогдол өгч байгаа. Тэгэхлээр энэ хугацаанд, энэ богино хугацаанд энэ их ажлыг хийж гүйцэтгэхэд энэ зээлийн зарцуулалт дээр ямар нэгэн хязгаарлалт байж болохгүй. Үйлдвэрийг яг л төлөвлөсөн байдлаар нь ашиглалтад оруулаад л, энэ ажлаа төлөвлөсөн хувьтайгаар нь гүйцэтгэл гаргаад л, зарцуулалтаа хийгээд л явбал үйлдвэр хугацаандаа ашиглалтад орох ёстой. Тэгэхлээр энэ хууль батлагдсанаар энэ хязгаарлалтыг үгүй болгож, бидэнд энэ үйлдвэрээ хугацаанд нь ашиглалтад оруулах энэ боломжийг өгнө гэж бид төсөл хэрэгжүүлэгч нэгжийн зүгээс үзэж байгаа юм. Баярлалаа.

**Н.Наранбаатар:** Тодруулъя Мөнхтулга гишүүн.

**П.Мөнхтулга:** Тэгэхээр та бол гэрээ, эрх зүйн асуудал хариуцсан хүн байна. Анхнаасаа энэ төсөл чинь түүхий эдээ хаанаас авах нь тодорхойгүйгээр баригдчихсан гэж ойлгох уу? Танай Монгол газрын тос боловсруулах үйлдвэр компани чинь түүхий эдээ хаанаас авахаа мэдэхгүй, бид зөвхөн энэ барилгыг нь л барих үүрэгтэй гээд. Тэгээд анхны ТЭЗҮ дээр чинь сая 500 мянган тонноор хийчхээд, одоо тэгээд түүхий эдээ хаанаас авахаа мэдэхгүй байна гэдэг чинь юу гэсэн үг вэ?

2-т нь танай талбай дээр очиж ажилласан. Монгол ажилчид байхгүй, 800 гаруй Энэтхэгүүд ажил хийж байна. Би танай Энэтхэг компанийн захиралтай уулзсан. Энэ маягаар танай төсөл явахгүй, хугацаандаа амжихгүй. Тэгэхээр Монгол компаниудыг туслан гүйцэтгэгчээрээ аваад, тэртээ тэрэнгүй энэ үйлдвэрийг Монголчууд.../минут дуусав/

**Н.Наранбаатар:** Тодруулъя, нэмж хариулъя, 5 номер.

**У.Чинзориг:** Монгол газрын тос боловсруулах үйлдвэр, Гэрээ, эрх зүйн газрын дарга Чинзориг. Гишүүний асуултад нэмж хариулъя. Юуны бид түүхий эдээ хаанаасаа авах гэж байгаа, авахаа мэдэхгүйгээр төсөл эхлүүлнэ гэж тийм юм байхгүй гишүүнээ. Тухайн үед 17 онд энэ үйлдвэрийг Энэтхэгийн зээлийн хөрөнгийг ашиглаж, төслийг хэрэгжүүлнэ гэсэн шийдвэр гарсны дагуу ТЭЗҮ 18 онд хийгдэж, батлагдсан. Энэ үйлдвэрийн хүчин чадал бол тухайн үеийн зах зээлийн мэдээлэл, мөн тухайн үеийн газрын түүхий тосны олборлолт, ашиглалтын тоо хэмжээн дээр үндэслэж, суурилж гаргасан л, тэрний дагуу л энэ төсөл ингээд хэрэгжээд явж байгаа юм.

2 дугаар асуудлын хувьд.../минут дуусав/

**Н.Наранбаатар:** Нэмээд хариулъя гүйцээж.

**У.Чинзориг:** 2 дугаар асуултын хувьд яах вэ ер нь ЕРС-1 хүрээнд, ЕРС-1 нь иргэний барилга байгууламжууд бол орсон, ажлын цар хүрээнд орсон. Энэ дээр Монголын туслан гүйцэтгэгч компаниуд, Монгол ажилтнуудыг нэлээд түлхүү оролцуулсан. ЕРС 2, 3, 4 бол ялангуяа энэ технологийн барилга байгууламжуудын ашиглалт, барилга угсралтын хувьд яалт ч үгүй гаднаас нарийн мэргэжлийн инженер, техникийн ажиллагсад шаардлагатай. Бидний зүгээс мэдээж Монголын талын оролцоо, Монгол компаниудаа оролцуулаад энд явуулах тийм шаардлагыг Энэтхэгт байнга тавьж байгаа.

**Н.Наранбаатар:** Тодруулъя Мөнхтулга гишүүн.

**П.Мөнхтулга:** Тийм юм байхгүй гээд орхичихлоо. Би яг хаанаас авахыг нь асуугаад байгаа юм. 700 мянган тонныг Дачин Тамсагаас гаргаж магадгүй. Тэгэхдээ талыг нь тэр хилийн цаана байгаа Хятад үйлдвэрүүд чинь хэрэглэх юм байна лээ. Бүрэн хүчин чадлаараа ажиллаад, ажиллаад манай үйлдвэрт 400 мянган тонныг өгвөл өгнө одоогийн байгаа нөөц чинь. 1 сая 500 мянган тонныг бид хаанаас түүхий эдээ авах юм бэ? Тэр чинь ТЭЗҮ дээр чинь байх ёстой, та тэрийг хариуцсан мэргэжилтэн, тэрийг л надад хариулаад өгчих гээд байгаа шүү дээ? Тэгээд бид эндээс баахан зээл аваад, ингээд хүү төлөөд, үйлдвэр бариад байдаг, түүхий эд нь байхгүй болчихоод байна. Тэрийг ТЭЗҮ дээрээ яаж тусгасан юм бэ яг тодорхой хэлээдэхье.

**Н.Наранбаатар:** Товч, тодорхой хариулна шүү, битгий тойруулаад байгаарай.

**У.Чинзориг:** Монгол газрын тос боловсруулах үйлдвэр, Гэрээ, эрх зүйн газрын дарга Чинзориг. Гишүүний асуултад нэмж хариулъя. ТЭЗҮ-ээр, ТЭЗҮ 18 онд батлагдсан, 23 онд бол тодотгол нь орсон. ТЭЗҮ-ээр бол үйлдвэрийн түүхий эдийг бол Тамсаг Тосон-Уулаас авна гэсэн тийм төлөвлөгөөтэй явж байгаа.

**Н.Наранбаатар:** Гишүүд асуулт асууж, хариулт авлаа. Чуулганы нэгдсэн хуралдаанаар хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42.2.1-д заасны дагуу гүйцээн боловсруулах чиглэл өгсөн 1 зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт явуулна. Саналын томьёоллыг уншиж танилцуулъя. Дуудаад л байна. Байнгын хорооны гишүүд санал хураалт хийх гэж байгаа тул хуралдааны танхимд орж ирээрэй. Саналын томьёолол. Гадаадын зээллэгийн ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлэх тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол.

1.Хуулийн төслийн 5 дугаар зүйлд дор дурдсан агуулгатай хэсэг нэмэх:

5.4.дунд хугацаанд хэрэгжих төслийн орлогоороо хөрөнгө оруулалтын зардлаа бүрэн нөхөх боломжтой, эдийн засгийн үр ашиг бүхий хөгжлийн төсөл, арга хэмжээг нэгдсэн төсөвт нөлөө үзүүлэхгүйгээр санхүүжүүлэх чиглэлийг баримтална. Санал гаргасан Төсвийн байнгын хороо, санал гаргасан ажлын хэсэг. Гишүүд санал хураалтад бэлтгээрэй. Түрүүний томьёоллоор дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт. Санал хураалтад 18 гишүүн оролцсоноос 5 гишүүн дэмжиж, 27,8 хувиар зарчмын зөрүүтэй санал дэмжигдсэнгүй. Санал хураалт явуулж дууслаа.

Хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төсвийн байнгын хорооноос гарах танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн хэн уншиж танилцуулах вэ? Булгантуяа гишүүн унших уу, Булгантуяа гишүүн ойрд уншаагүй байна шүү дээ. Өөр Энхтүвшин, Мөнхсоёл гишүүн. Чуулган дээр уншина. Ганзориг гишүүн уншиж танилцуулна.

12.49 цаг

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан хаасныг мэдэгдье. Гишүүд, ажлын хэсэгт баярлалаа.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ  
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,  
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА